



**ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО**

Үндэсний статистикийн хорооны даргын
2021 оны 10-р сарын 18-ны өдрийн А/167 тоот
тушаалаар батлав.

АЖ АХУЙН НЭГЖИЙН 2021 ОНЫ ТООЛЛОГО

Асуулга нөхөх заавар

УЛААНБААТАР 2021 ОН

АГУУЛГА

ТООЛОГЧ/ШАЛГАГЧ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ	3
АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-1.....	4
1. ХАЯГИЙН ХЭСЭГ.....	4
2. ЕРӨНХИЙ АСУУЛГА.....	6
3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ.....	11
4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020 оны дүнгээр нөхнө	14
5. БИЗНЕСИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХАНДЛАГА (2021 оны эхний 9 сарын байдлаар).....	24
6. ТОЛГОЙ, ОХИН/ХАРААТ КОМПАНИ, ХАМААРАЛ БҮХИЙ НЭГЖ, САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ТОДОРХОЙЛОХ	28
7. ИННОВАЦ, 2018-2021 оны дүнгээр	33
8. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ (2018-2021 оноор).....	44
9. ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ҮР ДҮН (2018-2021 оноор).....	53
ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-2.....	56
1. ХАЯГИЙН ХЭСЭГ	56
2. ЕРӨНХИЙ АСУУЛГА	57
3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ.....	61
4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2020 оны дүнгээр нөхнө)	64
5. ӨГӨГДЛИЙН САН	69
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-3.....	73
1. ХАЯГИЙН ХЭСЭГ	73
2. ЕРӨНХИЙ АСУУЛГА	74
3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ.....	76
4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2020 оны дүнгээр нөхнө)	77
5. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ.....	84
САЛБАР, НЭГЖ,ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР ААНТ-4.....	86
1. ХЯНАЛТЫН ХЭСЭГ	86
2. НЭРИЙН ХЭСЭГ	86
3. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ХАЯГИЙН ХЭСЭГ	87
4. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ДАРГА/ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ	87
5. ХАРЬААЛЛЫН ХЭЛБЭРИЙГ ТОДОРХОЙЛНО УУ	87
6. ТАНАЙХ МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАДАГ УУ?.....	87
7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, 2020 ОНЫ ДҮНГЭЭР	88
8. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, 2020 ОНЫ ДҮНГЭЭР	89
ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР ААНТ-5	89
1. ХАЯГИЙН ХЭСЭГ	89
2. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	90
ХАВСРАЛТ. АНГИЛАЛ, КОД.....	96

ТООЛОГЧ/ШАЛГАГЧ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

Тооллогын мэдээлэл цуглуулалтын ажил эхлүүлэхээс өмнө аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцэл, улсын бүртгэлийн гэрчилгээ, инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэсэн мэдээлэл, холбогдох бичиг баримтыг урьдчилан бэлтгэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлсэн байна. Мөн тооллогын асуулгыг ААН-ийн дарга/эзэн/захирал, ерөнхий менежер, нягтлан бодогч, санхүүгийн ажилтан нь хамтран нөхөх тухай урьдчилан мэдэгдсэн байна.

Тоологч нь уламжлалт аргаар авсан тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж, өөрийн харьяалах тооллогын комисст хүлээлгэж өгнө.

Тоологч/шалгагч гэж тооллогод хамрагдвал зохих аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтад тусгагдсан, өөрт хуваарилагдсан аж ахуйн нэгж, байгууллага, ХХЭ-ийг тооллогод онлайнаар бүрэн хамруулж (тоологч), мэдээллийг баталгаажуулах (шалгагч) чиг үүрэг бүхий ажилтныг ойлгоно. Онлайнаар мэдээлэл цуглуулалт хийсэн тохиолдолд тоологч нь шалгагчийн үүргийг давхар гүйцэтгэнэ гэж ойлгох ба тоологч, шалгагчийн код, хийх үйлдэл ижил байж болно.

Харин аймаг, нийслэл, дүүргийн тооллогын комиссын ажилтан тухайн аж ахуйн нэгжийн мэдээллийг шалгаж, баталгаажуулсан тохиолдолд шалгагчийн нэр, код нь автоматаар баталгаажуулсан хүнийг кодоор програм хангамжид бичигдэнэ.

Тоологч/шалгагчийн чиг үүрэг:

- 1) Тоологч нь өөрт хуваарилагдсан нэгжүүдийг тооллогод цахимаар бүрэн хамруулна. Тоологч нь өдөрт хамгийн багадаа 7-н нэгж, тооллогын хугацаа буюу 1 сарын хугацаанд дунджаар нийт 210 нэгжийг тоолно.
- 2) Тоологч нь тооллогын эхний өдрүүдэд өөрт хуваарилагдсан ААНБ, ХХЭ-тэй холбогдож, тооллогодоо хэрхэн хамрагдах арга замыг зааж өгч, тооллогодоо хамрагдахыг уриална.
 - a. <https://toollogo.1212.mn/> цахим хуудсаар тооллогод хамрагдах тухай мэдээлэл өгнө.
 - b. Урьдчилан бэлтгэх материалын жагсаалтыг хэлж өгнө. Үүнд:
 - i. Аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцэл
 - ii. Улсын бүртгэлийн гэрчилгээ
 - iii. Инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэсэн 2018-2021 оны мэдээлэл, холбогдох бичиг баримт
 - c. Дарга/эзэн/захирал, санхүү, нягтлан бодогч, ерөнхий менежер нь хамтран асуулгыг нөхөх талаар мэдээлэл өгнө.
- 3) Цахимаар тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн үнэн, зөв нөхөгдсөн эсэх болон үзүүлэлт хоорондын үсрэлт зөв байгаа эсэхийг хянаж, ангилал, кодыг шалгаж, шаардлагатай тохиолдолд тодруулга хийж, програм хангамжид өөрчлөлтийг тусгаж баталгаажуулна.
 - a. Дутуу нөхсөн.
 - b. Оронгийн алдаа
 - c. Кодлолтын алдаа гэх мэт.

- 4) Мэдээллээ бүрэн оруулсан нэгжийн мэдээллийг кодлож, баталгаажуулна.
 - a. Эдийн засгийн бүх төрлийн ангилал
 - b. Ажил, мэргэжлийн ангилал
- 5) Асуулгыг дутуу орхисон ААНБ, ХХЭ-рүү холбогдож мэдээллийг нөхүүлэх эсвэл хамтран асуулгыг нөхнө.
- 6) Хуваарилагдсан төлөвтэй нэгжүүдтэй дахин холбогдож, тооллогод хамрагдахыг дахин уриалж, тооллого дуусах хугацааг сануулна.
- 7) Цахимаар хамрагдах боломжгүй ААНБ, ХХЭ-ээс маягтаар авна.
 - a. Интернет ашиглах боломжгүй
 - b. Цахимаар хамрагдахаас татгалзсан.
- 8) Маягтаар авсан мэдээллээ програм хангамжид оруулна.
- 9) Холбогдох боломжгүй, утасны дугаар алдаатай нэгжүүдийн асуудлыг шийдвэрлэж, тооллогод хамруулна.
 - a. орон нутгийн тооллогын комисст хандаж нэмэлт мэдээллийг авна.
 - b. өөр эх үүсвэрээс эрэлхийлнэ (шилэн данс, олон нийтийн сүлжээ гэх мэт...).
- 10) Цаасан асуулгын хуудсыг эмхэлж, цэгцлэн бүртгэлжүүлж, програмтай тулгаж, архивын стандартын дагуу орон нутгийн тооллогын комисст хүлээлгэн өгнө.

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-1

Энэхүү маягтаар зах зээлд борлуулах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй албан ёсны бүртгэлд хамрагдсан хуулийн этгээд /компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн боловсрол, сургалтын байгууллага/-ээс мэдээллийг цуглуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1. Хяналтын хэсэг

Тоологч/шалгагчийн нэр, код: Тоологч/шалгагч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Тоологч/шалгагч дугаараа нөхөхдөө “код” баганын харгалзах нүдэнд байрлуулахад анхаарна. Хэрэв 2 эсвэл 1 оронтой дугаартай бол “001”, “011” гэж өмнөх оронгийн нүдэнд “0” тавьж гүйцээж бичнэ.

1.2. Нэрийн хэсэг

Тухайн аж ахуйн нэгжийн регистрийн дугаар, нэр, үйл ажиллагаа эхэлсэн огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, хариуцлагын хэлбэрийг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө. Мөн энэ хэсэгт аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрийг нөхөх асуулт багтана. Хувийн хамтарсан болон гадаад улсын өмчийн хэлбэртэй бол улсын нэрийг нөхнө. Түүнчлэн үүсгэн байгуулагдсан хэлбэрийг тодорхойлох асуулт байна.

Хариуцлагын хэлбэр

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж, түүнд бичигдсэн байдлаар нь харж нөхнө. Жишээ нь “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн бол ХХК, компани гэж товчилж, үгийг хасаж бичихгүй.

Тохирох кодыг кодлогч “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө. Хариуцлагын хэлбэрийг “хоршоо” гэж нөхсөн бол 2.10-р асуултыг заавал нөхнө.

Гадаадын компани, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээд болж асуулгад хамрагдана.

Өмчийн хэлбэр

Тухайн аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Харин өмчийн хэлбэр нь төрийн хамтарсан бол төрийн өмчийн эзлэх хувийг, орон нутгийн хамтарсан бол орон нутгийн өмчийн эзлэх хувийг, хувийн хамтарсан бол хувийн өмчийн эзлэх хувийг нөхнө. Хувийн хамтарсан болон гадаадын өмчийнх бол гадаад улсын нэрийг нөхнө. Хувийг нөхөхдөө харгалзах 3 нүдэнд нөхнө. Хэрэв хоёр оронтой бол “051” гэж өмнөх оронгийн нүдэнд “0” тавьж гүйцээн бичнэ. Кодлогч тухайн улсын код болон холбогдох бусад кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

- Монгол Улсын *“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”* хуулийн 13 дугаар зүйлд зааснаар *“Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд”* гэнэ.
- Монгол Улсын *“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”* хуулийн 21 дүгээр зүйлийн 1-р хэсэгт зааснаар *“Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд”* гэнэ.
- Монгол Улсын *“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”* хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар *төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулна.*

Үүсгэн байгуулагдсан хэлбэр

Тухайн аж ахуйн нэгжийн хэрхэн үүсгэн байгуулагдсан нөхцөлийг бичнэ. Үүсгэн байгуулагдсан хэлбэрийн тохирох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж кодлогч нөхнө.

Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн байгуулсан болон шинээр үүсгэн байгуулагдсан зэрэг орно.

1.3. Одоо үйл ажиллагаа явуулж буй хаягийн хэсэг

Аж ахуйн нэгжийн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим шуудангийн хаяг /и-мэйл/, цахим хуудас /веб/-ны нэр зэргийг бичнэ. Кодлогч холбогдох кодыг “Асуулга нөхөх заавар”-аас харж нөхөх бөгөөд хэрэв тухайн аж ахуйн нэгж оршин байгаа гудамж, хороолол нь хавсралтад байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй тохиолдолд ҮСХ-нд холбогдож кодолно.

1.4. Аж ахуйн нэгжийн дарга/захирлын мэдээлэл

Аж ахуйн нэгжийн дарга/захирлын мэдээлэл овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг асууж нөхнө.

2. ЕРӨНХИЙ АСУУЛГА

Тооллогын асуулгын энэ хэсэгт үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, үйл ажиллагаа эрхлээгүй шалтгаан, зээл авсан эсэх, зээлийн эх үүсвэр, үйл ажиллагаа явуулдаг байр, газрын эзэмшил, хөрөнгө оруулалттай эсэх, ISO стандарт, хүний нөөцийн дутагдалтай эсэх, шаардлагатай ажил мэргэжил зэрэг асуултууд багтана.

2.1. Үйл ажиллагаа явуулж байгаа эсэх

Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэлтийн байдлыг тодорхойлж тохирох хариултыг сонгоно. Хэрэв улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж нь тооллогын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй бол **үйл ажиллагаа явуулж байна** гэж үзнэ. Тухайлбал, аялал жуулчлал, барилга угсралтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг тооллогод хамруулах хугацаанд улирлын байдлаас хамаарч үйл ажиллагаагаа түр зогсоосон байвал тухайн аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна гэж үзнэ.

“Үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа” буюу “Тийм” гэж сонговол асуулт 2.3-т шилжинэ. Харин “Үйл ажиллагаа явуулаагүй” буюу “Үгүй” гэсэн хариултыг сонгосон тохиолдолд дараагийн асуулт буюу үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг асууна.

2.2. Үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаа хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжээс ямар шалтгааны улмаас үйл ажиллагаагаа явуулаагүй болохыг асууж тохирох хариултыг сонгоно.

“Үйл ажиллагаагаа эхлээгүй” гэдэгт үүсгэн байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаагаа явуулаагүй хуулийн этгээд, түүний салбар нэгжийг ойлгоно.

“Үйл ажиллагаа түр зогссон” гэж 18 сар хүртэлх хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нэгж хамрагдана.

“Үйл ажиллагаа бүрэн зогссон” гэдэгт 18-с дээш сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулаагүй аж ахуйн нэгжийг бүртгэнэ. Энд тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн зэрэг нэгж орно.

Дээрх шалтгаанаас өөр шалтгаантай бол хариултыг **“Бусад”** гэсэн хэсэгт нөхөж бичнэ.

2.3. Танай аж ахуйн нэгж сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан уу?

Тухайн аж ахуйн нэгж сүүлийн 2 жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан эсэхийг асууж, тохирох хариултыг сонгоно. **Тийм** гэж хариулсан бол “1” гэсэн кодыг сонгоод асуулт 2.5-д шилжинэ, харин **Үгүй** гэж хариулсан бол “2” гэсэн кодыг сонгоод дараагийн асуултыг асууна.

2.4. Танайх аж ахуйн нэгжээ татан буулгах хүсэлтэй юу?

Тооллогод хамрагдаж буй аж ахуйн нэгж, байгууллагаас танайх аж ахуйн нэгжээ татан буулгах хүсэлтэй эсэхийг асууж, тохирох хариултыг сонгоно. **Тийм** гэж хариулсан бол “1”, харин **Үгүй** гэж хариулсан бол “2”, **Мэдэхгүй** гэж хариулсан бол “3” гэсэн кодыг сонгоно.

2.5. Аж ахуйн нэгжийн нэрээс өөр үйл ажиллагаа явуулдаг оноосон нэршилтэй юу?

Тухайн аж ахуйн нэгж Улсын бүртгэлийн гэрчилгээнд байгаа хуулийн этгээдийн нэрээс өөр үйлдвэрлэл, үйлчилгээний оноосон нэрийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол **“Тийм”** буюу “1” гэсэн кодыг бичнэ. Харин **“Үгүй”** бол “2” гэсэн кодыг дугуйлна. Тухайлбал : И-март

2.6. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрныхаа эзэмшлийн хэлбэрийг тодорхойлно уу

Асуулгад тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа байрны эзэмшлийн хэлбэрийг аж ахуйн нэгжийн эзэмшлийн, үүсгэн байгуулагчийн эзэмшлийн, түрээсийн, гэртээ, дундын оффис, бусад гэсэн хэлбэрүүдээс тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн кодыг хариултыг сонговол байрны эзэмшлийг тодорхойлж бичнэ. Хэрэв 3, 4, 5, 6 гэсэн кодын аль нэгийг дугуйлсан бол асуулт 2.8-д шилжинэ.

2.7. Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эзэмшлийн хэлбэрийг тодорхойлно уу

Асуулгад тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагаа явуулж байгаа газрын эзэмшлийн хэлбэрийг аж ахуйн нэгжийн эзэмшлийн/ өмчлөлийн, үүсгэн байгуулагчийн эзэмшлийн/ өмчлөлийн, түрээсийн, бусад гэсэн хэлбэрээс тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол газрын эзэмшлийн хэлбэрийг тодорхойлж бичнэ.

2.8. Танай аж ахуйн нэгж гадаадын хөрөнгө оруулалттай юу?

Тухайн аж ахуйн нэгж гадаадын хөрөнгө оруулалттай эсэхийг асууж, **“Тийм”** гэж хариулсан бол “1”, харин **“Үгүй”** гэж хариулсан бол “2”-р хариултыг сонгож асуулт 2.10-т шилжинэ.

2.9. Хөрөнгө оруулалт хийсэн улс, хөрөнгийн эзлэх хувь

Тухайн аж ахуйн нэгжээс хөрөнгө оруулалт хийсэн улсын нэр, хөрөнгийн эзлэх хувийг асууж нөхнө. Хөрөнгийн хувийг асууж нөхөхдөө зөвхөн гадаадын хөрөнгө оруулсан хувийг нөхөж бичнэ. Кодлогч тухайн улсын кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

2.10. Хоршооны үндсэн үзүүлэлтийг нөхнө үү

Тоологч энэ асуулгыг 1.2-р хэсгийн хариуцлагын хэлбэрийг шалгаж “Хоршоо” бол энэ асуулгыг нөхнө. Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгөд үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. Тухайн хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг мянган төгрөгөөр нөхнө. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зөвхөн хувь нийлүүлсэн гишүүдийн хөрөнгийн хэмжээгээр бичих бөгөөд хандив, тусламжаар нийлүүлсэн хөрөнгийг энд оруулахгүй. Хэрэв хоршооны төрөл нь холимог бол “3” гэсэн кодыг сонгоно.

***Хоршооны гишүүдийн тоо** - хоршооны төрлөөс хамааран ялгаатай байна. Тухайлбал, анхан шатны хоршоог 9-өөс доошгүй иргэн, дундын хоршоог 2-оос доошгүй хуулийн этгээд байгуулдаг.*

***Хоршооны төрөл** - 9-өөс доошгүй иргэн нийлж байгуулсан бол анхан шатны хоршоо, дундын хоршоог хоёроос доошгүй хуулийн этгээд байгуулна гэж хуульд заасан байдаг. Хоршоод аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран эрхлэх зорилгоор бусад хоршоо болон хуулийн этгээдтэй хамтран дундын хоршоо байгуулж болно. Дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байх заалттай.*

2.11. Танай аж ахуйн нэгж зээлтэй юу?

Тухайн аж ахуйн нэгжээс зээлтэй эсэхийг асууж, тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 2.13-т шилжинэ. Танай аж ахуйн нэгж зээлтэй юу гэсэн асуулгад өнөөдөр зээлтэй байгаа эсэх асуудал хамаарна.

2.12. Танай аж ахуйн нэгж зээлээ ямар эх үүсвэрээс авсан бэ?

Тухайн аж ахуйн нэгж зээлээ ямар эх үүсвэрээс авсныг тодорхойлно. Банкны зээл, ББСБ, ХЗХ, хувь хүн, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан зэрэг эх үүсвэрийг хамруулна. Дээр дурдсан эх үүсвэрээс бусад эх үүсвэртэй бол “Бусад” гэдэгт дэлгэрэнгүй бичиж, асуулт 2.14-т шилжинэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

2.13. Танай аж ахуйн нэгж зээлд хамрагдаагүй шалтгаан юу вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс зээлд хамрагдаагүй шалтгаан асууж тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол зээлд хамрагдаагүй шалтгааныг дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын код олон сонголттой.

2.14. Танай аж ахуйн нэгж и-баримтын системд холбогдсон уу?

Тухайн аж ахуйн нэгжээс и-баримтын системд холбогдсон эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол “1” гэсэн кодыг сонгоод дараагийн асуултыг асууна. Харин **Үгүй** гэж хариулсан бол “2” гэсэн кодыг сонгоод асуулт 2.16-д шилжинэ.

2.15. Борлуулалтын хэдэн хувьд и-баримт өгдөг вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс нийт борлуулалтын хэдэн хувьд нь и-баримт өгдгийг асууж, хувиар илэрхийлж бичнэ.

2.16. Танай аж ахуйн нэгж тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг уу?

Тухайн аж ахуйн нэгжээс тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол “1” гэсэн кодыг дугуйлаад дараагийн асуултыг асууна. Харин **Үгүй** гэж хариулсан бол “2” гэсэн кодыг сонгоод асуулт 2.18-т шилжинэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан чуулга уулзалтаар 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгыг баталсан. Энэ нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн хөгжлийн тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагаа гэдэгт дараах үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- a. Эдийн засгийн үйл ажиллагаа (ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэх зэрэг),*
- b. Байгаль орчны үйл ажиллагаа (эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний хэмнэлт, усны хэрэглээ, бохир ус, усны нөөцийн нэгдсэн менежментийн арга, усыг дахин ашиглах, усны үр ашиг, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдал, түүний дотор аюултай хог хаягдал, хог хаягдлыг багасгах, дахин ашиглах практик, аюултай химийн бодис ашиглах, үйлдвэрлэх)*
- c. Засаглалын үйл ажиллагаа (материаллаг байдлын үнэлгээ, тогтвортой байдлын стратеги, засаглалын бүтэц, түүний дотор эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудлууд, гол нөлөөлөл, эрсдэл, боломжууд, авилгатай тэмцэх, өрсөлдөөний эсрэг хандлага, арга хэмжээ),*

- d. Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа (хөдөлмөрийн болон эрүүл мэндийн аюулгүй байдлын тусламж, үйлчилгээ; ажиллагчдыг жендерийн тэгш байдлыг хангах; ажиллагчдын сургалтын үйл ажиллагаа; засаглал, ажиллагчдын эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, ажиллагчдын эрх ашгийн хамгаалалт, хамтын гэрээ хэлэлцээрийн хүрээнд явуулсан үйл ажиллагаа)

2.17. Танай аж ахуйн нэгж тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагааны тайлан бичдэг үү?

Тухайн аж ахуйн нэгжээс нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжсэн үйл ажиллагааны талаар тайлан бичдэг эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол "1", харин **Үгүй** гэж хариулсан бол "2" гэсэн кодыг сонгоно.

2.18. Танай аж ахуйн нэгж ISO стандартыг нэвтрүүлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгж ISO стандартыг нэвтрүүлсэн эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол "1"-г сонгоод дараагийн асуултыг асууна. Харин **Үгүй** гэж хариулсан бол "2" гэсэн кодыг сонгоод асуулт 2.20-д шилжинэ.

2.19. ISO стандарт

Тухайн аж ахуйн нэгжийн нэвтрүүлсэн ISO стандартын нэр, стандартыг нэвтрүүлсэн огноо, хүчинтэй хугацаа, хаанаас авсныг асууж дэлгэрэнгүй бичнэ. Авсан байгууллага гэдэгт Стандартчилал хэмжилзүйн газар, ISO стандарт олгодог Олон улсын байгууллагыг хамруулна. Доор дурдаагүй стандартыг нэр зааж оруулж өгөхөд анхаарна.

ISO стандартад дараах стандарт хамаарна. Үүнд:

№	Стандарт
1.	ISO 9001:2015 Quality management system
2.	MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо
3.	ISO 22000:2018 - Food safety management systems
4.	MNS ISO 22000: 2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо.
5.	ISO 14001:2015 Environmental management systems
6.	MNS ISO 14001: 2016 Байгаль орчны менежментийн тогтолцоо.
7.	ISO/IEC 27000:2018 - Information security management systems
8.	MNS ISO 27001: 2021 Мэдээллийн технологи. Аюулгүй байдлын арга техник. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо.
9.	ISO 45001:2018 - Occupational health and safety management
10.	MNS ISO 45001: 2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо
11.	ISO 50001:2018 - Energy management systems
12.	MNS ISO 50001: 2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо
13.	ISO 26000:2010 Guidance on social responsibility
14.	MNS ISO 26000: 2012 Нийгмийн хариуцлагын удирдамж /зөвлөмж /
15.	ISO 31000:2018, Risk management
16.	MNS ISO 31000: 2020 Эрсдэлийн менежмент
17.	ISO/IEC 17025:2017 Testing and calibration laboratories

№	Стандарт
18.	MNS ISO/IEC 17025: 2018 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага

2.20. Нийт ажиллагчдын тоог хэлнэ үү.

Тухайн аж ахуйн нэгжийн одоогийн байдлаарх үндсэн, байнгын ажиллагчдын нийт болон эмэгтэй ажиллагчдын тоог асууж, нөхнө. Ажиллагчдын тоонд цагийн ажилтан, түр ажиллагчдыг оруулахгүй.

2.21. Ажиллагчдаас инженер, техникийн ажиллагчид

Нийт ажиллагчдаас инженер, мэргэжлийн ажилтан, техникийн ажилтан, туслах ажилтны нийт тоо болон эмэгтэй ажиллагчдын тоог тус бүр хэд байгааг нэг бүрчлэн асууж холбогдох нүдэнд нөхнө.

Инженер мэргэжилтэнд дараах мэргэжлүүд хамаарна. Үүнд:

- Аж үйлдвэрийн инженер
- Иргэний барилга байгууламжийн инженер
- Байгаль орчны инженер
- Механикч инженер
- Химийн инженер
- Уул уурхайн инженер, металлургич, холбогдох бусад мэргэжилтэн
- Цахилгааны инженер
- Цахим зүйн инженер
- Телехолбооны инженер

Техникийн ажилтан нь гол төлөв судалгаа шинжилгээ болон хавсарга ухаан, урлаг, үйл ажиллагааны баримтлал, арга техник ашиглах, төр, бизнесийн дүрэм журамтай холбоотой техникийн шинжтэй ажил хийж гүйцэтгэнэ.

Энгийн ажил эрхлэгч нь өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчлон биеийн хүчний ажил эрхэлнэ.

2.22. Танай аж ахуйн нэгжид хүний нөөцийн дутагдал байгаа юу?

Тухайн аж ахуйн нэгжид хүний нөөцийн дутагдал, хэрэгцээ байгаа эсэхийг тодруулан асууж "Тийм" гэсэн бол "1"-г сонгоод дараагийн асуултыг асууна, "Үгүй" гэсэн бол "2"-г сонгоод асуулт 2.25-д үсрэлтүүд шилжинэ.

2.23. Танай аж ахуйн нэгжид ямар мэргэжлийн ажилтан шаардлагатай байна вэ?

Тухайн аж ахуйн нэгжид ямар мэргэжлийн ажилтан шаардлагатай байгааг тодруулан асууж шаардлагатай байгаа ажил, мэргэжлийн нэр болон хүний тоог асууж тохирох нүдэнд нөхнө.

Тухайлбал, англи хэлний багш, япон хэлний багш, тогооч, зөөгч, барилга угсралтын менежер, зочид буудлын менежер, сувилахуйн мэргэжилтэн, яаралтай тусламжийн эмч, үйлчлэгч гэх

зэрэг ажил мэргэжлийн нэрийг дэлгэрэнгүй бичиж, шаардлагатай мэргэжлийн тоог холбогдох нүдэнд бичнэ.

Мэргэжлийн чиглэлийн кодыг 4 оронгийн түвшинд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт” (YAMAM-08)-ын дагуу номоос харж нийслэл, аймгийн тооллогын комиссын гишүүн кодолно.

2.24. Шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаанаа хэлнэ үү

Хүний нөөцийн дутагдалтай тухайн аж ахуйн нэгжээс шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгааныг нь асууж, тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

2.25. Танай аж ахуйн нэгжээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас баримт бичиг, тодорхойлолт шаарддаг уу?

Тухайн аж ахуйн нэгжээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад тусгай зөвшөөрөл, гэрээ, батламж, дүгнэлт, үнэлгээ зэрэг төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг, тодорхойлолт байдаг эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол дараагийн асуултыг асууна, харин **Үгүй, Мэдэхгүй** гэж хариулсан бол асуулт 3.1-т шилжинэ.

2.26. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг, тодорхойлолтыг хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг, тодорхойлолтын нэр болон тоог нөхнө.

Төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг, тодорхойлолтод тусгай зөвшөөрөл, гэрээ, батламж, дүгнэлт, байгаль орчны үнэлгээ гэх мэт төрөл бүрийн баримт бичгүүд хамаарна. Үүнд:

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл” гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг хэлнэ.

Гэрээнд ажил гүйцэтгэх гэрээ, ажлын байр түрээслэх гэрээ, бараа арилжих тухай гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, барьцаат зээлийн гэрээ гэх зэрэг үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн гэрээг хамруулна.

3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

3.1. Танай аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг уу?

Тухайн аж ахуйн нэгжээс үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 3.4-т шилжинэ.

Жишээ нь: Ухаалаг төхөөрөмж гэдэгт смарт дэлгэц, ухаалаг самбар, 3D принтер, AI (хиймэл оюун ухаанд) суурилсан төхөөрөмжүүд (үйлдвэрийн машин, тоног төхөөрмж) орно.

3.2. Ашиглаж байгаа компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоог нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжээс ашиглаж байгаа компьютерын тоог суурин, зөөврийн, таблет, ухаалаг бусад төхөөрөмж гэсэн төрлөөр ялгаж асууна. Бүгд гэдэгт суурин, зөөврийн компьютер, таблет, ухаалаг бусад төхөөрөмжийн тооны нийлбэрийг бичнэ.

3.3. Компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжээс компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.4. Үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг уу?

Тухайн аж ахуйн нэгжээс үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг эсэхийг асууж **“Ашигладаг”** бол **“1”**-г сонгоод дараагийн асуултыг асууна, Харин **“Ашигладаггүй”** бол **“2”**-г сонгоод асуулт 3.8-д шилжинэ.

***Сүлжээ гэдэг нь** агаараар болон кабелин холболтын сувгуудыг ашиглан хэсэг бүлэг компьютер бусад мэдээллийн төхөөрөмжүүдийг (хэвлэгч, камер...) холбосон цогцолбор холболт юм.*

Сүлжээг дараах байдлаар ангилна. Үүнд:

Интранэт гэж интернэт протокол ашиглаж буй дотоод сүлжээний харилцаа холбоо бөгөөд албан байгууллагын доторх зөвшөөрөгдсөн харилцаа холбоо юм.

Интранэт гэж дотоод сүлжээ нь байгууллага доторх мэдээлэл, хамтын ажиллагааны хэрэгсэл, үйлдлийн систем болон бусад тооцооллын үйлчилгээг хуваалцахад зориулагдсан компьютерын сүлжээ бөгөөд ихэвчлэн гаднын хүмүүсийн хандалтыг хориглодог. Интернэт рүү дэлхийн сая сая хүн ханддаг бол интранэтэд зөвхөн тухайн байгууллагын сүлжээний хүмүүс хандана.

Интернэт бол дэлхийн нийтийн компьютерын сүлжээ юм. Энэ нь World Wide Web зэрэг харилцаа холбооны хэд хэдэн үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд ашигласан төхөөрөмжөөс үл хамааран и-мэйл, мэдээ, өгөгдлийн файлуудыг дамжуулдаг.

3.5. Үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжээс үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг асууж интранэт/ дотоод сүлжээ, интернэт гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой. Зөвхөн “а” хариултыг сонгосон тохиолдолд асуулт 4.1-т шилжинэ.

Сүлжээний маш олон төрөл байдаг бөгөөд Personal area network – Хувийн сүлжээ (PAN), Local Area Network – Дотоод сүлжээ (LAN), Campus Area Network – Цогцолборын сүлжээ (CAN), Metropolitan area network – Хотын сүлжээ (MAN) болон Wide area network – Өргөн бүсийн сүлжээ (WAN) гэж ангилдаг.

3.6. Үйл ажиллагаандаа интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоог нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжээс интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.7. Ямар зорилгоор интернэтийг ашигладаг вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс интернэтийг ямар зорилгоор ашигладгийг асууж дараах хариултаас тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол төрлийг дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой. Дараах хариултаас сонгоно:

- Харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх
- Бараа бүтээгдэхүүнийг онлайнаар хүргэх
- И-мэйл авах/явуулах,
- Эд юмс, тоног төхөөрөмж удирдах /Internet of things/
- Мэдээ, мэдээлэл авах, илгээх
 - бараа үйлчилгээний
 - төрийн байгууллагын и-мэйл, веб сайтаар дамжуулан
 - бусад мэдээллийн хайлт болон судалгаанаас
- Интернэт банкны үйлчилгээнд хамрагдах
- Бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдах (мерчантын үйлчилгээ /и-коммерс үйлчилгээ, Qraу үйлчилгээ, pass ухаалаг түрийвч/ гэх зэрэг)
- Төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах
- Бусад

3.8. Танай аж ахуйн нэгж өгөгдлийн сантай юу?

Тухайн аж ахуйн нэгж өгөгдлийн сантай эсэхийг асууж “Тийм” бол “1”-г, “Үгүй” бол “2”-г сонгоно.

Өгөгдлийн сан буюу өгөгдлийн бааз нь зохион байгуулалттайгаар хадгалсан өгөгдлийн цуглуулга юм. Өгөгдлийн санд хандах, засварлах болон нэмэхэд хялбар байдлаар хийгдсэн байдаг. Өгөгдлийн сан нь мэдээлэл хайх, статистик мэдээ гаргаж авахад хялбар байдгаараа давуу талтай.

Өгөгдлийн сан нь нэлээд олон төрөл байдаг. Жишээ нь үйл ажиллагааны, гадаад өгөгдлийн, гипермедиа, өгөгдлийг агуулах зэрэг байна.

3.9. Танай аж ахуйн нэгж дата сервертэй юу?

Тухайн аж ахуйн нэгж дата сервертэй эсэхийг асууж “Тийм” бол “1”-г, “Үгүй” бол “2”-г сонгоно.

Сервер нь байгууллагын мэдээллийг хадгалж байгаа компьютер, тоног төхөөрөмж юм. Сервер нь хүсэлтийг боловсруулах, мэдээллийг бусад компьютер, интернэт эсвэл дотоод сүлжээгээр дамжуулах зорилготой компьютер юм.

3.10. Танай аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын хэдэн хувь нь гэрээсээ цахимаар ажиллах боломжтой вэ?

Тухайн аж ахуйн нэгжийн нийт ажиллагчдын хэдэн хувь нь гэрээсээ цахимаар ажиллах боломжтой эсэхийг асууж хувиар илэрхийлж бичнэ.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020 оны дүнгээр нөхнө

4.1. Танай аж ахуйн нэгж 2020 онд үйл ажиллагаа явуулсан уу?

Тухайн аж ахуйн нэгж 2020 онд үйл ажиллагаа явуулсан эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол "1", харин **Үгүй** гэж хариулсан бол "2" гэсэн кодыг сонгоно. Энэ асуулгад **"Үгүй"** гэж хариулсан тохиолдолд асуулт 4.2, 4.6, 4.7, 4.8-ыг нөхөхгүй.

4.2. Байгаль орчныг хамгаалахад 2020 онд зарцуулсан зардлын хэмжээг нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжийн 2020 онд байгаль хамгаалахад зарцуулсан зардлын хэмжээг асууж мянган төгрөгөөр илэрхийлж нөхнө. Байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, нөхөн сэргээх, байгаль орчныг хамгаалахтай холбогдон гарсан байгаль орчныг хамгаалах менежмент, байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээ, аудит, байгаль орчны стандартыг нэвтрүүлэхтэй холбогдон гарсан зардал, байгаль орчны хохирлын нөхөн төлбөр, торгуульд зарцуулсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг байгаль хамгаалах зардалд хамруулна.

Үйл ажиллагааны зардалд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа ажиллагчдын цалин хөлс болон зарцуулсан түлш шатахуун, цахилгаан эрчим хүч, хангамжийн бараа, материал, үйлчилгээний зардал багтана.

Хөрөнгө оруулалтын зардалд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд зориулан худалдан авсан машин, тоног төхөөрөмж болон түүний суурилуулалтын зардал багтана.

4.3. Танай аж ахуйн нэгж 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжид 2020 онд хийгдсэн хөрөнгө оруулалт байгаа эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Энэ асуулгад **"Үгүй"** гэж хариулсан тохиолдолд асуулт 4.5-д шилжинэ.

4.4. Хөрөнгө оруулалтын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү

Хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, 2020 онд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм. Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- *Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт* гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;

- **Өөрийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;
- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** - Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессын гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мянган төгрөгөөр үнэлж нөхнө. Бусад эх үүсвэрт бусдаас үнэ төлбөргүй авсан оюуны өмчийн хөрөнгө гэх мэт орно. Харин бусад эх үүсвэрт дахин үнэлгээний нэмэгдэл орохгүй.

Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүнг бодож бичнэ.

4.5. Хөрөнгийн үзүүлэлтийг нөхнө үү (элэгдэл хасагдаагүй дүн)

Тухайн аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл хасагдаагүй дүнг бичнэ.

Үндсэн хөрөнгө: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 1-ээс дээш жил давтан эсвэл үргэлжлэн ашиглагддаг хөрөнгийг хэлнэ.

Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг 2020 оны жилийн эхний үлдэгдэл, нэмэгдсэн, хөрөнгө оруулалт, хасагдсан, оны эцсийн үлдэгдлийг элэгдэл хасагдаагүй дүнгээр мянган төгрөгөөр тооцож нөхнө $\text{мөр1} = \text{мөр}(2+3+8+9+14+17+18)$.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга байгууламж, дуусаагүй барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж, өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

1.1 **Орон сууцны барилгад** аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.

1.2 **Бусад барилга, байгууламж** нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ $\text{мөр3} = \text{мөр}(4+5+7)$.

- 1.2.1 **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.
- 1.2.2 **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.
- 1.2.2.1 **Авто замыг** бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.
- 1.2.3 **Газар, хөрс сайжруулалт** нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна.
- 1.3 **Дуусаагүй барилга байгууламжид** хараахан дуусаагүй барилга байгууламжийг хамааруулж ойлгоно.
- 1.4 **Машин, тоног төхөөрөмж** нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ мөр $9 = \text{мөр}(10 \div 13)$.
- 1.4.1 **Тээврийн хэрэгсэл** нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх
- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
 - төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
 - нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
 - усан онгоц, аяны болон спортын завь
 - мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.
- 1.4.2 **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид** цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.
- 1.4.3 **Тавилга, эд хогшилд** албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.
- 1.4.4 **Бусад машин, тоног төхөөрөмжид** ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.
- 1.5 **Биологийн өсөж үрждэг хөрөнгөд** байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. **Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.**
- 1.6 **Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал** нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц,

баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

- Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
- Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;
- Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
- Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
- Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.7 Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилна мөр18=мөр(19+22+25+26). Үүнд:

- 1.7.1 **Судалгаа хөгжүүлэлтийн ажилд** хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. **Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зах зээлийн үнийг** шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.
- **Инновацад** бусдаар гүйцэтгүүлсэн/ худалдаж авсан судалгаа хөгжүүлэлтийн ажил, програм хангамж, мэдээллийн өгөгдлийн сан, худалдаж авсан биет хөрөнгө зэргийг хамруулах ба зах зээлийн үнийг шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.
 - **Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд** газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.
 - **Програм хангамж, мэдээллийн санд** худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан програм хангамж, системийн болон хэрэглээний програм хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол** програм хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, **өөрсдөө боловсруулсан бол** үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд **үйлдвэрлэлийн зардлаар** үнэлнэ. Програм хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ мөр22=мөр(23+24).
 - **Утга зохиол, урлагийн эх бүтээл** нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.

- **Оюуны өмчийн бусад хөрөнгө** дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник, эдийн засгийн үндэслэл

1. Материаллаг эргэлтийн хөрөнгө нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн орно.

2.1 Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2 Хангамжийн материал нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3 Дуусаагүй үйлдвэрлэл нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ $\text{мөр}35 = \text{мөр}(36 \div 38)$.

2.3.1 Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсөж гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2 Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд өсөж үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл болон дуусаагүй барилга байгууламжаас бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4 Бэлэн бүтээгдэхүүнд хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиа, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5 Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

2. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зориулалтаар эзэмшдэг хөрөнгө байна $\text{мөр}35 = \text{мөр}(36 \div 38)$.

3.1 Үнэт металл, үнэт чулуу нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2 Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3 Бусад үнэт зүйлсэд маркийн цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засаж хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

3. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө

Үйлдвэрлэгдэх хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

- Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.
- Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө – Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брэндийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.
 - **Шинэ бүтээл** гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.
 - **Бүтээгдэхүүний загвар** гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.
 - **Ашигтай загвар** гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.
 - **Барааны тэмдэг** гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.
- Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

Хөрөнгийн үзүүлэлтийг нөхөж бичихдээ 2020 оны дүнг 1-р баганад оны эхний үлдэгдлийн дүнг, 2-р баганад оны эхнээс нэмэгдсэн дүнг, 3-р баганад шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтыг, оны эхнээс хасагдсан дүнг 4-р баганад, эцсийн үлдэгдлийн дүнг 5-р баганад харуулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үндсэн хөрөнгө, материаллаг эргэлтийн хөрөнгө, үнэт зүйлийн нийлбэр дүн бичигдэнэ мөр48=мөр(1+27+35+39).

4.6. Нийт орлогыг нөхнө үү.

Тухайн аж ахуй нэгжийн 2020 оны нийт орлогыг орлогын төрөл тус бүрээр мянган төгрөгөөр илэрхийлж нөхнө.

- **Борлуулалтын орлого** -Тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүнг хэлнэ. Борлуулалтын үнийн дүнг онцгой татвар ороогүй үнээр нөхнө. Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлээс нь хамаарч үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, лизингийн хүүгийн орлогыг зохих мөрөнд нөхнө.
- **Өөрийн эцсийн хэрэглээнд зарцуулсан бараа бүтээгдэхүүн** -Өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өөртөө хэрэглэсэн бол түүнийг нийт үйлдвэрлэлийн хэмжээнд оруулж тусгана. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр үнэлнэ. Эсвэл бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын дүнгээр тооцон нийт үйлдвэрлэлд оруулж тооцно.

Жнь: Барилга угсралтын ААН бетон зуурмаг үйлдвэрлээд өөртөө хэрэглэсэн тохиолдолд бетон зуурмагт зарцуулсан зардлын дүнг энд нөхнө.

- **Улсын төсвөөс авсан татаас** -Засгийн газраас аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны түвшин, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, өртөг, борлуулалт, импортыг үндэслэн буцаан төлөх нөхцөлгүйгээр олгодог урсгал төлбөр юм. Жишээ нь: Эрчим хүч, нийтийн тээвэр, улаан буудай татаас. Төсвийн санхүүжилтийг энд оруулахгүй.
- **Үндсэн бус үйл ажиллагааны орлого** -Үндсэн хөрөнгө худалдсаны орлого, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээсэлснээс орсон орлого, ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр, хандив, тусламжийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз зэргийг оруулна.

4.7. Нийт зардлыг нөхнө үү

Тухайн аж ахуй нэгжийн 2020 оны нийт зардлыг зардлын төрөл тус бүрээр мян.төгрөгөөр илэрхийлж нөхнө.

Нийт зардалд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад орц байдлаар зарцуулсан бараа, үйлчилгээний материалын зардал болон үйлчилгээний төлбөрийг хамруулж тооцно мөр38=мөр(1+2+3+28+32+37).

- **Түүхий эд, материалын зардал** нь дахин борлуулахаар биш, харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно.

Жнь: Талх, нарийн боовны үйлдвэрийн түүхий эд, материалын зардал нь гурил, элсэн чихэр, сав баглаа боодол гэх мэт зүйлийн зардлын нийлбэр байна.

- **Дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөг нь** аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын үйлчлүүлэгчдэд борлуулах зорилгоор худалдан авсан бараа байна.

Дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөг нь санхүүгийн тайлангийн борлуулсан барааны өртгөөс ялгаатай. Санхүүгийн тайлангийн борлуулсан барааны өртөгт тухайн ажил, үйлчилгээ явуулахад гарсан бүх зардал багтдаг.

Үүнд: Худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, түүхий эд, материал, тээвэр, түрээс, цалин хөдөлмөрийн зардал, ашиглалтын зардал, засвар үйлчилгээний зардал гэх мэт.

- **Үйлчилгээний зардалд** тухайн аж ахуйн нэгжийн ашиглалтын зардал, бичиг хэрэг, цахилгаан, холбоо, интернэтийн зардал, барилга, байшин, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал гэх зэрэг үйлчилгээний зардлуудыг хамруулна мөр3=мөр(4÷27). Энд бусдаар үйлчлүүлсэн үйлчилгээний зардлын дүнг нөхнө.
- **Нийт цалин хөлс** нь ажиллагчдын цалингийн зардал, ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн шагнал, тусламж, дэмжлэг, аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн

болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хамааруулна. Ажиллагчдын цалингийн нийт зардлаас судалгаа хөгжүүлэлтийн ажил болон инновацын үйл ажиллагаанд оролцсон ажиллагчдын цалингийн зардлыг салгаж харуулна мөр28=мөр(29÷31).

- **Бусад зардал** аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгийн элэгдэл, торгуулийн зардал, хандивын зардал, гадаад валютын ханшийн зөрүүний гарз зэргийг хамруулна мөр32=мөр(33÷36). Татвар, хураамжид бүх төрлийн татвар, хураамж орно. (Үйлчилгээний хураамж орохгүй.)

4.8. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 2020 оны дүнгээр

Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: компьютерын сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэх мэтээр сайтар ялгаж бичнэ. Хэрэв тухайн аж ахуйн нэгж улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэнээс өөр үйл ажиллагаа явуулж байгаа бол явуулж байгаа үйл ажиллагааг нь бичнэ. Жишээ нь: улсын бүртгэлийн гэрчилгээнд “барилга угсралт” гэсэн боловч барилгын материалын жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол тухайн эрхэлж буй үйл ажиллагааг буюу “барилгын материалын жижиглэнгийн худалдаа” гэж дэлгэрэнгүй бичнэ.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл бүрийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн эсвэл борлуулалтын өндөр орлоготой үйл ажиллагааг хуваарилах буюу үйл ажиллагааг ихээх бага руу хуваарилах аргаар (Top-down method) тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC- 4.0 шинэчилсэн хувилбар)-ын дагуу номоос харж нийслэл, аймаг, дүүргийн тооллогын комиссын ажилтан кодолно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, эмэгтэй, гадаад ажиллагчид, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны нийт орлогод эзлэх хувь, нийт зардалд эзлэх хувь, тухайн үйл ажиллагааг эхэлсэн огноог нөхөж, мэдээ, тайлан гаргадаг эсэх, өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэхийг тодруулж, тохирох хариултыг сонгоно. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ хэдэн хувийг өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигладаг талаар тодруулж хувиар илэрхийлж бичнэ.

Ажиллагчдын тоо нь 2020 оны жилийн дундаж тоо байх ба нийт ажиллагчдын тоог багана 2-т, эмэгтэй ажиллагчдын тоог багана 3-т, гадаад ажиллагчдын тоог багана 4-т нөхнө.

Багана 5-д үйл ажиллагааны чиглэл бүрээр тухайн аж ахуйн нэгжээс 2020 онд ажиллагчдаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлыг мянган төгрөгөөр нөхнө. Үүнээс эмэгтэй ажиллагчдын цалинг багана 6-д, гадаад ажиллагчдын цалинг багана 7-д нөхнө. Цалин, түүнтэй адилтгах зардалд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал,

урамшуулал багтана. Цалин, түүнтэй адилтгах зардлын дүн нь 4.7 нийт зардлын хэсгийн нийт цалин хөлс (мөр 27) дүнтэй тэнцүү байна.

Үндсэн цалин - тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.

Нэмэгдэл - ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл байна.

Нэмэгдэл хөлс - ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.

Багана 8, 9-д үйл ажиллагааны чиглэл бүрээр нийт орлогод эзлэх хувь, нийт зардалд эзлэх хувийг нөхнө. Нийт орлого, зардалд эзлэх хувийн дүн 100 хувьтай тэнцүү байна.

Багана 10-т үйл ажиллагааны чиглэл бүрээр үйл ажиллагаа эхэлсэн огноог асуух ба үйл ажиллагаа эхэлсэн огноо нь улсын бүртгэлд бүртгүүлсэн огнооноос өмнө бичиж болохгүй. Тоологч "1.2"-оос улсын бүртгэлд бүртгүүлсэн огноог тулгаж шалгана.

Багана 11-т үйл ажиллагааны чиглэл бүрээр үйл ажиллагааны тайлан гаргадаг эсэх талаар асууж тохирох хариултыг сонгоно.

12-р баганад өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

13-р баганад бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ хэдэн хувийг өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигладгийг асууж, хувиар илэрхийлж нөхнө.

4.9. Танай аж ахуйн нэгжийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хэр байдаг вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс удирдлагын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хэр байдаг талаар тодруулж оролцоог хувиар илэрхийлсэн хариултыг сонгоно.

4.10. Танай аж ахуйн нэгж олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн эсэхийг асууж Тийм гэсэн бол нийлүүлэлтийн сүлжээний нэрийг бичнэ, харин Үгүй бол 2 гэсэн кодыг сонгоно. Тухайлбал, Toyota, Nissan, Shangri-la, Tom N Toms Coffee, Caffè Bene, KFC, CU, Орифлейм, Amway гэх зэрэг нийлүүлэлтийн сүлжээний нэрийг бичнэ.

4.11. Танай аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргадаг уу?

Тухайн аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргадаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Харин Үгүй гэсэн хариултыг сонгосон бол асуулт 4.13-т шилжинэ.

4.12. Танай аж ахуйн экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахдаа санхүүжилтийн эх үүсвэрээ хэрхэн шийдвэрлэж байна вэ?

Тухайн аж ахуйн нэгж экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахдаа санхүүжилтийн эх үүсвэрээ хэрхэн шийдвэрлэж байгаа талаар асууж тохирох хариултыг сонгоно. Тухайлбал, өөрийн хөрөнгөөр, Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр, ОУБ-ын төсөл, хөтөлбөрөөр, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагын зээлээр гэсэн хариултаас сонгоно. Харин хариултад дурдаагүй хариулт хэлсэн бол бусад гэсэн кодыг сонгож хариултыг дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

4.13. Танай аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй юу?

Тухайн аж ахуйн нэгжээс зөвхөн үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжтэй эсэхийг тодруулж асууж тохирох хариултыг сонгоно. **“Тийм”** гэж хариулсан бол “1” гэсэн кодыг сонгоно, **“Үгүй”** гэж хариулсан бол асуулт 4.16-д шилжинэ. Энэхүү асуултыг 4.8-р асуултад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд асууна.

Үйлдвэрлэлд дараах үйл ажиллагааны салбаруудыг хамруулна. Үүнд:

- В. Уул уурхай, олборлолт /0510-0990/
- С. Боловсруулах үйлдвэрлэл /1010-3320/
- D. Цахилгаан, хий, уур, агааржуулалт /3510-3530/
- E. Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /3600-3900/
- F. Барилга /4100-4390/

4.14. Та аж ахуйн нэгжийнхээ үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлыг хэлнэ үү.

Тухайн аж ахуйн нэгжээс үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлыг асууж хүчин чадлын хэмжээ болон хэмжих нэгжийг холбогдох нүдэнд нөхнө. Тоног төхөөрөмж тус бүрээр хэлнэ. Суурилагдсан хүчин чадал гэдэгт тухайн үйлдвэрийн хамгийн их бүтээгдэхүүн үйлдвэрлэх жилийн хэмжээг ойлгоно. Жнь: А гурлын үйлдвэр нь хамгийн ихдээ өдөрт 30тонн, жилд 6000 тонн гурил үйлдвэрлэх боломжтой бол 4.14-т хүчин чадлыг 6000, хэмжих нэгжийг тонн гэж бичнэ.

4.15. Суурилагдсан хүчин чадлын хэдэн хувийг ашигласан бэ?

Тухайн аж ахуйн нэгжээс үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадлынхаа хэдэн хувийг 2020 онд болон 2021 оны эхний 9 сард ашигласныг асууж хариултыг хувиар илэрхийлж бичнэ.

4.16. Үйлдвэрлэлд ашиглаж буй үндсэн түүхий эдийн эх үүсвэрийг хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлд ашиглаж буй үндсэн түүхий эдийн эх үүсвэрийг тодруулан асууж, дотоод, гадаадаар ангилан хувиар илэрхийлж холбогдох нүдэнд нөхнө. Дотоод, гадаад эх үүсвэрийн нийлбэр 100 хувьтай тэнцүү байна.

4.17. Танай үйлдвэрлэлийн ажлын байрны талбайн хэмжээ хэд вэ?

Тухайн аж ахуйн нэгжийн зөвхөн үйлдвэрлэл явуулж буй нэгжийн талбайн хэмжээг тодруулан асууж холбогдох нүдэнд тохирох хариултыг метр квадратаар бичнэ.

Үйлдвэрлэлийн нэгжийн талбайн хэмжээг дараах үйл ажиллагааны салбаруудын үйл ажиллагааны хувьд асууна. Үүнд:

- С. Боловсруулах үйлдвэрлэл /1010-3320/
- D. Цахилгаан, хий, уур, агааржуулалт /3510-3530/

5. БИЗНЕСИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХАНДЛАГА (2021 оны эхний 9 сарын байдлаар)

5.1. Танай аж ахуйн нэгжийн 2021 оны санхүүгийн байдлыг өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад ямар байсан бэ?

Тухайн аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын санхүүгийн байдал /хөрөнгө, авлага, өр төлбөр/-ыг өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад ямар байсныг тодруулан асууж тохирох хариултыг сонгоно.

“Санхүүгийн байдал” буюу **“Хөрөнгө”** өмнөх оны мөн үетэй харьцуулахад ямар байгааг асууж, **“нэмэгдсэн, хэвийн, буурсан, мэдэхгүй”** гэсэн хариултаас, **“Авлага”, “Өр төлбөр”** ямар байгааг **“байхгүй, нэмэгдсэн, буурсан, мэдэхгүй”** гэсэн хариултаас тус тус сонгоно.

5.2. Танай аж ахуйн нэгж нийт хүчин чадлынхаа хэдэн хувийг 2021 оны эхний 9 сард ашигласан бэ?

Тухайн аж ахуйн нэгж нийт хүчин чадлынхаа хэдэн хувийг 2021 оны эхний 9 сард ашигласан талаар асууж, хувиар илэрхийлж бичнэ.

Тухайн ААН-ийн ашиглах боломжтой нийт хүчин чадал гэдэг нь ажиллах хүч, тоног төхөөрөмж, үйлчилгээ, хүний нөөц зэрэг бүхий л хүчин чадлыг хамруулж ойлгоно.

5.3. Танай аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Тухайн аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын дараах бизнесийн үйл ажиллагааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдсөн эсэхийг нэг бүрчлэн асууна.

- Үйлдвэрлэл/ үйлчилгээний хэмжээ
- Орлого
- Алдагдал
- Хэрэглэгчдийн захиалга
- Экспортын хэмжээ
- Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл
- Ажиллагчдын тоо

Хэрэв **Тийм** гэж хариулсан бол “1”-г сонгоод өссөн, буурсан эсэхийг асууж, хариултын кодоос тохирох хариултыг сонгож нөхнө. Харин **Үгүй** бол “2”-г сонгоно.

- 1 - 10 хүртэл хувь
- 2 - 10-19 хувь
- 3 - 20-49 хувь
- 4- 50 ба түүнээс дээш хувь

5.4. Танай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн зардал өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Тухайн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээний дараах үндсэн зардал өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад өөрчлөгдсөн эсэхийг зардлын төрөл бүрээр асууна.

- Түүхий эд, материалын зардал
- Цалингийн зардал, НДШ
- Татвар, төлбөр, хураамж
- Маркетинг, зар сурталчилгааны зардал
- Зээлийн хүүгийн зардал
- Түрээсийн зардал
- Тээвэр, шатахууны зардал
- Шуудан холбооны зардал
- Тусгай зөвшөөрөл, лицензийн зардал
- Бусад зардал

Хэрэв **Тийм** гэж хариулсан бол “1”-г сонгоод өссөн, буурсан эсэхийг асууж, хариултын кодоос тохирох хариултыг сонгож нөхнө. Харин **Үгүй** бол “2”-г сонгоно.

- 1 - 10 хүртэл хувь
- 2 - 10-19 хувь
- 3 - 20-49 хувь
- 4- 50 ба түүнээс дээш хувь

5.5. Танай аж ахуйн нэгж ирэх онд бизнесийн үйл ажиллагаандаа ямар үр дүнг хүлээж байна вэ?

Тухайн аж ахуйн нэгж ирэх онд бизнесийн үйл ажиллагаандаа ямар үр дүнг хүлээж байгааг асууж Хэвийн байна, сайжирна, муудна гэсэн хариултаас сонгож хувиар илэрхийлж бичнэ.

5.6. Цаашид танай аж ахуйн нэгжийн бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистой вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс цаашид бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистойг асууж тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой бөгөөд дараах хариултаас **хамгийн чухал гурван хариултыг** холбогдох нүдэнд эрэмбэлж нөхнө:

- Авилга, хүнд суртлыг бууруулах
- Албан зөвшөөрлийн хураамжийн хэмжээг бууруулах
- Банк, санхүүгийн байгууллагын зээлийн хүүг бууруулах
- Дэд бүтцийг сайжруулах
- Зөвшөөрөл /лиценз/-ийн тоог багасгах
- НДШ-ийн иргэдээс авах хувь хэмжээг бууруулах
- Төрөөс хийгдэж буй хяналт шалгалтын тоог бууруулах
- Төрөөс хийгдэж буй хяналт шалгалтын давхардлыг арилгах
- Татварын таатай орчин бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох
- Үндэсний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих
- Хууль, эрх зүйн орчныг сайжруулах
- Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломж бүрдүүлэх

5.7. Танай аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал яаж нөлөөлсөн бэ?

Тухайн аж ахуйн нэгжийн 2021 оны эхний 9 сарын үйл ажиллагаанд Ковид-19 цар тахал яаж нөлөөлснийг асууж “Эерэг”, “Сөрөг”, “Огт нөлөөлөөгүй” гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно.

5.8. Танай аж ахуйн нэгж хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хэрхэн явуулсан бэ?

Тухайн аж ахуйн нэгж **хатуу хөл хорионы үед** үйл ажиллагаагаа хэрхэн явуулж байсныг асууж “Хэвийн явуулж байсан” гэсэн бол “1”-г, “Зайнаас ажиллаж байсан” гэвэл “2”-г, “Хязгаарлагдмал хүрээнд ажиллаж байсан” гэвэл “3”-г, “Бүрэн зогссон гэвэл” “4”-г тус тус сонгож дараагийн асуултыг асууна.

5.9. Танай аж ахуйн нэгжийн бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээл юу вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс хатуу хөл хориотой холбоотой бизнест үүссэн хүндрэл бэрхшээлийг асууж тохирох хариултыг сонгоно. Хэрэв хариултын сонголтод дурдаагүй хариулт хэлсэн бол “бусад” гэсэн хэсэгт хариултыг дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын

олон сонголттой бөгөөд **хамгийн чухал гурван хариултыг** дараах үзүүлэлтээс холбогдох нүдэнд эрэмбэлж нөхнө.

- Ажлын байраа хадгалах
- Ажиллагчдын цалин тавих
- Төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал
- Түүхий эдийн олдоц
- Зээлийн эргэн төлөлт
- Түрээсийн төлбөр
- Гадаад түншийн гэрээний үүрэг биелүүлэхгүй байх, гэрээ цуцлагдах
- Үйл ажиллагааны зөвшөөрөл авах процесс
- Тээврийн хэрэгслийн хязгаарлалт
- Дэлгүүр, үйлчилгээний цагийн хязгаарлалт
- Халдвар, хамгааллын хувцас, хэрэглэл.

5.10. Бизнесийн үйл ажиллагаа, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээнд хамрагдсан уу?

Тухайн аж ахуйн нэгжээс бизнесийн үйл ажиллагаа, ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор төр засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээнд хамрагдсан эсэхийг нэг бүрчлэн асууж, **Тийм** бол “1”-г, **Үгүй** бол “2”-г тус тус сонгоно. Үүнд:

- НДШ тэглэх
- 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой ААНБ-аас ААНОАТ-аас чөлөөлөх
- Ажлын байраа хадгалж байгаа ААНБ-ын ажилтнуудад сар бүр 200000 төгрөгийн дэмжлэг олгох
- Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд идэвхжүүлэх
- Зээл, зээлийн хүүгийн төлөлтийг хойшлуулах
- Ноос, ноолуурын урамшуулал олгох
- Ажлын байрыг хадгалах 3%-ийн хүүтэй зээл олгох
- Аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, усны төлбөрийг төрөөс даах (хөнгөлөх)

Хэрэв хариултын сонголтод дурдаагүй хариулт хэлсэн бол “бусад” гэсэн хэсэгт хариултыг дэлгэрэнгүй бичнэ.

5.11. Танай аж ахуйн нэгж өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах боломжтой хугацааг хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгж өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах боломжтой хугацааг асууж 1 сар хүртэл, 1-3 сар, 4-6 сар, 7 сар-1 жил, 1 жилээс дээш гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно.

5.12. Ажиллагчдын цалингийн хэмжээг хатуу хөл хорионы үед өөрчилсөн үү?

Хатуу хөл хорионы үед тухайн аж ахуйн нэгж ажиллагчдын цалингийн хэмжээг өөрчилсөн эсэхийг асууж “Өөрчлөлт оруулаагүй гэвэл “1”-г, “Цалингийн хэмжээг бууруулсан” гэвэл хэдэн хувиар буурсаныг тодруулж, 0-25 хувиар буурсан бол “2”-г, 25-50 хувиар бууруулсан бол “3”, 50 ба түүнээс дээш хувиар бууруулсан бол “4”-г, “Цалин олгоогүй” гэвэл “5”-г, “Зөвхөн ажилласан өдрөөр тооцсон” гэвэл “6” гэсэн кодыг тус тус сонгоно. Бусад гэдгийг сонгосон бол хариултыг дэлгэрүүлж нөхнө.

5.13. Танай аж ахуйн нэгжийн мөнгөн хөрөнгийн нөөцийн хүрэлцээтэй хугацааг хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжийн мөнгөн хөрөнгө (эргэлтийн хөрөнгө)-гийн нөөц ямар хугацаанд хүрэлцээтэй байгаа талаар асууж 1 сар хүртэл, 1-3 сар, 4-6 сар, 7 сар-1 жил, 1 жилээс дээш гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно.

6. ТОЛГОЙ, ОХИН/ХАРААТ КОМПАНИ, ХАМААРАЛ БҮХИЙ НЭГЖ, САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫГ ТОДОРХОЙЛОХ

Энэ хэсгийн мэдээлэлд үндэслэн толгой, охин/хараат компани болон хамаарал бүхий хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газрыг тодорхойлно. Хамаарал бүхий хуулийн этгээд гэж хууль эрх зүйн болон/эсвэл санхүүгийн хувьд хоорондоо уялдаа холбоотой хуулийн этгээдүүдийн нэгдлийг ойлгоно.

- **Толгой компани** (Харьяалах дээд байгууллага) нь аж ахуйн нэгжийн хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан хуулийн этгээд юм.
- **Монгол Улсын иргэдийн байгуулсан:** Монгол Улсад үйл ажиллагаа явуулахаар Монгол Улсын иргэний байгуулсан хуулийн этгээдүүдээс бүрдсэн группийг ойлгоно.
- **Дотоодын удирдлага/хяналттай:** Монгол Улсад төвтэй бүлгийн толгой компаниар удирдуулдаг хил дамнасан группийг ойлгоно.
- **Гадаадын удирдлага/хяналттай:** Монгол Улсаас өөр улсад төвтэй толгой хуулийн этгээдээр удирдуулдаг хил дамнасан группийг ойлгоно.

6.1. Танай аж ахуйн нэгж толгой, охин/хараат компани, хамаарал бүхий хуулийн этгээд, салбар төлөөлөгчийн газартай юу?

Аж ахуйн нэгж толгой, охин/хараат компани, хамаарал бүхий хуулийн этгээд, салбар төлөөлөгчийн газартай эсэхийг асууж **Тийм** гэж хариулсан бол толгой, охин/хараат компани, хамаарал бүхий хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газрын мэдээллийг 6.15, 6.16-р асуултад заавал нөхөж бичнэ.

6.2. Танай аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад бүртгэлтэй өөр аж ахуйн нэгж байгаа юу?

Танай аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад бүртгэлтэй өөр аж ахуйн нэгж байгаа эсэхэд тухайн аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас дээш хувийг өөр аж ахуйн нэгж эзэмшдэг бол **"Тийм"** гэж хариулсан бол аж ахуйн нэгжийг удирдаж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг 6.15, 6.16-р асуултад заавал нөхөж бичих ба **"Үгүй"** бол асуулт 6.4-т шилжинэ.

6.3. Танай аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад бүртгэлтэй өөр аж ахуйн нэгж нь шийдвэр гаргах түвшинд танай аж ахуйн нэгжийг удирдах эрхтэй юу?

Аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж нь тухайн аж ахуйн нэгжийг шийдвэр гаргах түвшинд удирдах эрхтэй бол **"Тийм"** гэж хариулах ба 6.15, 6.16-р асуултад тухайн аж ахуйн нэгжийг удирдаж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг бичнэ.

6.4. Танай аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас доош хувийг эзэмшдэг ч шийдвэр гаргах түвшний удирдах эрхтэй Монгол Улсад бүртгэлтэй өөр аж ахуйн нэгж байгаа юу?

Танай аж ахуйн нэгжийн хувьцааны 50-иас доош хувийг эзэмшдэг ч шийдвэр гаргах түвшний удирдах эрхтэй Монгол Улсад бүртгэлтэй өөр аж ахуйн нэгж байгаа юу гэсэн асуултад **"Тийм"** бол танай аж ахуйн нэгжийг удирдаж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг 6.15, 6.16-р асуултад заавал нөхөж бичнэ.

6.5. Танай аж ахуйн нэгжийн хувьцааг шууд эзэмшдэг, шийдвэр гаргах түвшний удирдах эрхтэй гадаад улсын аж ахуйн нэгж байгаа юу?

Аж ахуйн нэгжийн хувьцааг шууд эзэмшдэг, шийдвэр гаргах түвшний удирдах эрхтэй гадаад улсын аж ахуйн нэгж байгаа бол **"Тийм"** гэж хариулах ба 6.15, 6.16-р асуултад тухайн аж ахуйн нэгжийг удирдаж буй аж ахуйн нэгжийн мэдээллийг бичнэ.

6.6. Танай аж ахуйн нэгжийг шууд бусаар шийдвэр гаргах түвшинд удирдах эрхтэй 6.5-р асуултад тусгагдсанаас өөр хэд хэдэн улс оронд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгаа юу?

Танай аж ахуйн нэгжийг шууд бусаар шийдвэр гаргах түвшинд удирдах эрхтэй 6.5-р асуултад тусгагдсанаас өөр хэд хэдэн улс оронд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгаа бол **"Тийм"** гэж хариулах бол тухайн аж ахуйн нэгжийг 6.15, 6.16-р асуултад хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн мэдээллийг бичнэ.

6.7. Танай аж ахуйн нэгжийн хараат/охин хуулийн этгээд хилийн чанадад байгаа юу?

Энэ асуултад хараат/охин эсвэл хилийн чанадад байгаа аж ахуйн нэгжийн мэдээллийг бичих ба гадаадтай хамтарсан аж ахуйн нэгжийг хараат гэж үзэхгүй.

6.7a. Асуулт 6.1-6.7-д “Үгүй” гэж хариулсан эсэхийг шалгах

Асуулт 6.1-6.7-д “Үгүй” гэж хариулсан эсэхийг шалгана. Тийм бол асуулт 7.1-д шилжинэ, Үгүй бол дараагийн асуултыг асууна.

6.8. Танай аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг өөр нэг хуулийн этгээд удирддаг уу?

Тухайн аж ахуйн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг өөр хуулийн этгээд удирддаг эсэхийг асууж тохирох асуултыг сонгоно.

6.9. Танай аж ахуйн нэгж нь хамаарал бүхий бусад нэгжээс санхүүждэг үү?

Тухайн аж ахуйн нэгжээс хамаарал бүхий бусад нэгжээс санхүүждэг эсэхийг асууж, Тийм-1, Үгүй-2 гэж бичнэ.

6.10. Танай аж ахуйн нэгж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг үйлдвэрлэлийн хүчин зүйлээ хамаарал бүхий бусад нэгжүүдтэй хамтран ашигладаг уу?

Тухайн аж ахуйн нэгжээс үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг үйлдвэрлэлийн хүчин зүйлээ хамаарал бүхий бусад нэгжүүдтэй хамтран ашигладаг эсэхийг асууж тохирох хүчин зүйлүүдээс сонгоно. Хэрэв хариултын сонголтод байхгүй хүчин зүйл дурдсан тохиолдолд бусад гэсэн хэсэгт дэлгэрэнгүй бичнэ.

Тухайн ААН-ийн ашиглах боломжтой нийт хүчин чадал гэдэг нь ажиллах хүч, тоног төхөөрөмж, үйлчилгээ, хүний нөөц зэрэг бүхий л хүчин чадлыг хамруулж ойлгоно.

6.11. Үйл ажиллагаанд ашиглаж буй үйлдвэрлэлийн хүчин зүйлээ(нөөцөө) өргөжүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс үйл ажиллагаанд ашиглаж буй үйлдвэрлэлийн хүчин зүйлээ (нөөцөө) өргөжүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэдгийг асууж өөрсдөө бүрэн шийдвэрлэдэг, хязгаарлагдмал байдлаар, бусад нэгжээс хамааралтай гэсэн хариултаас тохирохыг сонгоно.

6.12. Танай аж ахуйн нэгжийн хамаарал бүхий нэгж нэг бэлтгэн нийлүүлэгчтэй юу?

Тухайн аж ахуйн нэгжээс хамаарал бүхий нэгжүүд нэг бэлтгэн нийлүүлэгчтэй эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

6.13. Танай аж ахуйн нэгж бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээний нөхцөлийг чөлөөтэй сонгодог уу?

Тухайн аж ахуйн нэгжээс бэлтгэн нийлүүлэгчтэй хийх гэрээний нөхцөлийг чөлөөтэй сонгодог эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

6.14. Танай аж ахуйн нэгжийн хамаарал бүхий нэгж нэг хэрэглэгчидтэй юу?

Тухайн аж ахуйн нэгжээс хамаарал бүхий нэгж дундаа нэг хэрэглэгчидтэй эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

6.15. Толгой, охин/хараат, харилцан хамаарал бүхий хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газрын хаягийн мэдээлэл

Тухайн аж ахуйн нэгж дотоодод болон гадаадад салбар, төлөөлөгчийн газар, охин/хараат, толгой компанитай нөхцөлд гадаад, дотоодын салбар, төлөөлөгчийн газар, охин/хараат, толгой компанийн мэдээллийг нөхнө. Хэрэв тухайн аж ахуйн нэгж нь олон салбар, төлөөлөгчийн газар, охин/хараат компанитай бол нэмэлт хуудас оруулна.

Үүнд гадаадын аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар хамаарахгүй. Тэдгээрийг бие даасан аж ахуйн нэгж гэж үзэн үндсэн асуулгын хуудаснаас нөхүүлнэ.

Тоологч Толгой -1, охин/хараат -2, хамаарал бүхий аж ахуйн нэгж -3, салбар -4, төлөөлөгчийн газар -5 гэсэн тохирох кодыг сонгож асуулгыг нөхнө.

Толгой, охин/хараат, хамаарал бүхий хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газрын мэдээллийг мөрөнд жагсаан бичнэ. Үүнд регистрийн дугаар, нэр, хаягийн мэдээлэл, утасны дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноо гэсэн үзүүлэлт байна. Хаягийн хэсэгт улс, аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хорооны нэрийг нөхөх ба "Хаяг" гэсэн баганад гудамж, хорооллын нэр, байр/ байшин, хашаа/хаалганы дугаарыг нөхнө.

- **Толгой компани** (Харьяалах дээд байгууллага) нь аж ахуйн нэгжийн хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан аж ахуйн нэгж байна..
- Монгол Улсын "Компанийн тухай" хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 1-р хэсэгт заалтын дагуу **Хараат компани** нь компанийн нийт энгийн хувьцааны 20-50 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж

байгаа тохиолдолд уг компанийг хэлнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг аж ахуйн нэгж байна.

- Монгол Улсын "Компанийн тухай" хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 2-р хэсэгт зааснаар **"Охин компани"** нь компанийн нийт энгийн хувьцааны 50-с дээш (51-100) хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан аж ахуйн нэгж байх бөгөөд охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.
- Монгол улсын "Компанийн тухай" хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар **"Салбар"** нь толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.
- **Нэгж** – салбар болон төлөөлөгчийн газар болж чадахгүй, үндсэн аж ахуйн нэгжээс өөр газар үйл ажиллагаа явуулж буй (уурхай, мод бэлтгэл гэх мэт) нэгжийг хамруулж ойлгоно.
- **Салбар** нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан толгой компанийн нэрийн өмнөөс явуулах ба толгой компани нь өөрийн салбар компанийн хүлээх үүргийг хариуцна.

Салбарын охин/хараат компаниас ялгагдах онцлог нь аж ахуйн нэгжийн эрхийг эдлэхгүй. Харин түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.

- **Төлөөлөгчийн газар** нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

1-7-р баганад толгой, охин/хараат, хамаарал бүхий аж ахуйн нэгж, салбар, төлөөлөгчийн газрын регистрийн дугаар, нэр, улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо болон хаяг, утасны дугааруудыг нөхөж бичнэ.

8-р баганад үйл ажиллагаа эхэлсэн огноог бичнэ.

9-р баганад охин, хараат компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хувиар бичнэ.

10-р баганад охин, хараат компани нь удирдлага/хяналтын төрлийг асууж, "Шууд-1"; "Шууд бус-2" гэж үзнэ. Шууд болон шууд бус холбоо хамаарал байхгүй бол "Үгүй-0" гэж тэмдэглэнэ.

11-р баганад групп компанид нэгдсэн огноог асууж, бичнэ.

6.16. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 2020 оны дүнгээр

Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг, 2020 оны дүнгээр нөхнө.

Тухайн байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж салбар -1, төлөөлөгчийн газар -2 гэсэн тохирох кодыг сонгож асуулгыг нөхнө.

Салбар, төлөөлөгчийн газрын регистрийн дугаар, нэр, үйл ажиллагааны чиглэлийн нэр, код, ажиллагчдын тоо, түүнээс эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлого /мянган төгрөг/, тухайн үйл ажиллагааны чиглэл,

салбар нэгжийн түвшинд нягтлан бодох бүртгэл (НББ)-ийг хөтөлдөг эсэх гэсэн үзүүлэлтүүд байна. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нэрийг дэлгэрэнгүй нөхнө. Жишээ нь: компьютерын сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номоос харж нийслэл, аймаг, дүүргийн тооллогын комиссын гишүүн кодолно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогыг нөхөж бичнэ. Салбаруудын 3-7-р баганын үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогын дүнг БҮГД мөрөнд нэгтгэж бичнэ.

7. ИННОВАЦ, 2018-2021 оны дүнгээр

Инновац гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг ойлгоно.

Шинэ мэдлэг гэж шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээл юм.

Бүтээгдэхүүний инновац гэж аж ахуйн нэгжийн зах зээлд өмнө үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулж эсвэл цоо шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг НЭВТРҮҮЛСНИЙГ хэлнэ.

7.1. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд шинээр эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг нэвтрүүлсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний инновац нэвтрүүлсэн бол “1” гэсэн кодыг дугуйлна.

7.2. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд бизнесийн үйл явцын инновац нэвтрүүлсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

Бизнесийн үйл явцын инновац гэдэг нь аж ахуйн нэгжийн ашиглаж байсан өмнөх бизнесийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай буюу нэг юм уу хэд хэдэн бизнесийн үйл ажиллагааг сайжруулсан эсвэл шинээр бий болгож аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд НЭВТРҮҮЛЖ ашиглахыг хэлнэ.

Бизнесийн үйл явцын инновацыг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. **Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл** - Үйлдвэрлэлийг дэмжих инженерийн болон холбогдох техникийн туршилт, дүн шинжилгээ, баталгаажуулалтын үйл ажиллагаа зэрэг орцыг бараа, үйлчилгээ болгон хувиргах үйл ажиллагаа
2. **Түгээлт, логистик** - Тээвэрлэлт, хүргэлтийн үйлчилгээ, агуулах болон захиалгыг бэлтгэх үйл ажиллагааг оруулна.
3. **Маркетинг борлуулалтын үйл ажиллагаа** –
 - Зар сурталчилгаа (бүтээгдэхүүний урамшуулал, байршуулалт, бүтээгдэхүүний савлагаа), маркетинг (телемаркетинг), үзэсгэлэн, яармаг, зах зээлийн судалгаа, шинэ зах зээлийг хөгжүүлэх бусад үйл ажиллагаа,
 - Үнийн стратеги, арга хэрэгсэл,
 - Хэрэглэгчдэд үйлчлэх төв зэрэг борлуулалтын үеийн болон борлуулалтын дараах үйл ажиллагаа
4. **Мэдээлэл, харилцаа холбооны систем - Мэдээлэл, харилцаа холбооны системийн засвар үйлчилгээ, хангамж орно. Нарийвчилбал,**
 - Техник хангамж, програм хангамж
 - Мэдээлэл боловсруулалт, мэдээллийн сан
 - Засвар үйлчилгээ
 - Цахим хуудас ажиллуулах болон бусад компьютертэй холбоотой мэдээллийн үйл ажиллагаа
5. **Зохион байгуулалт, менежмент** - Дараах үйл ажиллагаанууд хамаарна. Үүнд:
 - Бизнесийн стратегийн болон ерөнхий удирдлага (салбар дундын шийдвэр гаргалт, ажлын хариуцлагыг зохион байгуулах)
 - Байгууллагын засаглал (дүрэм, журам, төлөвлөлт, олон нийттэй харилцах)
 - Нягтлан бодох бүртгэл, аудит, төлбөр тооцоо болон бусад санхүүгийн эсвэл даатгалын үйл ажиллагаа
 - Хүний нөөцийн удирдлага (сургалт, хүний нөөцийн бүрдүүлэлт, ажлын байрны зохион байгуулалт, цалингийн менежмент)
 - Худалдан авалт
 - Ханган нийлүүлэгчид болон холбоонууд гэх мэт гадаад харилцааг удирдах.
6. **Бүтээгдэхүүн болон бизнесийн үйл явцын хөгжүүлэлт** - Бизнесийн хамрах хүрээг тодорхойлох, хөгжүүлэх, нэвтрүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагаа

7.3. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд дараах инновацын үйл ажиллагааг хөгжүүлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд дараах инновац үйл ажиллагааг хөгжүүлсэн эсэхийг асууж, “Тийм” бол “1”-г, “Хийгдэж байгаа” бол “2”-г, “Үгүй” бол “3”-ыг сонгоно.

Инновацын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаанууд хамаарна. Үүнд:

- Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үйл ажиллагаа
- Инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа
- Маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаа
- Оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагаа
- Ажиллагчдыг сургах үйл ажиллагаа
- Програм хангамж, мэдээллийн өгөгдлийн санг хөгжүүлэх үйл ажиллагаа

- Биет хөрөнгийг худалдаж авах, түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Инновацийн менежментийн үйл ажиллагаа
- **Инновацийн үйл ажиллагаа** гэдэгт ААНБ-ууд инновацыг хөгжүүлж үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлсэн хөгжүүлэлтийн, санхүүгийн болон худалдааны үйл ажиллагаануудыг ойлгоно.

Инновацийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж гэж тайлант хугацаанд нэг эсвэл хэдэн үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор шинэ, сайжруулсан бүтээгдэхүүн эсвэл бизнесийн үйл явц хөгжүүлснийг хэлнэ. Инновацийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг болон эрхэлдэггүй аж ахуйн нэгж нь инновацын үйл ажиллагааг тайлант хугацаанд явуулсан байж болно.

Судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэх, байгаа мэдлэгийн хэрэглээг бий болгох зорилгоор хийсэн бүтээлч, системтэй ажил юм.

Судалгаа, хөгжүүлэлтийн ажил нь 5 шалгуурыг хангасан байх ёстой (Frascati manual 2015)

1. Шинэлэг (novel)
2. Бүтээлч (creative)
3. Тодорхойгүй үр дүнг шийдвэрлэх (address an uncertain outcome)
4. Системчилсэн (systematic)
5. Шилжүүлж болох/ хуулбарлах боломжтой (transferable and/ or reproducible)

Судалгаа, хөгжүүлэлт нь

- Суурь судалгаа (мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг)
- Хэрэглээний судалгаа (харьцангуй практикт чиглэгддэг)
- Туршилтын хөгжүүлэлт (бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцыг сайжруулах эсвэл шинээр бий болгоход чиглэгддэг)-ээс бүрдэнэ.

Бусад бизнесийн байгууллагаар гүйцэтгүүлсэн болон төлбөр төлсөн бүх төрлийн судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлсэн гэж үзнэ.

Инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа:

Инженерчлэл нь үйлдвэрлэл болон чанарын хяналтын журам, арга, стандартыг хамардаг. Үйл ажиллагаанууд нь бараа, үйлчилгээ, үйл явц, системийн техникийн үзүүлэлтүүдийг төлөвлөх, турших, үнэлэх, тохируулах буюу үйлдвэрлэхээс өмнөх үйл ажиллагааг багтаана. Мөн тоног төхөөрөмж суурилуулах, багаж хэрэгсэл бэлтгэх, турших, туршилт хийх, хэрэглэгчдэд үзүүлэх; одоо байгаа бүтээгдэхүүн, технологийн тоног төхөөрөмжөөс мэдээллийг гаргаж авах үйл ажиллагаа ("урвуу инженерчлэл") ордог.

Дизайн нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын шинэ эсвэл өөрчилсөн функц, хэлбэр, дүр төрхийг хөгжүүлэх үйл ажиллагааг багтаадаг. Бүтээгдэхүүний дизайны зорилго нь бараа, үйлчилгээний сонирхол татахуйц (гоо зүйн) эсвэл ашиглахад хялбар (үйл ажиллагаа) байдлыг сайжруулах явдал юм.

Бусад бүтээлч ажилд шинэ мэдлэг олж авах, мэдлэгийг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх бүх үйл ажиллагаа орно.

Маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаанд зах зээлийн судалгаа, зах зээлийн туршилт, үнэ тогтоох арга, бүтээгдэхүүн байршуулах, бүтээгдэхүүний урамшуулал, сурталчилгаа; үзэсгэлэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, маркетингийн стратеги боловсруулах зэрэг ордог. Мөн тухайн ААНБ-ын олон нийтэд, хэрэглэгчдэд таниулах зар сурталчилгаа хамаардаг.

Оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагаа нь ихэвчлэн судалгаа, хөгжүүлэлт, програм хангамж хөгжүүлэлт, инженерчлэл, дизайн болон бусад бүтээлч ажлын үр дүнд бий болсон мэдлэгийг хамгаалах эсвэл ашиглах явдал юм.

Оюуны өмчийн үйл ажиллагаанд оюуны өмчийн эрхийг **мэдүүлэх, бүртгүүлэх, баримтжуулах, удирдах, худалдаалах, лиценз авах, зах зээлд гаргах, хэрэгжүүлэхэд** чиглэсэн бүх захиргааны болон хууль эрх зүйн ажил орно. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөл олж авах эсвэл шууд худалдан авах, гуравдагч этгээдэд IP худалдах бүхий л үйл ажиллагаа хамаарна.

Оюуны өмчийн эрхийн гэрчилгээнд **патент, хэрэглээний патент, ашигтай загвар, барааны тэмдэг, зохиогчийн эрх, ургамал үржүүлэгчийн эрх (шинэ ургамлын сорт), газарзүйн заалт**, худалдааны нууц зэрэг нууц мэдээлэл орно (WIPO, 2004).

Хамаарах хугацаанаас өмнөх инновацын үр дүнд мэдүүлсэн, авсан оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагааг 2018-2021 онд хэрэгжүүлсэн ч **оруулахгүй**.

Ажиллагчдын сургах үйл ажиллагаанд тодорхой хугацаанд худалдаа эсвэл тусгайлсан ажил мэргэжил, үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор байгууллагаас төлбөрийг төлсөн эсвэл хөнгөлөлт үзүүлсэн бүх сургалтын үйл ажиллагааг ойлгоно.

Сургалтад

- Ажлын байран дахь сургалт
- Боловсролын байгууллага, сургуулийн сургалт аль аль нь хамаарна.

Жишээ

- Шинэ програм хангамжийн ложистикийн систем эсвэл шинэ тоног төхөөрөмж зэрэг инновацийг ашиглах хүний нөөцийг сургах;
- Бүтээгдэхүүний инновацийн онцлогийн талаар хүний нөөц эсвэл үйлчлүүлэгчдэд зааварчилгаа өгөх зэрэг инновацийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт.

Гэхдээ

- Одоо байгаа бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцыг ашиглах эсвэл
- Ерөнхий ур чадварыг дээшлүүлэх эсвэл
- Хэлний сургалт нь инновацын үйл ажиллагаанд **орохгүй**.

Програм хангамж, мэдээллийн сан хөгжүүлэх үйл ажиллагаанд дараах ажлууд орно. Үүнд:

1. Систем болон хэрэглээний програм хангамжийн аль алинд нь **компьютерийн програм хангамж, програмын тайлбар, туслах материалыг дотооддоо хөгжүүлэх, худалдан авах** (стандарт програм хангамжийн багцууд, тусгайлан тохируулсан програм хангамжийн шийдэл, бүтээгдэхүүн эсвэл тоног төхөөрөмжид суулгасан програм хангамж орно).
2. Компьютерийн мэдээллийн сан болон бусад компьютержсэн **мэдээллийг олж авах, дотооддоо хөгжүүлэх, дүн шинжилгээ хийх** (нээлттэй тайлан болон интернэтээс мэдээлэл олж авах мөн орно.)
3. Мэдээллийн технологийн систем, түүний дотор компьютерийн програм, өгөгдлийн сангийн функцийг шинэчлэх, өргөжүүлэх үйл ажиллагаа. Үүнд статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээлэл олборлох үйл ажиллагаа орно.

Биет хөрөнгийг худалдаж авах, түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаанд барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийг худалдан авах, түрээслэх, эсвэл өөрийн хэрэгцээнд зориулан дотооддоо үйлдвэрлэх үйл ажиллагаа орно.

Эдгээр хөрөнгө нь бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцын шинэчлэлд шаардлагатай бол хамаарахыг анхаарна уу.

Мөн одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмж, биет хөрөнгөөс эрс ялгаатай байх.

Инновацын менежментийн үйл ажиллагаанд инновацийн дотоод болон гадаад нөөцийг төлөвлөх, удирдах, хянах бүх системтэй үйл ажиллагааг багтаадаг.

Үүнд:

- Инновацын нөөцийг хэрхэн хуваарилах,
- Ажилчдын дунд үүрэг хариуцлага, шийдвэр гаргах зохион байгуулалт,
- Гадны түншүүдтэй хамтран ажиллах менежмент,
- Инновацын үйл ажиллагаанд гадны оролцоог нэгтгэх,
- Инновацын үр дүнг хянах, туршлагаас суралцах, дэмжих үйл ажиллагаа орно.

Ерөнхийдөө инновацын менежментийн үйл ажиллагаа нь инновацид идэвхтэй ажилладаг ААНБ-д илүү хамаатай байдаг.

7.4. Танай аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагааны хүрээнд цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс инновацын үйл ажиллагааны хүрээнд цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Энэ асуулгад “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 7.6-д шилжинэ.

7.5. Танай аж ахуйн нэгж дараах цахим технологийн үйлчилгээний алийг нэвтрүүлсэн бэ?

Тухайн аж ахуйн нэгжээс ямар цахим технологийн үйлчилгээ нэвтрүүлснийг асууж тохирох хариултыг сонгоно. Харин хариултад дурдаагүй ажил хэлсэн бол 'Бусад' буюу 'Г'-г сонгоод ямар цахим технологийн үйлчилгээ нэвтрүүлснийг асууж бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

***Нийгмийн инноваци гэдэг нь:** Нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдэл юм.*

7.6. Танай аж ахуйн нэгж инновацын чиглэлээр дараах төсөл, хөтөлбөр, тэтгэлэгт хамрагдсан уу?

Тухайн аж ахуйн нэгжээс инновацын чиглэлээр дотоод, гадаадын төсөл, хөтөлбөр, тэтгэлэгт хамрагдсан эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Дотоодын төсөл, хөтөлбөр, тэтгэлэг нь төсвийнх үү, төсвийн бус уу гэдгийг ангилан хариулна.

1. Инновацын грантын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г, "Үгүй" бол 2-г сонгоно.

***Инновацын грант** гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр инновацын тодорхой төсөлд буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг ойлгоно.*

2. Инновацын/ технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл хэрэгжүүлсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г, "Үгүй" бол 2-г сонгоно.

- ***Инновацын төсөл** гэж санхүүжилтийн шаардлага, зохион байгуулалтын нөхцөлд нийцүүлэн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх цогц үйл ажиллагааг тодорхой цаг хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг ойлгоно.*

- ***Технологийн туршилт, зүгшрүүлэлт** гэж лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагааг ойлгоно.*

3. Бусад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г, "Үгүй" бол 2-г сонгоно.

7.7. 2018-2021 онд инновацын ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэхийг шалгах: Асуулт 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6-н аль нэгэнд "Тийм", 7.3-т "Хийгдэж байгаа" гэж хариулсан эсэх

Тухайн аж ахуйн нэгж 2018-2021 онд инновацын ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэхийг шалгана. Асуулт 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6-н аль нэгэнд "Тийм", 7.3-т "Хийгдэж байгаа" гэж хариулсан бол дараагийн асуултыг асууна, харин бүгдэд "Үгүй" гэж хариулсан бол асуулт 7.11-т шилжинэ.

7.8. Танай аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагааг хэрхэн хөгжүүлсэн бэ?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд инновацыг хэрхэн хөгжүүлснийг асууж дараах хариултаас тохирохыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Аж ахуйн нэгж дангаараа
- Дээд боловсролын байгууллагатай хамтарсан
- Бусад байгууллагатай хамтарсан
- Бусад байгууллагын Инновацыг өөрийн онцлогт тохируулан шинэчлэн сайжруулсан

7.9. Инновацын үйл ажиллагааны 2020 оны зардлын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжийн 2020 оны инновацын үйл ажиллагааны зардлын хэмжээг эх үүсвэрээр доор дурдсан зардлын нэр төрлөөр нөхнө. Эдгээр зардлыг эх үүсвэр тус бүрээр нь мянган төгрөгөөр илэрхийлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр зардлын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ $\text{мөр13} = \text{мөр}(1+6 \div 12)$.

- Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт
 - "Шинжлэх ухаан, технологийн сан (ШУТСан)-гаас"
 - "Орон нутгийн төсвийн санхүүжилт"
 - Яам, агентлагаас
 - шинжлэх ухаан, технологийн салбарын асуудал эрхэлсэн сайдын багцаас
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаас
- Дээд боловсролын сургалтын байгууллагаас
- Төрийн бус байгууллага
- Өөрийн үйл ажиллагааны орлогоос
- Банк, санхүүгийн байгууллагаас
- Гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламжаар

7.10. Инновацын үйл ажиллагааны 2020 оны зардлын хэмжээг үйл ажиллагааны төрлөөр нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжээс 2020 оны инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй үйл ажиллагааны зардлын хэмжээг доор тусгагдсан зардлын төрөл бүрээр нь мянган төгрөгөөр илэрхийлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр зардлын төрлийн нийлбэр дүн бичигдэнэ $\text{мөр10} = \text{мөр}(1 \div 9)$.

- Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үйл ажиллагаа
- Инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа
- Маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаа
- Оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагаа
- Ажиллагчдыг сургах үйл ажиллагаа
- Програм хангамж, мэдээллийн өгөгдлийн санг хөгжүүлэх үйл ажиллагаа
- Биет хөрөнгийг худалдаж авах, түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Инновацын менежментийн үйл ажиллагаа
- Бусад үйл ажиллагааны зардал

7.11. Инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэхийг шалгах: Асуулт 7.3-ын аль нэг үйл ажиллагаанд "Тийм", "Хийгдэж байгаа" гэж хариулсан эсэх

Тухайн аж ахуйн нэгж 2018-2021 онд инновацын үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэхийг шалгана. Асуулт 7.3-ын аль нэг үйл ажиллагаанд **"Тийм"**, **"Хийгдэж байгаа"** гэж хариулсан бол **"1"** гэсэн кодыг сонгоод асуулт 7.14-т шилжинэ.

7.12. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд яагаад инновацын үйл ажиллагаа явуулаагүй вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд яагаад инновацын үйл ажиллагаа явуулаагүйг асууж "Шинэ инновац хийх шаардлага байгаагүй гэж хариулсан" бол **"1"**-г сонгоод дараагийн асуултыг асууна, харин "Хүндрэл бэрхшээл их байсан" гэж хариулсан бол **"2"**-г сонгоод асуулт 7.14-т шилжинэ.

7.13. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд инновацын үйл ажиллагаа явуулаагүй шалтгаан нь юу вэ?

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд инновацын үйл ажиллагаагүй шалтгаан нь юу байсныг тодруулан асууж дараах хариултаас тохирохыг сонгоно. Харин хариултад дурдаагүй шалтгаан хэлсэн бол **"Бусад"** буюу **"д"**-г сонгоод ямар шалтгаантай байсныг асууж бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Зах зээлд инновацын эрэлт бага
- Өмнөх шинэлэг зүйлүүдээс шалтгаалан шинэчлэл хийх шаардлагагүй
- Зах зээлд өрсөлдөөн маш бага тул шинэчлэл хийх шаардлагагүй
- Инновацын шинэ санаа дутагдаж байна

7.14. Танай аж ахуйн нэгжид инновацын үйл ажиллагааг явуулахад тулгардаг хүндрэл бэрхшээлээ хэлнэ үү

Тухайн аж ахуйн нэгжээс 2018-2021 онд инновацын үйл ажиллагааг явуулахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг асууж дараах хариултаас тохирохыг сонгоно. Харин хариултад дурдаагүй шалтгаан хэлсэн бол **"Бусад"** буюу **"ё"**-г сонгоод ямар шалтгаантай байсныг асууж бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Төсөв хөрөнгө хангалтгүй
- Зээл, өөрийн хөрөнгө дутмаг
- Чадварлаг ажиллагчид дутмаг
- Төрийн дэмжлэг хангалтгүй бага байдаг
- Хамтран ажиллах түншийг олоход хэцүү
- Зах зээлийн өрсөлдөөн их

7.15. Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн үү?

Тухайн аж ахуйн нэгж 2020 онд инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлсэн эсэхийг асууж, **Тийм** гэсэн бол “1”-г, **Үгүй** гэсэн бол “2”-г сонгоод асуулт 8.1-т шилжинэ.

МУЗГ-аас 2020 онд баталсан Тэргүүлэх чиглэл (5 бүлгийн 11 чиглэл)

- Мэдээллийн технологийн үйл ажиллагаа
- Шинэ материалын технологийн үйл ажиллагаа
- Биотехнологи/ үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа
- Сэргээгдэх эх үүсвэртэй эрчим хүчний технологийн үйл ажиллагаа
- Үндэсний онцлог бүхий соёлын инноваци, бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

7.16. Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг, 2020 оны дүнгээр нөхнө үү.

Тухайн аж ахуйн нэгжийн 2020 оны инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг асууж нөхнө үү.

Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа бүрт нийт ажиллагчдын тоо, үүнээс эмэгтэй ажиллагчид, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлого, хөрөнгө оруулалтын хэмжээг дотоод, гадаад эх үүсвэрээр нөхнө. Дотоод эх үүсвэрийг төсвийн болон төсвийн бус задална. Мөн санхүүгийн тайлан гаргадаг эсэх талаар тодруулж тохирох хариултыг сонгоно.

Ажиллагчдын тоо нь 2020 оны жилийн дундаж тоо байх ба нийт ажиллагчдын тоог багана 1-т, эмэгтэй ажиллагчдын тоог багана 2-т нөхнө.

Багана 3-д инновацын тэргүүлэх чиглэл бүрээр тухайн аж ахуйн нэгжээс 2020 онд ажиллагчдадаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлыг мянган төгрөгөөр нөхнө. Үүнээс эмэгтэй ажиллагчдын цалинг багана 4-т Цалин, түүнтэй адилтгах зардалд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал багтана.

***Үндсэн цалин** - тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.*

***Нэмэгдэл** - ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл байна.*

***Нэмэгдэл хөлс** - ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.*

Багана 5-д инновацын тэргүүлэх чиглэл бүрээрх орлогыг мянган төгрөгөөр, багана 6-д нийт хөрөнгө оруулалтын хэмжээг мянган төгрөгөөр, багана 7-д дотоодын төсвийн хөрөнгө оруулалт, багана 8-д дотоодын төсвийн бус хөрөнгө оруулалт, багана 9-д гадаадын хөрөнгө оруулалтыг тус бүр нөхнө.

Багана 10-т тухайн аж ахуйн нэгж тухайн үйл ажиллагааны тайлан гаргадаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

- Санхүүгийн тайлан гаргадаг бол “а”-г, татварын тайлан гаргадаг бол “б”-г, дотоодын тайлан гаргадаг бол “в”-г, бусад тайлан гаргадаг бол “г”-г сонгоно.

Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- **Хиймэл оюун хөгжүүлэх, хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи** гэж хүн, амьтны байгалийн оюун ухааныг мэдээллийн технологийн тусламжаар дуурайлган хийсэн оюун ухааны програм тооцоолол юм.
- **Их өгөгдлийн боловсруулалт, хамгаалалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт** гэж том, олон төрлийн, хувилбар бүхий их хэмжээний мэдээлэл, өгөгдлийн багцыг хадгалах, өгөгдлийн шинжилгээ, хайлт хийх, хуваалцах, дамжуулах, дүрслэх, шинэчлэх, мэдээллийн нууцлал, эх сурвалжуудыг дэвшилтэт мэдээллийн анализын аргаар харьцуулсны үндсэн дээр илүү үнэ цэнэтэй, тодорхой мэдээллийн эх сурвалжийг тодорхойлж, оновчтой шийдэл боловсруулах арга, технологи юм.
- **Арьс шир, ноос, ноолуур гүн боловсруулах технологи** гэж бизнес үйлдвэрлэлд хэрэгцээтэй, давуу байдлыг бий болгох чиглэлээр ноос, ноолуур, арьс ширний физик, химийн шинж чанарыг өөрчлөн сайжруулж, хөнгөн үйлдвэрийн шинэ болон сайжруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн дэвшилтэт арга технологи юм.
- **Дулааны материал үйлдвэрлэх технологи** гэж барилга байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчийг хэмнэх зориулалт бүхий хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дулаан дамжуулалт багатай материал үйлдвэрлэх арга технологи юм.
- **Шинэ түлшний материал гарган авах технологи** гэж хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасан, зах зээлийн хэрэгцээг тогтвортой хангах, эрчим хүчний найдвартай байдлыг бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байх шинэ түлшний материалыг гарган авах арга технологи юм.
- **Хөдөө аж ахуйн болон байгалийн түүхий эдийг орчин үеийн биотехнологийн аргаар хүнс, хүний эм, вакцин, биобэлдмэл хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи** гэж байгалийн болон техникийн ухааны уулзвар дээр үүссэн салбар дундын судалгаа, үйлдвэрлэлийн хосолмол чиглэл юм. Монгол орны уламжлалт мал аж ахуй болон унаган байгаль орчинд байгаа биологийн нөөцийг ашиглан шинэ бүтээгдэхүүн, бодис биологийн идэвхт нэмэлт бодис гарган авах арга технологи юм.
- **Малын эм урвалж, вакцин, ургамал хамгаалах бэлдмэл хийх технологи** гэж амьд биетийн уураг, удамшлын мэдээллийн молекулын түвшний оношилгоо шинжилгээ, туршилтын арга технологийг ашиглан уураг, энзим фермент, биологийн идэвхт нэмэлт бодисуудыг ялган авч мал аж ахуйд зориулсан вакцин, оношлуур, эм урвалжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга технологи юм.
- **Эрчим хүчийг хуримтлуулах технологи** гэж эрчим хүчний системийг үр ашигтай болгох, хэрэглэгчийг найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор эрчим хүчийг хуримтлуулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үр ашгийг дээшлүүлэх арга технологи юм.
- **Эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологид суурилсан барилга байгууламжийг байгуулах технологи** гэж эрчим хүчний хэмнэлт бүхий барилга байгууламжийг байгуулах, эрчим хүчний зохистой, ухаалаг хэрэглээг бий болгох тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх арга технологи юм.

- **Дижитал технологид суурилсан контент, соёлын үйлчилгээ** гэж монгол орны үзэсгэлэнт байгаль, үндэсний түүх соёлын өв, уламжлалт мэдлэгийг ашиглан соёлын аж үйлдвэрийг бий болгох, түүнд тулгуурласан бизнесийн, танин мэдэхүйн бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох арга технологи юм.
- **Ухаалаг технологид суурилсан төрийн болон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт** гэж төрийн болон бизнесийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, шат дамжлагагүй, хүнд сурталгүй хүргэх ухаалаг технологийг нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх арга технологи юм.

7.17. Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд оролцсон ажиллагчдын тоог шинжлэх ухааны салбар тус бүрээр 2020 оны дүнгээр нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгж инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон нийт ажиллагчдын тоог 2020 оны дүнгээр, шинжлэх ухааны салбар бүрээр, хүйс, боловсролын түвшин, эрдмийн зэргээр ангилан нөхнө. Харин “БҮГД” гэсэн нүдэнд ажиллагчдын нийлбэр дүн бичигдэнэ мөр8=мөр(1÷7).

Ажиллагчдын тоо нь 2020 оны дундаж тоо байх бөгөөд шинжлэх ухааны салбар бүрээр нийт ажиллагчдын тоог багана 1-т, эмэгтэй ажиллагчдын тоог багана 2-т, багана 3-т дээд боловсролтой, багана 4-т үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог, багана 5-д техникийн болон мэргэжлийн боловсролтой, багана 6-д үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог, багана 7-д бусад боловсролтой, багана 8-д үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог, багана 9-14 эрдмийн зэрэгтэй ажиллагчдын тоог тус тус нөхнө.

1. Дээд боловсролд доктор, магистр, дипломын дээд боловсролтой хүмүүсийг хамруулна. Үүнд:

- **Доктор**т дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан докторын сургалт 210 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж докторын боловсролын зэрэг хамгаалсан инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.
- **Магистр**т дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан магистрын сургалт 150 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж магистрын боловсролын зэрэг хамгаалсан инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.
- **Бакалавр**т дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120-оос доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж бакалаврын боловсролын зэрэг хамгаалсан инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.
- **Дипломын дээдэд** дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж дипломын боловсролын зэрэг хамгаалсан инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.

2. **Техникийн болон мэргэжлийн боловсролд** техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.

- **“Мэргэжлийн боловсрол”** гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг ойлгоно.
- **“Техникийн боловсрол”** гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг ойлгоно.

3. **Бусад** суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.

Багана 9-14-т эрдмийн зэрэгтэй ажиллагчдын тоог нөхнө. Харин “БҮГД” гэсэн нүдэнд нийлбэр дүн бичигдэнэ.

- **Шинжлэх ухааны докторт** эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэн Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн тушаалаар олгодог эрдмийн зэрэгтэй инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцсон ажилтныг хамруулна.
- **Боловсролын доктор** нь их сургууль зэрэг судалгааны чиг баримжаатай мэргэжлийн боловсролын байгууллагуудад шинэлэг, дэвшилтэт судалгааны ажил гүйцэтгэсэн суралцагчдад олгодог эрдмийн зэрэг юм.

Шинжлэх ухааны салбарыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- **Байгалийн шинжлэх ухааны салбар:** Тус шинжлэх ухааны салбарт математикийн шинжлэх ухаан, компьютер, мэдээллийн шинжлэх ухаан, физикийн шинжлэх ухаан, химийн шинжлэх ухаан, газар, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, биологийн шинжлэх ухаан болон бусад байгалийн шинжлэх ухааны дэд салбарыг хамруулан авч үзнэ.
- **Инженерчлэл болон технологийн шинжлэх ухааны салбар:** Иргэний инженерчлэл, цахилгааны инженерчлэл, электроникийн инженерчлэл, мэдээллийн инженерчлэл, механик инженерчлэл, химийн инженерчлэл, материал (түүхий эд) судлал, анагаах ухааны инженерчлэл, хүрээлэн буй орчны инженерчлэл, хүрээлэн буй орчны биотехнологи, үйлдвэрлэлийн биотехнологи, нано-технологи, бусад инженерчлэл болон технологийн дэд салбаруудыг хамруулна.
- **Анагаах болон эрүүл мэндийн шинжлэх ухааны салбар:** Анагаах ухааны суурь судалгаа, эмнэл зүйн анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн биотехнологи болон бусад анагаах ухааны дэд салбаруудыг авч үзнэ.
- **Хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн шинжлэх ухааны салбар:** Хөдөө аж ахуй, ой, загас, агнуур, амьтан, сүү судлал, мал эмнэлэг судлал, ХАА биотехнологи болон бусад ХАА-н шинжлэх ухааны дэд салбаруудыг авч үзнэ.
- **Нийгмийн шинжлэх ухааны салбар:** Сэтгэл судлал, эдийн засаг, бизнес, боловсрол судлал, социологи, хууль, эрх зүй, улс төр судлал, нийгэм, эдийн засгийн газар зүй, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо болон бусад нийгмийн шинжлэх ухааныг хамруулна.
- **Хүмүүнлэг болон урлагийн шинжлэх ухааны салбар:** Түүх, археологи, хэл, уран зохиол, философи, ёс зүй, шашин, урлаг болон бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны дэд салбаруудыг хамруулна.

8. СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ (2018-2021 оноор)

Судалгаа хөгжүүлэлтийн ажил гэж хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа системтэй, бүтээлч үйл ажиллагаа болон уг ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглахад чиглэсэн цогц ажил юм.

8.1. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн үү?

Тухайн аж ахуйн нэгж 2018-2021 онд судалгаа хөгжүүлэлтийн ажил хийсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

1. Суурь судалгааны ажил хийсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г сонгоод гүйцэтгэсэн нийт ажлын тоог холбогдох нүдэнд нөхнө, "Үгүй" бол 2-ыг сонгоод, бүгдэд "Үгүй" гэсэн бол асуулт 9.1-т шилжинэ.

Суурь судалгааны ажил гэж аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд анхнаасаа ашиглахыг зориогүй, туршилтын буюу онолын судалгааны ажил юм.

Суурь судалгаа нь судлагдахууны шинж чанар, бүтэц, өөр хоорондын харилцан хамааралд дүн шинжилгээ хийх замаар таамаглал, онол, зүй тогтлыг шинээр томьёолох, туршихад чиглэнэ. Хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагааг ойлгоно (Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.3-р заалт).

2. Хэрэглээний судалгааны ажил хийсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г сонгоод гүйцэтгэсэн нийт ажлын тоог холбогдох нүдэнд нөхнө, "Үгүй" бол 2-ыг сонгоно.

Хэрэглээний судалгаа (хавсарга судалгаа)-ны ажил гэж тодорхой үр дүн гаргахад чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтооход чиглэгдэнэ. Хэрэглээний судалгааны үр дүн нь тодорхой бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй, тогтолцоонд ашиглагдахад зориулагдсан байдаг (Фраскатиин гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

3. Туршилт, хөгжүүлэлтийн ажил хийсэн эсэхийг асууж, "Тийм" бол 1-г сонгоод гүйцэтгэсэн нийт ажлын тоог холбогдох нүдэнд нөхнө, "Үгүй" бол 2-ыг сонгоно.

Туршилт, хөгжүүлэлтийн ажил гэж шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажлыг ойлгоно (Фраскатиин гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

2018-2021 онд ямар суурь, хэрэглээний судалгааны ажил, туршилт, хөгжүүлэлтийн ажил хийсэн эсэхийг шалгана. Хэрэв асуулт 9.1-д аль нэг үзүүлэлтэд "Тийм" гэж хариулсан бол дараагийн асуултыг асууна, бүгдийг "Үгүй" гэж хариулсан бол асуулгыг дуусгана.

8.2. Танай аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн ажлын чиглэлээр ямар төсөл, судалгааны ажил хэрэгжүүлсэн бэ?

Тухайн аж ахуйн нэгжээс судалгаа хөгжүүлэлтийн ажлын чиглэлээр ямар төсөл, судалгааны ажил хэрэгжүүлснийг тодруулан асууж тохирох хариултыг сонгоно. Харин хариултад

дурдаагүй ажил хэлсэн бол 'Бусад' буюу 'з'-г сонгоод ямар төсөл, судалгааны ажил хийснийг бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

Засгийн газрын 2014 оны 301-р тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын ШУТ-ийн төсөлд хамаарах шинэ мэдлэг, мэдээллийг бий болгоход чиглэсэн суурь судалгааны төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүдийг **суурь судалгааны** ажилд, хэрэглээний судалгаанд чиглэсэн хөтөлбөрийн зорилтот төсөл, захиалгат төсөл, гадаадтай хамтарсан төслүүдийг **хэрэглээний судалгааны** ажилд, цөм технологийн төсөл, технологийн, туршилт зүгшрүүлэлтийн төслүүдийг **туршилт, хөгжүүлэлтийн** ажилд тус тус оруулна.

- **Хөтөлбөрийн зорилтот төсөл** гэж нийгмийн болон салбарын хөгжлийн урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжиж байгаа төслийг ойлгоно.
- **Суурь судалгааны төсөл** гэж хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг, мэдээллийг бий болгоход чиглэсэн төслийг хамааруулна.
- **Захиалгат төсөл** гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ болон төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, агентлаг, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн төслийг ойлгоно. Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг болон нутгийн захиргааны байгууллага нь дангаараа эсвэл аж ахуйн нэгжтэй хамтран төсөл захиалж болно.
- **Цөм технологийн төсөл** гэж Засгийн газраас баталсан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалтад хамаарах технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх төслийг ойлгоно.
- **Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл** гэж лабораторийн түвшинд боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслийг ойлгоно
- **Гадаадтай хамтарсан төсөл** гэж Монгол Улсын Засгийн газар, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гадаадын улс орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ (хэлэлцээр)-ний хүрээнд хэрэгжүүлэх хоёр болон олон талт төслийг ойлгоно.
- **Тэтгэлэгт судалгаа буюу "Грант"** гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгө юм.

8.3. Танай аж ахуйн нэгж шинжлэх ухааны аль салбарын хүрээнд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн бэ?

Тухайн аж ахуйн нэгж шинжлэх ухааны аль салбарын хүрээнд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснийг асууж тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

- **Байгалийн шинжлэх ухааны салбар:** Тус шинжлэх ухааны салбарт математикийн шинжлэх ухаан, компьютер, мэдээллийн шинжлэх ухаан, физикийн шинжлэх ухаан, химийн шинжлэх ухаан, газар, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, биологийн шинжлэх ухаан болон бусад байгалийн шинжлэх ухааны дэд салбарыг хамруулан авч үзнэ.
- **Инженерчлэл болон технологийн шинжлэх ухааны салбар:** Иргэний инженерчлэл, цахилгааны инженерчлэл, электроникийн инженерчлэл, мэдээллийн инженерчлэл, механик инженерчлэл, химийн инженерчлэл, материал (түүхий эд) судлал, анагаах ухааны инженерчлэл, хүрээлэн буй орчны инженерчлэл, хүрээлэн буй орчны биотехнологи, үйлдвэрлэлийн биотехнологи, нано-технологи, бусад инженерчлэл болон технологийн дэд салбаруудыг хамруулна.
- **Анагаах болон эрүүл мэндийн шинжлэх ухааны салбар:** Анагаах ухааны суурь судалгаа, эмнэл зүйн анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухаан, эрүүл мэндийн биотехнологи болон бусад анагаах ухааны дэд салбаруудыг авч үзнэ.
- **Хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн шинжлэх ухааны салбар:** Хөдөө аж ахуй, ой, загас, агнуур, амьтан, сүү судлал, мал эмнэлэг судлал, ХАА биотехнологи болон бусад ХАА-н шинжлэх ухааны дэд салбаруудыг авч үзнэ.
- **Нийгмийн шинжлэх ухааны салбар:** Сэтгэл судлал, эдийн засаг, бизнес, боловсрол судлал, социологи, хууль, эрх зүй, улс төр судлал, нийгэм, эдийн засгийн газар зүй, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо болон бусад нийгмийн шинжлэх ухаануудыг хамруулна.
- **Хүмүүнлэг болон урлагийн шинжлэх ухааны салбар:** Түүх, археологи, хэл, уран зохиол, философи, ёс зүй, шашин, урлаг болон бусад хүмүүнлэгийн шинжлэх ухааны дэд салбаруудыг хамруулна.

8.4. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон ажиллагчдын тоог 2020 оны дүнгээр, албан тушаалаар нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон нийт ажиллагчид болон судлаачдыг, бүтэн цаг, бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга, албан тушаал, хүйсээр ангилан нөхнө.

Ажиллагчдын тоо нь 2020 оны дундаж тоо байх ба нийт ажиллагчдын тоог багана 1-т, эмэгтэй ажиллагчдын тоог багана 3-т нөхнө.

СХА-ын хүний нөөц гэж СХА хэрэгжүүлэхэд оролцож буй судлаачид, бусад шаардлагатай ажиллагчдын нөөц юм. Энд СХА биечлэн гүйцэтгэж буй хүний нөөц болон СХА-ын менежер, бичиг хэргийн ажилтан, инженер, техникийн ажилтан зэрэг шууд үйлчилгээ үзүүлдэг нийт ажиллагчдыг хамруулна (Фраскатийн гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

- **Удирдах албан тушаалтан** гэж СХА-ын хүрээнд хэрэгжүүлэх туршилт, судалгааны ажлыг оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, ханган ажиллах чиг үүрэг бүхий менежерийг ойлгоно. Удирдах албан тушаалтан нь ихэвчлэн судалгааны үйл ажиллагаанд шууд оролцдог судлаачдаас илүү их судалгааны ажлын туршлага, судалгааны ажлыг удирдан зохион байгуулах ур чадвартай байна (Фраскатийн гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).
- **Судлаач** гэж шинжлэх ухааны тодорхой салбарт шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, процесс, аргачлал, үзэл баримтлал, онол, загвар, техник хэрэгсэл, системийг санаачлах, бүтээх

чиглэлээр СХА хэрэгжүүлдэг, төсөл хэрэгжүүлэхэд биечлэн, идэвхтэй оролцдог мэргэжилтэн юм. СХА гүйцэтгэж буй докторант оюутнуудыг мөн хамааруулж үзнэ. Нийт судлаачдын тоонд хагас цагаар ажиллагчдыг хамруулж тооцно (Фраскатийн гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).

- **Техникч, түүнтэй дүйцэх ажилтан** гэж инженер, физик, нийгэм, хүмүүнлэгийн ухааны нэг буюу хэд хэдэн салбарт ажлын техникийн мэдлэг, мэргэшлийн нарийн ур чадвар, туршлага шаардсан ажил гүйцэтгэдэг мэргэжилтэн юм. Техникч, түүнтэй дүйцэх ажилтан нь судлаачийн удирдлага доор онол, аргачлалын дагуу шинжлэх ухаан, техникийн даалгавар гүйцэтгэх замаар СХА-д оролцож ажилладаг (Фраскатийн гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).
- **Бусад туслах ажилтан** гэж судалгаа хөгжүүлэлтийн төслийн ажилтан болон төсөлтэй шууд холбоотой ажилладаг мэргэжилтэй болон мэргэжилгүй ажилтан, нарийн бичиг, бичиг хэргийн ажилтан зэрэг бусад туслах ажилтныг хамруулна (Фраскатийн гарын авлага, ЭЗХАХБ, 2015 он).
- **Үндсэн (бүтэн цагаар) ажиллагч** гэж Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай ажилладаг ажиллагч болон ээлжээр ажилладаг ажиллагчийг ойлгоно.
- **Ажиллагчдын бүтэн цагт шилжүүлсэн утга** гэж судалгаа хөгжүүлэлтийн хүний нөөцийг нэлэнхүй тооллогын дүн, бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утгаар илэрхийлнэ. Тухайн жилд судалгаа хөгжүүлэлтийн ажилд бүтэн цагаар ажилласан нийт үндсэн ажиллагчдын тоон дээр хагас цагаар ажилладаг нийт ажиллагчдыг бүтэн цагт шилжүүлж тооцсон утгыг нэмж, нийт ажиллагчдыг бүтэн цагт шилжүүлсэн утгаар илэрхийлнэ.

Ажиллагчдын бүтэн цагт шилжүүлсэн утга = $\sum$ (бүтэн цагаар ажилласан үндсэн ажиллагч, хагас цагаар ажилласан ажиллагчдыг бүтэн цагт шилжүүлсэн утга)

Жишээ нь:

БЦАХТШУ нь бутархай тоо байж болно. Тухайн байгууллагын ажиллагчид нь СХА-д жилийн турш бүтэн цагаар ажилладаг үндсэн ажилтан бол СХА-ын нийт ажиллагчдын тоо нь бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга (БЦАХТШУ)-тай тэнцүү байна.

Нэг БЦАХТШУ гэдгийг нэг хүн-жил гэж үзэж болно. Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга нь СХА-ын хүний нөөцийн бодит хэмжээг илэрхийлнэ. Тус тоон үзүүлэлтээр олон улсын харьцуулалт хийх боломжтой.

СХА-ын асуулгыг тухайн жил СХА-ын БЦАХТШУ дор хаяж нэгтэй тэнцүү байгаа нэгжийг хамруулахыг зөвлөмж болгов. Бодит амьдрал дээр ажлын цагийнхаа 90-ээс их буюу тэнцүү хувийг СХА-д зарцуулдаг хүнийг нэг БЦАХТШУ гэж үзэж болно. Үүнтэй адилаар ажлын цагийн 10-аас бага буюу тэнцүү хувийг СХА-д зарцуулдаггүй хүнийг судалгаанд оруулахгүй.




Бүтэн цагаар ажиллах амлалт гэдэг нь тухайн ажиллагчийн байгууллагатай хийсэн гэрээний утгыг илэрхийлнэ.


СХА-д жилд идэвхтэй оролцох хугацаа гэдэг нь тухайн ажилтан бүтэн жилийн хугацаанд СХА-д хэр хугацаанд идэвхтэй оролцох хугацааг илэрхийлнэ.

СХА-д өдөрт зарцуулах цаг гэдэг нь өдрийн 8 цагийн хэдийг нь СХА-д зарцуулж байгааг илэрхийлнэ.

Жишээ 1.



Жишээ 2.



Жишээ 3.



- Хэрэв нийт ажлын цагийнхаа 30 хувийг СХА-д, үлдсэнийг нь бусад ажилд зарцуулж буй тухайн хүнийг 0.3 БЦАХТШУ гэж үзнэ.
- Хэрэв судлаач жилийн 6 сарыг судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулсан бол 0.5 БЦАХТШУ болно. Хамгийн сүүлд нийлбэрийг нэгтгэж дүнг олоод бүхэл тоонд шилжүүлнэ.
- Бүтэн цагийн ажилтан СХА-д ажлын цагийн 100%-ийг зарцуулна: $(1*1*1)=1$ БЦАХТШУ
- Бүтэн цагийн ажилтан СХА-д ажлын цагийн 40%-ийг хагас жил зарцуулна (жилийн зөвхөн 6 сар л идэвхтэй ажиллана): $(1*0.5*0.4)=0.2$ БЦАХТШУ
- Цагийн ажилтан (ажлын 40%-ийг бүтэн жилийн хугацаанд зарцуулна) зөвхөн СХА-д хагас (ажлын цагаа 100% СХА-д зарцуулах) жилийн турш ажиллана: $(0.4*0.5*1)=0.2$ БЦАХТШУ
- Бүтэн цагаар ажилладаг 20 хүн СХА-д ажлын цагийн 40%-ийг жилд зарцуулна: $20*(1*1*0.4)=8$ БЦАХТШУ

8.5. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон ажиллагчдын тоог 2020 оны дүнгээр, боловсролын түвшнээр нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон нийт ажиллагчид болон судлаачдыг, бүтэн цаг, бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга, боловсролын түвшин, хүйсээр ангилан нөхнө.

- **Докторт** дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан докторын сургалт 210 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд

боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж докторын боловсролын зэрэг хамгаалсан СХА-д оролцсон ажилтныг хамруулна.

- **Магистрт** дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан магистрын сургалт 150 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж магистрын боловсролын зэрэг хамгаалсан СХА-д оролцсон ажилтныг хамруулна.
- **Бакалаврт** дээд боловсрол эзэмшүүлэх өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120-оос доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж бакалаврын боловсролын зэрэг хамгаалсан СХА-д оролцсон ажилтныг хамруулна.
- **Дипломын дээдэд** дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд дээд боловсролын тухай хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж дипломын боловсролын зэрэг хамгаалсан СХА-д оролцсон ажилтныг хамруулна.
- **Техникийн болон мэргэжлийн боловсролд** техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн СХА-ын ажилтныг хамруулна.
 - о **"Мэргэжлийн боловсрол"** гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ.
 - о **"Техникийн боловсрол"** гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ.
- **Бусдад** суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн СХА-д оролцсон ажилтныг хамруулна.

8.6. Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон ажиллагчдыг тоог 2020 оны дүнгээр, насны бүлгээр нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд оролцсон нийт ажиллагчид болон судлаачдыг, бүтэн цаг, насны бүлэг, хүйсээр ангилан нөхнө.

- **25 хүртэлх**- 25 нас хүртэл
- **25-34**- 25-аас 34 насны
- **35-44** – 35-аас 44 насны
- **45-54** – 45-аас 54 насны
- **56-64** – 55-аас 64 насны
- **65, түүнээс дээш**-65, түүнээс дээш насны ажиллагчид хамаарна.

8.7. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын 2020 оны зардлын хэмжээг нөхнө үү

Тухайн аж ахуйн нэгжийн судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулсан дотоод зардлын санхүүжилтийн хэмжээг эх үүсвэрээр нөхнө. Эдгээр зардлыг эх үүсвэр тус бүрээр нь мянган төгрөгөөр үнэлж нөхнө. Харин "БҮГД" мөрөнд эдгээр зардлын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ $\text{мөр1} = \text{мөр}(2+7 \div 13)$.

- **Улсын төсвийн санхүүжилт гэж** тодорхой орлогын эх үүсвэрээс санхүүжихээр улсын төсөвт тусгагдсан СХА-д зарцуулах бүх зардлын санхүүжилтийн хэмжээг ойлгоно. Улсын төсвөөс бусад эх үүсвэрээс СХА-ыг санхүүжүүлсэн зардлыг тухайн жилийн төсөвт тусгасан тохиолдолд нэмж тооцно. Харин төрийн өмчит байгууллагуудаас санхүүжүүлсэн зардлыг тооцохгүй ба зөвхөн онцгой тохиолдолд эдгээр байгууллагуудаас СХА-д зориулсан санхүүжилтийг улсын төсвөөс СХА-д хуваарилсан зардлын бүрэлдэхүүн хэсэг гэж тооцож болно.
- **Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын санхүүжилт гэж** бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудаас тайлант хугацаанд олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.
- **Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт гэж** дээд боловсролын сургалтын байгууллагуудаас тайлант хугацаанд олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.
- **Төрийн бус байгууллагын санхүүжилт гэж** хувийн хэвшлийн ашгийн бус байгууллагуудаас тайлант хугацаанд олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.
- **Өөрийн үйл ажиллагааны орлогын санхүүжилт гэж** өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн нийт санхүүжилтийн хэмжээг ойлгоно.
- **Гадаадын байгууллагын санхүүжилт гэж** гадаад улсын Засгийн газар, гадаадын ОУБ-ын төсөл, хөтөлбөрүүдээс тайлант хугацаанд олгосон санхүүжилтийн хэмжээг ойлгоно.

Тухайн аж ахуйн нэгж 2020 онд судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гарч буй үйл ажиллагааны зардлын хэмжээг зардлын ангиллаар нөхнө. Тухайн жилд СХА-ыг гүйцэтгэхэд зориулсан бүх урсгал зардлыг бичнэ $m\ddot{e}p14 = m\ddot{e}p(15 + 22 \div 42)$.

- **Цалингийн зардалд** СХА-ын ажиллагчдын цалин болон урамшуулал, амралтын цалин, тэтгэврийн сан зэрэг нэмэлт зардлыг оруулна. Энд удирдах албан тушаалтан, судлаач /үндсэн, гэрээт/, техникч, түүнтэй дүйцэх ажилтан, бусад туслах ажилтнуудын цалинг тус тус ангилан бичнэ.
- **Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд** нийгмийн болон эрүүл даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг хамруулна.
- **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд** гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр болон бохир ус зэрэг зардлыг оруулна.
- **Хангамж, бараа материалын зардалд** бичиг хэрэг, тээвэр шатахуун, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардлыг оруулна.
- **Нормативт зардалд** эм, бэлдмэл эмнэлэг, лабораторийн хэрэгсэл, нормын хувцас, зөөлөн эдлэлтэй холбоотой зардлыг хамруулна.
- **Урсгал засварын зардалд** засвар болон ашиглалт, үйлчилгээний зардлуудыг оруулна.
- **Дотоод томилолт, зочны зардалд** дотоодын албан томилолт, зочны зардлыг авч үзнэ.
- **Гадаад томилолтын зардалд** нийт гадаад томилолтын зардлыг бичнэ.
- **Байр, талбайн түрээсийн зардалд** байр, талбайн түрээсийн нийт зардлыг бичнэ.
- **Машин, тоног төхөөрөмжийн түрээсийн зардалд** машин, тоног төхөөрөмжийн түрээсийн нийт зардлыг бичнэ.

- *Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний төлбөрт* шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний нийт төлбөрийг бичнэ.
- *Эрдэм шинжилгээний хурал, семинар үзэсгэлэн зохион байгуулах зардалд* нийт эрдэм шинжилгээний хурал, семинар үзэсгэлэн зохион байгуулахад зарцуулсан зардлыг бичнэ.
- *Хээрийн болон социологийн судалгааны зардалд* хээрийн болон социологийн судалгаанд зарцуулсан нийт зардлыг бичнэ.
- *Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх зардалд* олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх нийт зардлыг бичнэ.
- *Эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн санд хандах болон архив, номын сангийн үйлчилгээний төлбөрт* эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн санд хандах болон архив, номын сангийн үйлчилгээний нийт зардлыг бичнэ.
- *Патент мэдүүлэхтэй холбоотой зардалд* бүтээгдэхүүний загвар, шинэ бүтээл, ашигтай загварт патент авахаар мэдүүлэхтэй холбоотой гарсан нийт зардлыг бичнэ.
- *Төслийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зардалд* төслийн үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой гарсан нийт зардлыг бичнэ.
- *Судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зардалд* судалгааны үр дүнг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулахтай холбоотой нийт зардлыг бичнэ.
- *Судлаачийг мэргэшүүлэх, дагалдуулан сургах зардалд* судлаачийг мэргэшүүлэх, дагалдуулан сургахтай холбоотой нийт зардлыг бичнэ.
- *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид* СХА-тай холбоотой үйл ажиллагааг бусдаар гүйцэтгүүлсний төлөө төлсөн ажил, үйлчилгээний төлбөрийг бичнэ.
- *Зээлийн хүүд* СХА-тай холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд банк болон бусад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүг бичнэ.
- *Үйл ажиллагааны бусад зардалд* дээр дурдсанаас бусад үйл ажиллагааны зардал буюу урсгал зардлыг хамруулж авч үзнэ.
- *Хөрөнгийн зардал* -СХА-ын төслүүдэд нэгээс дээш жил эсвэл давтан хэрэглэдэг хөрөнгийн зардлууд, програм хангамжийн болон лицензийн хураамж, нэгээс илүү жил хэрэглэх мэдээллийн сангийн худалдан авалт, газар болон байгууламжийн шинэчлэл болон сайжруулалтад зориулсан томоохон засваруудыг хамруулна $мөр43=мөр(44+49+54+57+58)$.
- Харин бусад засвар ашиглалт, үйлчилгээний зардлууд, хангамжийн элэгдэл хорогдол, СХА-ын эд хөрөнгийн худалдаанаас орж ирсэн орлого зэргийг хамруулахгүй.
- *Орон сууцны барилга* -Аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, нийтийн зориулалттай байр, дотуур байр болон нийтийн зориулалттай орон сууцыг мөн хамруулна.
- *Бусад барилга, байгууламж* -СХА-д ашиглагдаж буй барилга, байгууламжуудыг хамруулна. Барилга, байгууламжийн зардлыг үндсэн болон лабораторийн барилга, бусад байгууламжуудаар тооцно.
- *Жишээ нь:* МУИС-ын Байгалийн ухааны факультет шинэ барилга барихаар 10 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ барилгын цаашдын ашиглалтын 20% нь СХА явуулахад зориулагдах болно. Холбогдох СХА-ын зардлыг тооцохдоо нийт барилгын ажлын зардалд СХА-ын эзлэх хувийг харгалзан үзнэ. Энэ барилгын ирээдүйн хэрэглээний 20% нь СХА-д хэрэглэгдэнэ гэдэг нь харагдаж байна. Иймээс энэ нь барилгын зардалд СХА-

ын эзлэх хувь 2.0 тэрбум төгрөг байна гэж тооцно (2.0 тэрбум төгрөг=10.0 тэрбум төгрөг * 0.2).

- **Орон сууцны бус барилга** -СХА эрхлэх оффисын зориулалттай байр болон туршилт, үйлдвэрлэл хийх лабораторийн барилгыг хамруулна.
- **Жишээ нь:** Шинэ баригдах лабораторийг авч үзвэл үүний яг СХА-ын зорилгоор хэрэглэх хэсгийн зардал нь СХА-ын зардалд багтах ба харин туршилт болон чанарын хяналтын хэсгийн зардал нь СХА-ын зардлаас хасагдана гэсэн үг юм. Хэрэв энэхүү шинэ лабораторийн нийт хэрэглээний 40%-ийг СХА-д ашиглахаар зориулагдсан бол (Жишээ нь: Үлдсэн 60%-ийг бусад үйл ажиллагаанд) тус барилгын нийт барилгын ажлын зардлын 40%-ийг холбогдох СХА-ын зардал гэж тооцно.
- **Бусад байгууламж** -Орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээг хамруулна.
- **Газар, хөрс сайжруулалт** -СХА-ыг гүйцэтгэх зорилгоор эзэмшин ашигладаг болон шинээр худалдан авсан газар, малын бэлчээр, тариалангийн болон туршилт, үйлдвэрлэлийн талбай зэргийг хамруулна.
- **Машин, тоног төхөөрөмж** -СХА-ыг гүйцэтгэх зорилгоор ашиглаж буй бүх төрлийн тээврийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг хамруулна.
- **Тээврийн хэрэгсэл** -СХА-д ашиглагдаж буй бүх төрлийн машин, тээврийн хэрэгслийг ойлгоно.
- **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж** -СХА-д ашиглагдаж буй бүх төрлийн компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжийг хамруулна.
- **Бусад машин, тоног төхөөрөмж** -Судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн багаж, тоног төхөөрөмж болон цэрэг дайны зориулалтаар худалдан авсан зэр зэвсгийн системээс бусад тоног төхөөрөмжийг энд оруулна. Харьцангуй бага үнэтэй болон тогтмол худалдан авдаг гар багаж зэргийг оруулахгүй.
- **Жишээ нь:** ШУТИС-ийн Байгалийн ухааны факультет шинэ тоног төхөөрөмжийг 20 сая төгрөгөөр худалдан авч ашиглав. Багш нарын үзэж байгаагаар, энэ тоног төхөөрөмж нь судалгаа болон сургалтын үйл ажиллагаанд адилхан ашиглагдах болно гэж тооцоолж байна. Шинэ тоног төхөөрөмж худалдан авахад нийт зардал нь 20 сая төгрөг болж байна. Холбогдох СХА-ын зардлыг тооцохдоо нийт зардлын СХА-ын эзлэх хувийг харгалзан үзнэ. Байгалийн ухааны факультетын багш нарын үзэж байгаагаар, энэ тоног төхөөрөмж нь судалгаа болон сургалтын үйл ажиллагаанд адилхан ашиглагдах (50.0 хувь) тул зардлын СХА-д эзлэх хувь нь 10 сая төгрөг байна гэж тооцно (20 сая.төг * 0.5). ШУТИС нь хүнсний технологийн сургуульд албан хэрэгцээнд 100.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан байна. Тухайн автомашин ашиглалтын 30 хувийг СХА-д зориулахаар төлөвлөсөн байна. Энэ тохиолдолд автомашин худалдан авсан үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн зардлыг СХА-ын зардал гэж тооцно (100.0 сая.төг*0.3).
- **Тавилга, эд хогшил** -СХА-д өдөр тутам болон давтамжтайгаар ашиглагдаж буй тавилга, эд хогшлыг хамруулна.
- **Өсөж үрждэг хөрөнгө** -СХА-ын зорилгоор байгууллагын шууд хяналт, удирдлагын дор үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, ургамлыг хамруулна.
- **Мал, амьтад** -СХА-ын зорилгоор өсгөж, үржүүлж буй мал, амьтныг хамруулна.
- **Олон наст ургамал** -СХА-ын туршилтын зорилгоор өсгөж, үржүүлж буй олон наст ургамлыг ойлгоно.
- **Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал** - Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөц орно.

Эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардалд дараах зардал багтана. Үүнд: Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл; худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал; хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар; хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар; худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал; хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

- **Оюуны өмчийн бүтээгдэхүүн** -Биет шинж чанаргүй, хүний оюуны хүчин чармайлтаар бий болдог, нэг буюу түүнээс дээш жил ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг ойлгоно. Үүнд шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, компьютерын програм хангамж, мэдээллийн сан, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэрэг орно. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг компьютерын програм хангамж, мэдээллийн сан, бусад оюуны өмчийн хөрөнгөөр бүртгэнэ мөр58=мөр(59÷61+64+65).
- **Компьютерын програм хангамж** -СХА-ыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай компьютерын програм хангамжийн зардлыг оруулна.
- **Жишээ нь:** Техник технологийн дээд сургууль нь мэдээлэл зүйн анги танхимаа тохижуулахын тулд шинэ програм хангамж худалдан авахад 300.0 сая төгрөг зарцуулжээ. Энэ тохиолдолд эдгээр програм хангамжууд нь сургалтын зорилгоор ашиглагдах тул үүнийг СХА-ын зардал гэж тооцохгүй.
- **Мэдээллийн сан** -Нэгдсэн ангилал, код, индекс, арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага хангасан цуглуулж, боловсруулж, хадгалсан цаасан болон цахим мэдээллийн бүрдлийг ойлгоно.
- **Оюуны өмчийн бусад хөрөнгө** -Дээр дурдсанаас бусад геологи хайгуулын ажил болон үнэлгээ, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэргийг хамруулна.

9. ИННОВАЦ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ҮР ДҮН (2018-2021 оноор)

9.1. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрсэн үү?

Тухайн аж ахуйн нэгжээс инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр ямар үр дүнд хүрснийг асууж тохирох хариултыг сонгоно.

[А] Шинэ технологи бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-ыг сонгоно.

Шинэ технологи гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц юм.

[Б] Шинэ биет бүтээгдэхүүн бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-ыг сонгоно.

Шинэ биет бүтээгдэхүүн гэж биет шинж чанартай, эзэмшигчдээ онцгой эрх, эдийн засгийн үр өгөөж авчирдаг хөрөнгө.

[В] Зураг, каталог бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-ыг сонгоно.

Зураг гэж дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцан хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан

тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атлас, фото зураг, барилгын зураг зэргийг тоон болон дүрслэлийн аргаар зохиож хэвлэх үйл ажиллагаа юм.

Каталог гэж бүхий л баримт, мэдээллийг олон янзын аргаар хайн олж, шүүлтүүр, эрэмбийг хялбар хийх зэргээр ашиглахад хялбар байдлаар хийгдсэн хэрэглэгчдэд мэдээлэх үүрэг бүхий бүртгэлийг ойлгоно.

[Г] Аргачлал, заавар, зөвлөмж бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-ыг сонгоно.

Аргачлал гэдэг нь онолын болон практик үйл ажиллагааг зохион байгуулах аргуудын тайлбар гэж ойлгоно.

Заавар гэж хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан заасан баримт бичиг.

Зөвлөмж гэж удирдлагын аливаа үйл ажиллагааг сайжруулах болон удирдлагын шийдвэрт тусгуулах санал, үзэл баримтлалыг хураангуйлан нэгтгэсэн баримт бичиг.

[Д] Жор, үнэлгээ бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-г сонгоно.

Жор гэж эм, хоол гэх мэт бүтээгдэхүүнд зориулан орц, найрлага, хийх, бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичиг юм.

Үнэлгээ гэж тухайн ажлын гүйцэтгэл ямар байх ёстойг харуулсан болон үр дүнд үнэлэлт дүгнэлт өгсөн бичиг баримтыг ойлгоно.

[Е] Стандарт бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-г сонгоно.

Стандарт гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг юм (Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4.1.2 заалт).

[Ё] Тоног төхөөрөмжийн туршилтын загвар бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-ыг сонгоно.

[Ж] Үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-г сонгоно.

[З] Бусад /тайлан, диссертац гэх зэрэг/ бий болгосон эсэхийг асууж, “Тийм” бол 1-ийг, “Үгүй” бол 2-г сонгоно.

9.2. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх мэдүүлэг гаргасан уу?

Тухайн аж ахуйн нэгжээс инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр оюуны өмчийн патент болон гэрчилгээ авахаар оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргасан эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Хэрэв “Тийм” гэж хариулсан бол оюуны өмчийн газарт гаргасан бүтээл тус бүрийн мэдүүлгийн тоог бичнэ.

9.3. Танай аж ахуйн нэгж 2018-2021 онд инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр оюуны өмчийн патент болон гэрчилгээ авсан уу?

Тухайн аж ахуйн нэгж инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэснээр оюуны өмчийн газраас оюуны өмчийн патент болон гэрчилгээ авсан эсэхийг асууж тохирох

хариултыг сонгоно. Хэрэв “Тийм” бол оюуны өмчийн газраас авсан нийт патент болон гэрчилгээний тоог бичнэ.

Патент гэж тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг гаргасан эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагаанд (шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт) өгч буй онцгой эрх юм.

[А] Шинэ бүтээлийн патент авсан эсэхийг асууж, “Тийм” бол 1-г, “Үгүй” бол 2-г сонгоно.

Шинэ бүтээл гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.

[Б] Бүтээгдэхүүний загварын патент авсан эсэхийг асууж, “Тийм” бол 1-г, “Үгүй” бол 2-г сонгоно.

Бүтээгдэхүүний загвар гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.

[В] Ашигтай загварын патент авсан эсэхийг асууж, “Тийм” бол 1-г, “Үгүй” бол 2-г сонгоно.

Ашигтай загвар гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.

[Г] Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авсан эсэхийг асууж, “Тийм” бол 1-г, “Үгүй” бол 2-г сонгоно.

Барааны тэмдэг гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.

[Д] Зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан эсэхийг асууж, “Тийм” бол 1-г, “Үгүй” бол 2-г сонгоно.

Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерын програм, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.

Асуулгын хуудсыг бөглөж дууссаны дараа асуулгыг өгсөн хүний албан тушаал, овог, нэр, утасны дугаар, мэдээлэл өгсөн огноог заавал бичнэ.

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-2

Тооллого эхлүүлэхээс өмнө тухайн байгууллагад 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцэл, улсын бүртгэлийн гэрчилгээ, инновацын ажлын гүйцэтгэсэн мэдээлэл, холбогдох бичиг баримтыг урьдчилан бэлтгэх талаар байгууллагад мэдээлсэн байна.

Мөн тооллогын асуулгын нөхөхөд тухайн байгууллагын нягтлан бодогч, санхүүгийн ажилтан, мэдээллийн технологийн ажилтан зэргээс мэдээлэл авах тул урьдчилан мэдэгдсэн байна.

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын комисст хүлээлгэж өгнө.

Энэхүү маягтаар улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн байгууллага, албан газар, тэдгээрийн удирдлагад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1. Хяналтын хэсэг

Тоологч/шалгагчийн нэр, код: Тоологч/шалгагч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Тоологч/шалгагч дугаараа нөхөхдөө “код” баганын харгалзах нүдэнд байрлуулахад анхаарна. Хэрэв 2 эсвэл 1 оронтой дугаартай бол “001”, “011” гэж өмнөх оронгийн нүдэнд “0” тавьж гүйцээж бичнэ.

1.2. Нэрийн хэсэг

Тухайн байгууллагын регистрийн дугаар, нэр, байгуулагдсан огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноог улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө. Мөн энэ хэсэгт байгууллагын өмчийн хэлбэр нөхөгдөнө.

Өмчийн хэлбэр

Тухайн байгууллагын өмчийн хэлбэрийг Төрийн болон орон нутгийн өмчийн гэж нөхнө.

Төрийн өмчит үйлдвэрийн газрыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.

- о Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.
- о Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

Төрийн өмчит хуулийн этгээдийг дараах байдлаар ойлгож, ангилна. Үүнд:

- о Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна.
- о Төрийн байгууллага, албан газар
- о Төрийн өмчит үйлдвэрийн газар
- о Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг

1.3. Байгууллагын хаягийн хэсэг3

Байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин байр, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим шуудангийн хаяг (и-мэйл), веб хуудасны нэрийг бичнэ. Кодлогч тэдгээрт тохирох кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас авч нөхнө. Хэрэв тухайн байгууллагын оршин байгаа гудамж, хорооллын нэр нь хавсралтад байгаа гудамж, хорооллын жагсаалтад байхгүй, түүнийг нэмэх шаардлага гарвал түүний кодыг ҮСХ-ны ААНБ-ын тооллогын комиссын гишүүдтэй холбогдож кодолно.

2. ЕРӨНХИЙ АСУУЛГА

2.1. Танай байгууллага хүний нөөцийн чадавхыг сайжруулах сургалт хийдэг үү?

Тухайн байгууллагаас хүний нөөцийн чадавхыг сайжруулахаар сургалт хийдэг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. Хэрэв “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 2.3-т шилжинэ.

2.2. Танай байгууллага хүний нөөцийн чадавхыг сайжруулах ямар чиглэлийн сургалт хийдэг вэ?

Тухайн байгууллагаас хүний нөөцийн чадавхыг сайжруулах ямар чиглэлийн сургалт хийдгийг тодруулан асууж, холбогдох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

Хүний нөөцийн чадавхыг сайжруулах дараах сургалтуудаас дурдаагүй хариулт хэлсэн бол Бусад гэдэгт дэлгэрэнгүй бичнэ. Үүнд:

- Мэргэшүүлэх сургалт
- Чиглүүлэх сургалт
- Мэргэжил дээшлүүлэх
- Хүний хөгжлийн сургалт
- Гадаад хэлний сургалт

2.3. Танай байгууллага үйл ажиллагаагаа явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээл юу вэ?

Тухайн байгууллага үйл ажиллагаагаа явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг асууж, дараах хариултаас сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой. Хэрэв доор дурдагдсан шалтгаанаас бусад хүндрэл бэрхшээл байвал нөхөж бичнэ.

- Төсөв, санхүү хангалтгүй
- Бие дааж үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадамжгүй
- Ажлын байрны нөхцөл хангалтгүй
- Хүний нөөцийн чадавх сул
- Тогтсон байргүй
- Батлагдсан орон тоо хүрэлцээгүй

2.4. Танай байгууллагад хүний нөөцийн дутагдал байгаа юу?

Тухайн байгууллагад хүний нөөцийн дутагдал, хэрэгцээ байгаа эсэхийг тодруулан асууж “Тийм” гэсэн бол “1”-г сонгоод дараагийн асуултыг асууна, “Үгүй” гэсэн бол “2”-г сонгоод асуулт 2.6-д шилжинэ.

2.5. Танай байгууллагад ямар мэргэжлийн ажилтан шаардлагатай байна вэ?

Тухайн байгууллагад ямар мэргэжлийн ажилтан шаардлагатай байгааг тодруулан асууж шаардлагатай байгаа ажил, мэргэжлийн нэр болон хүний тоог асууж тохирох нүдэнд нөхнө.

Тухайлбал, англи хэлний багш, япон хэлний багш, мэдээллийн технологийн мэргэжилтэн, инженер, сувилахуйн мэргэжилтэн, яаралтай тусламжийн эмч гэх зэрэг ажил мэргэжлийн нэрийг дэлгэрэнгүй бичиж, шаардлагатай мэргэжлийн тоог холбогдох нүдэнд бичнэ.

Мэргэжлийн чиглэлийн кодыг 4 оронгийн түвшинд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт” (YAMAM-08)-ын дагуу номоос харж нийслэл, аймгийн тооллогын комиссын гишүүн кодолно.

2.6. Танай байгууллага 2018-2021 онд дараах инновацын үйл ажиллагааг хөгжүүлсэн үү?

Инновацын үйл ажиллагаа гэдэгт ААНБ-ууд инновацыг хөгжүүлж үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлсэн хөгжүүлэлтийн, санхүүгийн болон худалдааны үйл ажиллагаануудыг ойлгоно.

Инновацийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж гэж тайлант хугацаанд нэг эсвэл хэдэн үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор шинэ, сайжруулсан бүтээгдэхүүн эсвэл бизнесийн үйл явц хөгжүүлснийг хэлнэ. Инновацийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг болон эрхэлдэггүй аж ахуйн нэгж нь инновацийн үйл ажиллагааг тайлант хугацаанд явуулсан байж болно.

Тухайн байгууллага 2018-2021 онд инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн эсэхийг асууж дараах хариултаас тохирохыг сонгоно.

Инновацийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаанууд хамаарна. Үүнд:

- Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үйл ажиллагаа
- Инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа
- Маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаа
- Оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагаа
- Ажиллагчдыг сургах үйл ажиллагаа
- Програм хангамж, мэдээллийн өгөгдлийн санг хөгжүүлэх үйл ажиллагаа
- Биет хөрөнгийг худалдаж авах, түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Инновацийн менежментийн үйл ажиллагаа

Судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэх, байгаа мэдлэгийн хэрэглээг бий болгох зорилгоор хийсэн бүтээлч, системтэй ажил юм.

Судалгаа, хөгжүүлэлтийн ажил нь 5 шалгуурыг хангасан байх ёстой (Frascati manual 2015)

6. Шинэлэг (novel)
7. Бүтээлч (creative)
8. Тодорхойгүй үр дүнг шийдвэрлэх (address an uncertain outcome)
9. Системчилсэн (systematic)
10. Шилжүүлж болох/ хуулбарлах боломжтой (transferable and/ or reproducible)

Судалгаа, хөгжүүлэлт нь

- Суурь судалгаа (мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг)
- Хэрэглээний судалгаа (харьцангуй практикт чиглэгддэг)
- Туршилтын хөгжүүлэлт (бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцыг сайжруулах эсвэл шинээр бий болгоход чиглэгддэг)-ээс бүрдэнэ.

Бусад бизнесийн байгууллагаар гүйцэтгүүлсэн болон төлбөр төлсөн бүх төрлийн судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг инновацийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн гэж үзнэ.

Инженерчлэл, дизайн, бүтээлч бусад үйл ажиллагаа:

Инженерчлэл нь үйлдвэрлэл болон чанарын хяналтын журам, арга, стандартыг хамардаг. Үйл ажиллагаанууд нь бараа, үйлчилгээ, үйл явц, системийн техникийн үзүүлэлтүүдийг төлөвлөх, турших, үнэлэх, тохируулах буюу үйлдвэрлэхээс өмнөх үйл ажиллагааг багтаана. Мөн тоног төхөөрөмж суурилуулах, багаж хэрэгсэл бэлтгэх, турших, туршилт хийх, хэрэглэгчдэд үзүүлэх; одоо байгаа бүтээгдэхүүн, технологийн тоног төхөөрөмжөөс мэдээллийг гаргаж авах үйл ажиллагаа ("урвуу инженерчлэл") ордог.

Дизайн нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын шинэ эсвэл өөрчилсөн функц, хэлбэр, дүр төрхийг хөгжүүлэх үйл ажиллагааг багтаадаг. Бүтээгдэхүүний дизайны зорилго нь бараа, үйлчилгээний сонирхол татахуйц (гоо зүйн) эсвэл ашиглахад хялбар (үйл ажиллагаа) байдлыг сайжруулах явдал юм.

Бусад бүтээлч ажилд шинэ мэдлэг олж авах, мэдлэгийг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх бүх үйл ажиллагаа орно.

Маркетинг, брэнд гаргах үйл ажиллагаанд зах зээлийн судалгаа, зах зээлийн туршилт, үнэ тогтоох арга, бүтээгдэхүүн байршуулах, бүтээгдэхүүний урамшуулал, сурталчилгаа; үзэсгэлэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, маркетингийн стратеги боловсруулах зэрэг ордог. Мөн тухайн ААНБ-ын олон нийтэд, хэрэглэгчдэд таниулах зар сурталчилгаа хамаардаг.

Оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагаа нь ихэвчлэн судалгаа, хөгжүүлэлт, програм хангамж хөгжүүлэлт, инженерчлэл, дизайн болон бусад бүтээлч ажлын үр дүнд бий болсон мэдлэгийг хамгаалах эсвэл ашиглах явдал юм.

Оюуны өмчийн үйл ажиллагаанд оюуны өмчийн эрхийг **мэдүүлэх, бүртгүүлэх, баримтжуулах, удирдах, худалдаалах, лиценз авах, зах зээлд гаргах, хэрэгжүүлэхэд** чиглэсэн бүх захиргааны болон хууль эрх зүйн ажил орно. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөл олж авах эсвэл шууд худалдан авах, гуравдагч этгээдэд IP худалдах бүхий л үйл ажиллагаа хамаарна. Оюуны өмчийн эрхийн гэрчилгээнд **патент, хэрэглээний патент, ашигтай загвар, барааны тэмдэг, зохиогчийн эрх, ургамал үржүүлэгчийн эрх (шинэ ургамлын сорт), газарзүйн заалт, худалдааны нууц зэрэг нууц мэдээлэл** орно (WIPO, 2004).

Хамаарах хугацаанаас өмнөх инновацын үр дүнд мэдүүлсэн, авсан оюуны өмчтэй холбоотой үйл ажиллагааг 2018-2021 онд хэрэгжүүлсэн ч **оруулахгүй**.

Ажиллагчдын сургах үйл ажиллагаанд тодорхой хугацаанд худалдаа эсвэл тусгайлсан ажил мэргэжил, үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор байгууллагаас төлбөрийг төлсөн эсвэл хөнгөлөлт үзүүлсэн бүх сургалтын үйл ажиллагааг ойлгоно.

Сургалтад

- Ажлын байран дахь сургалт
- Боловсролын байгууллага, сургуулийн сургалт аль аль нь хамаарна.

Жишээ

- Шинэ програм хангамжийн ложистикийн систем эсвэл шинэ тоног төхөөрөмж зэрэг инновацийг ашиглах хүний нөөцийг сургах;
- Бүтээгдэхүүний инновацийн онцлогийн талаар хүний нөөц эсвэл үйлчлүүлэгчдэд зааварчилгаа өгөх зэрэг инновацийг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт.

Гэхдээ

- Одоо байгаа бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцыг ашиглах эсвэл

- Ерөнхий ур чадварыг дээшлүүлэх эсвэл
- Хэлний сургалт нь инновацын үйл ажиллагаанд **орохгүй**.

Програм хангамж, мэдээллийн сан хөгжүүлэх үйл ажиллагаанд дараах ажлууд орно. Үүнд:

4. Систем болон хэрэглээний програм хангамжийн аль алинд нь **компьютерийн програм хангамж, програмын тайлбар, туслах материалыг дотооддоо хөгжүүлэх, худалдан авах** (стандарт програм хангамжийн багцууд, тусгайлан тохируулсан програм хангамжийн шийдэл, бүтээгдэхүүн эсвэл тоног төхөөрөмжид суулгасан програм хангамж орно).
5. Компьютерийн мэдээллийн сан болон бусад компьютержсэн **мэдээллийг олж авах, дотооддоо хөгжүүлэх, дүн шинжилгээ хийх**. (нээлттэй тайлан болон интернэтээс мэдээлэл олж авах мөн орно.)
6. Мэдээллийн технологийн систем, түүний дотор компьютерийн програм, өгөгдлийн сангийн функцийг шинэчлэх, өргөжүүлэх үйл ажиллагаа. Үүнд статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээлэл олборлох үйл ажиллагаа орно.

Биет хөрөнгийг худалдаж авах, түрээслэхтэй холбоотой үйл ажиллагаанд барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийг худалдан авах, түрээслэх, эсвэл өөрийн хэрэгцээнд зориулан дотооддоо үйлдвэрлэх үйл ажиллагаа орно.

Эдгээр хөрөнгө нь бүтээгдэхүүн, бизнесийн үйл явцын шинэчлэлд шаардлагатай бол хамаарахыг анхаарна уу.

Мөн одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмж, биет хөрөнгөөс эрс ялгаатай байх.

Инновацын менежментийн үйл ажиллагаанд инновацийн дотоод болон гадаад нөөцийг төлөвлөх, удирдах, хянах бүх системтэй үйл ажиллагааг багтаадаг.

Үүнд:

- Инновацын нөөцийг хэрхэн хуваарилах,
- Ажилчдын дунд үүрэг хариуцлага, шийдвэр гаргах зохион байгуулалт,
- Гадны түншүүдтэй хамтран ажиллах менежмент,
- Инновацын үйл ажиллагаанд гадны оролцоог нэгтгэх,
- Инновацын үр дүнг хянах, туршлагаас суралцах, дэмжих үйл ажиллагаа орно.

Ерөнхийдөө инновацын менежментийн үйл ажиллагаа нь инновацид идэвхтэй ажилладаг ААНБ-д илүү хамаатай байдаг.

3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

3.1. Танай байгууллага үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг уу?

Тухайн байгууллагаас үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 3.4-т шилжинэ.

3.2. Ашиглаж байгаа компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоог хэлнэ үү

Тухайн байгууллагаас ашиглаж байгаа компьютерын тоог суурин, зөөврийн гэсэн байдлаар ангилж нөхнө. Мөн таблет, ухаалаг төхөөрөмжийг төрлөөр нөхөхөд анхаарна. Бүгд гэдэгт суурин, зөөврийн компьютер, таблет, ухаалаг төхөөрөмжийн тооны нийлбэрийг бодож нөхнө.

3.3. Компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагаас компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.4. Танай байгууллага мэдээллийн технологийн нэгжтэй юу?

Тухайн байгууллагаас мэдээллийн технологийн нэгжтэй эсэхийг асууж холбогдох хариултыг сонгоно.

3.5. Мэдээллийн технологийн ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагын мэдээллийн технологийн ажиллагчдын тоог асууж нөхнө. Нийт ажиллагчдаас програм хангамжийн ажилтан, техник хангамжийн ажилтныг, хүйсээр ангилан нөхнө.

3.6. Үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг уу?

Тухайн байгууллагаас үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг эсэхийг асууж “**Ашигладаг**” бол “1”-г сонгоод дараагийн асуултыг асууна, Харин “**Ашигладаггүй**” бол “2”-г сонгоод асуулт 3.8-д шилжинэ.

3.7. Үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг хэлнэ үү

Тухайн байгууллагаас үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг асууж интранэт/дотоод сүлжээ, интернэт гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой. Зөвхөн “а” хариултыг сонгосон тохиолдолд асуулт 3.9-т шилжинэ.

Сүлжээ гэдэг нь агаараар болон кабелин холболтын сувгуудыг ашиглан хэсэг бүлэг компьютер бусад мэдээллийн төхөөрөмжүүдийг (хэвлэгч, камер...) холбосон цогцолбор холболт юм.

Сүлжээг дараах байдлаар ангилна. Үүнд:

Интранэт гэж интернэт протокол ашиглаж буй дотоод сүлжээний харилцаа холбоо бөгөөд албан байгууллагын доторх зөвшөөрөгдсөн харилцаа холбоо юм.

Интранэт гэж дотоод сүлжээ нь байгууллага доторх мэдээлэл, хамтын ажиллагааны хэрэгсэл, үйлдлийн систем болон бусад тооцооллын үйлчилгээг хуваалцахад зориулагдсан компьютерын сүлжээ бөгөөд ихэвчлэн гаднын хүмүүсийн хандалтыг хориглодог. Интернэт рүү дэлхийн сая сая хүн ханддаг бол интранэтэд зөвхөн тухайн байгууллагын сүлжээний хүмүүс хандана.

Интернэт бол дэлхийн нийтийн компьютерын сүлжээ юм. Энэ нь World Wide Web зэрэг харилцаа холбооны хэд хэдэн үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд ашигласан төхөөрөмжөөс үл хамааран и-мэйл, мэдээ, өгөгдлийн файлуудыг дамжуулдаг.

Сүлжээний маш олон төрөл байдаг бөгөөд Personal area network – Хувийн сүлжээ (PAN), Local Area Network – Дотоод сүлжээ (LAN), Campus Area Network – Цогцолборын сүлжээ (CAN), Metropolitan area network – Хотын сүлжээ (MAN) болон Wide area network – Өргөн бүсийн сүлжээ (WAN) гэж ангилдаг.

3.8. Үйл ажиллагаандаа интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагаас интернэт тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.9. Танай байгууллага инновацын үйл ажиллагааны хүрээнд цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн үү?

Тухайн байгууллагаас инновацын үйл ажиллагааны хүрээнд цахим технологийн үйлчилгээг нэвтрүүлсэн эсэхийг дараах хариултаас асууж тохирохыг сонгоно. Энэ асуулгад “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 4.1-т шилжинэ.

Жишээ: e-mongolia, ehalamj, ebarimt зэрэг хамаарна.

3.10. Танай байгууллага дараах цахим технологийн үйлчилгээний алийг нэвтрүүлсэн бэ?

Тухайн аж ахуйн нэгж ямар цахим технологийн үйлчилгээ нэвтрүүлснийг асууж тохирох хариултыг сонгоно. Харин хариултад дурдаагүй ажил хэлсэн бол ‘Бусад’ буюу ‘Г’-г сонгоод ямар цахим технологийн үйлчилгээ нэвтрүүлснийг асууж бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн програм хангамж
- Үйлчилгээнд нэвтрүүлсэн програм хангамж
- Нийгмийн инновац буюу цахим контент, технологийн програм хангамж

Нийгмийн инновац гэдэг нь: Нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдэл юм.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2020 оны дүнгээр нөхнө)

4.1. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй, тодорхой бичнэ. Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC-4.0)-аас харж кодлогч нөхнө.

Үйл ажиллагааг тухайн байгууллагын үндсэн эрхлэх үйл ажиллагааны дагуу дараалуулан бичнэ.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, цалин, түүнтэй адилтгах зардал, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогыг нөхнө. Эдгээрийг үйл ажиллагааны чиглэл бүрээр тодорхойлох боломжгүй бол үндсэн үйл ажиллагаагаар нөхнө. 2-оос 5-р багануудын дүнг харгалзах баганын “Бүгд” гэсэн мөрөнд нэгтгэнэ. Ажиллагчдын тоог 2020 оны дундаж ажиллагчдын тоо байна.

Тухайн асуулгын 4 дүгээр баганад 2020 онд тухайн байгууллагаас ажиллагчдадаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээг мянган төгрөгөөр тооцож тавина. Цалин, түүнтэй адилтгах зардалд үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллыг оруулна.

***Үндсэн цалин** гэдэг нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм. **Нэмэгдэл** гэдэг нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.*

***Нэмэгдэл хөлс** гэдэг нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.*

5-р баганад үндсэн бус туслах үйл ажиллагааны орлогыг мянган төгрөгөөр тооцож нөхнө. Үүнд төсвийн зардлыг оруулахгүй. Өөрөөр хэлбэл гадаад валютын ханшны зөрүүгийн олз, хөрөнгө худалдсаны олз, бараа материал, нөөцийн бараа материал худалдсаны олз зэрэг орно. Жнь: Хэвлэлийн цехийн орлого, МАА, ГТ-ийн орлого гэх мэт.

6-р баганад тухайн байгууллага дээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг мянган төгрөгөөр тооцож нөхнө.

4.2. Танай байгууллага 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн үү?

Тухайн байгууллага 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Тийм” буюу “1”-р хариултыг сонговол дараагийн асуултыг үргэлжлүүлэн асууна. “Үгүй” буюу “2”-р хариултыг сонговол асуулт 4.4-т шилжинэ.

4.3. Хөрөнгө оруулалтын хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү

Хөрөнгө оруулалт нь хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, 2020 онд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм.

Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт** гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;
- **Өөрийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;
- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт**- аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт**- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессын гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мянган төгрөгөөр үнэлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ.

4.4. Хөрөнгийн үзүүлэлтийг нөхнө үү (элэгдэл хасагдаагүй дүн)

Тухайн аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл хасагдаагүй дүнг бичнэ.

1. Үндсэн хөрөнгө. Үндсэн хөрөнгийг 2020 оны жилийн эхний үлдэгдэл, нэмэгдсэн, хөрөнгө оруулалт, хасагдсан, оны эцсийн үлдэгдлийг элэгдэл хасагдаагүй дүнгээр мянган төгрөгөөр тооцож нөхнө $\text{мөр1} = \text{мөр}(2+3+8+9+14+17+18)$.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга байгууламж, дуусаагүй барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж, өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

1.1 Орон сууцны барилгад аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.

1.2 Бусад барилга, байгууламж нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ $\text{мөр3} = \text{мөр}(4+5+7)$.

- 1.2.1 **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.
- 1.2.2 **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.
- 1.2.2.1 **Авто замыг** бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.
- 1.2.3 **Газар, хөрс сайжруулалт** нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна.
- 1.3 **Дуусаагүй барилга байгууламжид** хараахан дуусаагүй барилга байгууламжийг хамааруулж ойлгоно.
- 1.4 **Машин, тоног төхөөрөмж** нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ мөр₉=мөр_(10÷13).
- 1.4.1 **Тээврийн хэрэгсэл** нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх
- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
 - төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
 - нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
 - усан онгоц, аяны болон спортын завь
 - мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.
- 1.4.2 **Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид** цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.
- 1.4.3 **Тавилга, эд хогшилд** албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.
- 1.4.4 **Бусад машин, тоног төхөөрөмжид** ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.
- 1.5 **Биологийн өсөж үрждэг хөрөнгөд** байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. **Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.**
- 1.6 **Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал** нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

- Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
- Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;
- Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
- Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
- Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
- Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.7 Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилна $\text{мөр}18 = \text{мөр}(19+22+25+26)$. Үүнд:

1.7.1 Судалгаа хөгжүүлэлтийн ажилд хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. **Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зах зээлийн үнийг** шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.

- **Инновацад** бусдаар гүйцэтгүүлсэн/ худалдаж авсан судалгаа хөгжүүлэлтийн ажил, програм хангамж, мэдээллийн өгөгдлийн сан, худалдаж авсан биет хөрөнгө зэргийг хамруулах ба зах зээлийн үнийг шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.
- **Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд** газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.
- **Програм хангамж, мэдээллийн санд** худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан програм хангамж, системийн болон хэрэглээний програм хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол** програм хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, **өөрсдөө боловсруулсан бол** үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд **үйлдвэрлэлийн зардлаар** үнэлнэ. Програм хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ $\text{мөр}22 = \text{мөр}(23+24)$.
- **Утга зохиол, урлагийн эх бүтээл** нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.
- **Оюуны өмчийн бусад хөрөнгө** дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник эдийн засгийн үндэслэл

2. Материаллаг эргэлтийн хөрөнгө нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн орно.

2.1 Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2 Хангамжийн материал нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3 Дуусаагүй үйлдвэрлэл нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ $\text{мөр}35 = \text{мөр}(36 \div 38)$.

2.3.1 Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсөж гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2 Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд өсөж үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл болон дуусаагүй барилга байгууламжаас бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4 Бэлэн бүтээгдэхүүнд хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиа, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5 Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

3. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зориулалтаар эзэмшдэг хөрөнгө байна $\text{мөр}35 = \text{мөр}(36 \div 38)$.

3.1 Үнэт металл, үнэт чулуу нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2 Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3 Бусад үнэт зүйлсэд маркийн цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засаж хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

4. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө

Үйлдвэрлэгдэх хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

4.1 Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.

4.2 Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө – Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брэндийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.

- **Шинэ бүтээл** гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.
- **Бүтээгдэхүүний загвар** гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.
- **Ашигтай загвар** гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.
- **Барааны тэмдэг** гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.

4.3 Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

Хөрөнгийн үзүүлэлтийг нөхөж бичихдээ 2020 оны дүнг 1-р баганад оны эхний дүнг, 2-р баганад оны эхнээс нэмэгдсэн дүнг, 3-р баганад шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтыг, оны эхнээс хасагдсан дүнг 4-р баганад, эцсийн дүнг 5-р баганад харуулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үндсэн хөрөнгө, материаллаг эргэлтийн хөрөнгө, үнэт зүйлийн нийлбэр дүн бичигдэнэ мөр $48 = \text{мөр}(1+27+35+39)$.

5. ӨГӨГДЛИЙН САН

5.1. Танай байгууллага өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сантай юу?

Тухайн байгууллагаас өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сантай эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулгыг дуусгана.

5.2. Өгөгдлийн сангийн талаарх мэдээллийг нөхнө үү

Багана А, 1: Тухайн байгууллагын өгөгдлийн сангийн нэр, зориулалтыг асууж, мөрөнд жагсаан бичнэ.

Өгөгдлийн сан буюу өгөгдлийн сан нь зохион байгуулалттайгаар хадгалсан өгөгдлийн цуглуулга юм. Өгөгдлийн санд хандах, засварлах болон нэмэхэд хялбар байдлаар хийгдсэн байдаг. Өгөгдлийн сан нь мэдээлэл хайх, статистик мэдээ гаргаж авахад хялбар байдгаараа давуу талтай.

Багана 2: Тухайн байгууллагын өгөгдлийн сангийн нууцын зэрэглэлийн түвшнийг асууж **"төрийн нууц"**-аар хамгаалагдсан бол **"1"** гэсэн кодыг, **"албаны нууц"**-аар хамгаалагдсан бол **"2"** гэсэн кодыг, нууцлалгүй нээлттэй бол **"Нээлттэй"** буюу **"3"** гэсэн кодыг сонгоно.

Багана 3: Тухайн байгууллагын өгөгдлийн сангийн бичлэгийн түвшин буюу ямар мэдээллийг агуулж байгааг асууж **"хувь хүн"**-ний мэдээлэл гэсэн бол **"1"**-ийг, **"аж ахуйн нэгж, байгууллага"**-ын мэдээлэл гэсэн бол **"2"**-ыг, **"объект"** буюу барилга, байшингийн мэдээллийг агуулж байгаа бол **"3"**-ыг, **"нэгтгэсэн"** мэдээлэлтэй бол **"4"** гэсэн кодыг сонгоно.

Багана 4: Тухайн байгууллагын өгөгдлийн сангийн хэрэглэгчийг асууж хэрэглэгч нь **"эрх бүхий төрийн албан хаагч"** гэсэн бол **"1"**-ийг, хэрэглэгч нь **"иргэд"** гэсэн бол **"2"**-ыг, хэрэглэгч нь **"аж ахуйн нэгж, байгууллага"** гэсэн бол **"3"**-ыг, хэрэглэгч нь **"бусад"** гэсэн бол **"4"** гэсэн кодыг сонгоно.

Багана 5: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санг анх нэвтрүүлсэн оныг асууж нөхнө.

Багана 6: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сангийн төрлийг асууж дараах хариултаас сонгоно (1. Oracle, 2. MSSQL, 3. MySQL, 4. PostgreSQL, 5. MongoDB). Бусад төрлийн өгөгдлийн санг бүрдүүлсэн бол 6 гэж дугуйлан төрлийг нь бичиж өгнө.

Багана 7: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сан хаана байрлаж байгааг асууж холбогдох хариултыг сонгоно. Өгөгдлийн сан нь **"Үндэсний дата төв"**-д байрладаг бол **"1"** гэсэн кодыг, **"Өөрийн дата төв"**-д байрладаг бол **"2"** гэсэн кодыг, дээрхээс бусад газарт байрладаг бол **"Бусад"** гэдгийг сонгоно.

Багана 8: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сан төрийн мэдээлэл солилцооны **"ХУР"** системд холбогдсон эсэхийг асууж **Тийм** бол **"1"**-ийг, **Үгүй** бол **"2"**-ыг сонгоно.

Багана 9: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сан төрийн мэдээллийн сан буюу **"E-mongolia"**-д холбогдсон эсэхийг асууж **Тийм** бол **"1"**-ийг, **Үгүй** бол **"2"**-ыг сонгоно.

Багана 10: Тухайн байгууллага өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн сангийн мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээ хийдэг эсэхийг асууж **Тийм** бол **"1"**-ийг, **Үгүй** бол **"2"**-ыг сонгоно.

Багана 11: Тухайн байгууллагаас өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санг шинээр бий болгох болон түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж оруулсан хөрөнгө оруулалтыг асууж, мянган төгрөгөөр нөхөж бичнэ.

Багана 12-13: Нийт хөрөнгө оруулалтын дүнгээс програм хангамж болон техник хангамжийн хөрөнгө оруулалтын дүнг салган асууна.

Багана 14: Тухайн байгууллагын хөрөнгө оруулалтын хамарсан хугацааг асууж, жил, сараар илэрхийлж бичнэ.

Багана 15: Тухайн байгууллагаас өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санг хөтлөн явуулахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг асууж, холбогдох (1. Санхүүжилт, 2. Хүний нөөц, 3. Техник, тоног төхөөрөмж, 4. Хамгаалалт, аюулгүй байдал) хариултыг сонгоно. Хариултад дурдаагүй хариулт хэлсэн бол бусад гэдэгт дэлгэрэнгүй бичнэ.

Багана 16: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санд ашиглаж байгаа програм хангамж лицензтэй эсэхийг асууж **"лицензтэй"** бол **"1"**-ийг сонгоод лицензтэй програм хангамжийн нийт тоог бичээд багана 18—д шилжинэ. Харин **"лицензгүй"** бол **"2"**-ыг сонгоод лицензгүй програм хангамжийн нийт тоог бичээд багана 17-г нөхнө.

Багана 17: Тухайн байгууллагын өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санд ашиглаж байгаа лицензгүй програм хангамжид **лиценз** авахад шаардлагатай зардлын хэмжээг мянган төгрөгөөр бичнэ.

Багана 18: Тухайн байгууллагаас өөрийн удирдан хөгжүүлдэг өгөгдлийн санд зориулан зарцуулдаг жилийн дундаж урсгал зардлыг асууж мянган төгрөгөөр бичнэ.

Багана 19: Нийт цалин хөлсөнд өгөгдлийн сангийн ажиллагчдын жилийн дундаж цалин, урамшуулал, НДШ, татварын зардлыг оруулна.

Багана 20: Програм хангамжийн лицензийн зардалд өгөгдлийн сангийн програм хангамжийн лицензийн зардал, өгөгдлийг санг ажиллуулахад шаардлагатай програм хангамжийн лицензийн зардлуудыг оруулна.

Багана 21: Програм хангамжийн бусад зардалд өгөгдлийн санг ажиллуулахад шаардагддаг бусад зардлуудыг оруулна.

Багана 22: Тоног төхөөрөмжийн лицензийн зардалд өгөгдлийн сангийн ажиллуулахад шаардагддаг сервер, тоног төхөөрөмжийн лицензийн зардлуудыг оруулна.

Багана 23: Тоног төхөөрөмжийн бусад зардалд өгөгдлийн санг ажиллуулахад шаардагддаг сүлжээний тоног төхөөрөмжийн зардал, мэдээллийн аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн зардал, сервер, дата төвийн тоног төхөөрөмжийн зардал, бусад техник, тоног төхөөрөмжийн зардлуудыг оруулна.

Багана 24: Засвар, үйлчилгээний лицензийн зардалд өмнөх зардлуудаас өөр засвар, үйлчилгээний төрлийн лицензүүдийн зардлыг оруулна.

Багана 25: Засвар, үйлчилгээний бусад зардалд интернэтийн зардал, програм хангамжийн засвар, даатгал, агааржуулалтын систем, цахилгааны үйлчилгээний зардал, бусад засвар үйлчилгээний зардлуудыг оруулна.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө. Мэдээлэл өгсөн хүнд талархал илэрхийлнэ.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА ААНТ-3

Тооллого эхлүүлэхээс өмнө тухайн байгууллагад 2020 оны жилийн эцсийн тайлан тэнцэл, улсын бүртгэлийн гэрчилгээ болон холбогдох бичиг баримтыг урьдчилан бэлтгэх талаар байгууллагад мэдээлсэн байна.

Мөн тооллогын асуулгын нөхөхөд тухайн байгууллагын дарга/захирал, нягтлан бодогч, санхүүгийн ажилтан, мэдээллийн технологийн ажилтан зэргээс мэдээлэл авах тул урьдчилан мэдэгдсэн байна.

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын комисст хүлээлгэж өгнө.

Энэхүү маягтаар нийгэм болон гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага; үйлдвэрчний эвлэлийн байгууллага; үндэсний хүмүүнлэгийн байгууллага; шашны байгууллага; сан; улс төрийн нам; олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар, Монгол улсад суугаа элчин сайдын яамд; төсөл хөтөлбөрүүдээс мэдээлэл цуглуулна.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1. Хяналтын хэсэг

Тоологч/шалгагчийн нэр, код: Тоологч/шалгагч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Тоологч/шалгагч дугаараа нөхөхдөө “код” баганын харгалзах нүдэнд байрлуулахад анхаарна. Хэрэв 2 эсвэл 1 оронтой дугаартай бол “001”, “011” гэж өмнөх оронгийн нүдэнд “0” тавьж гүйцээж бичнэ.

1.2. Нэрийн хэсэг

Тухайн байгууллагын регистрийн дугаар, нэр, байгуулагдсан огноо, улсын бүртгэлийн дугаар, улсын бүртгэлд бүртгүүлсэн огноог улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн нөхнө. Мөн энэ хэсэгт байгууллагын өмчийн хэлбэр, үүсгэн байгуулагдсан төрлийг нөхнө.

Өмчийн хэлбэр. Тухайн байгууллагын өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Өмчийн хэлбэрийн холбогдох кодыг кодлогч “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

1.3. Үйл ажиллагаа явуулж буй хаяг

Байгууллагын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим шуудангийн хаяг (и-мэйл), цахим /веб/ хуудасны нэрийг бичиж өгнө.

Кодлогч тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхөх бөгөөд байгууллагын оршин байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн нэр нь хавсралтад байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй тохиолдолд ҮСХ-ны ААНБ-ын тооллогын комиссын гишүүдтэй холбогдож кодолно.

1.4. Байгууллагын дарга/захирлын мэдээлэл

Байгууллагын дарга/захирлын овог, нэр, регистрийн дугаар, суурин утас, гар утасны дугаарыг асууж нөхнө.

1.5. Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа

Нийгэмдээ үйлчилдэг төрийн бус байгууллага уг асуулгыг нөхөх ба өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хувьд үйл ажиллагааны төрлийг “Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал (ICNPO)”-ын дагуу нөхнө. Кодлогч үйл ажиллагааны чиг үүргийн ангиллыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтыг ашиглан кодолно.

2. ЕРӨНХИЙ АСУУЛГА

2.1. Төрийн бус байгууллагын төрөл

Төрийн бус байгууллагыг дотор нь нийгэмдээ үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэж ангилна. Нийгэмдээ үйлчилдэг буюу “1” -ийг сонговол асуулт 2.3-т шилжинэ. Гишүүддээ үйлчилдэг буюу “2”-ыг сонговол дараагийн асуултыг асууна.

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг ойлгоно.

Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага нь өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдгээс бусад төрийн бус байгууллагууд байна.

2.2. Гишүүдийн тоо

Тухайн төрийн бус байгууллагын гишүүдийн нийт тоо байна. Үүнд гишүүн бус ажиллагчдын тоог оруулахгүй. Жич: Улс төрийн намыг төв байгууллага нь нийт гишүүдийн тоог нөхнө. Харин аймаг, дүүргийн улс төрийн нам нь тухайн салбар намдаа бүртгэлтэй гишүүдийн тоог нөхнө.

2.3. Үйл ажиллагаа явуулж байгаа эсэх

Тухайн байгууллагын үйл ажиллагаа эрхлэлтийн байдлын тохирох хариултыг сонгоно.
Асуултад Тийм буюу 1-р хариултыг сонговол 3.1-т шилжинэ.

2.4. Үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаа хэлнэ үү

Тухайн байгууллага 2.3-р асуултын 2-р хариултыг сонгосон тохиолдолд үйл ажиллагаа эрхлээгүй шалтгааныг асууж нөхнө. “Эхлээгүй” хариулт нь үүсэн байгуулагдсанаасаа хойш үйл ажиллагаа явуулаагүй байгууллага байна. “Түр зогсоосон” нь 18 сар хүртэлх хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах зорилго бүхий нэгж хамрагдана. “Бүрэн зогссон” гэж 18-с дээш сарын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй тухайн орон нутгийн татварын байгууллагад болон бусад бүртгэлийн байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн нэгж байна. Хэрэв дээрхээс өөр шалтгаантай бол “Бусад” гэсэн хэсэгт бичнэ.

3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

3.1. Танай байгууллага үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг уу?

Тухайн байгууллага үйл ажиллагаандаа компьютер, ухаалаг төхөөрөмж ашигладаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 3.4-т шилжинэ.

3.2. Ашиглаж байгаа компьютер, ухаалаг төхөөрөмжийн тоог нөхнө үү

Тухайн байгууллагаас ашиглаж байгаа компьютерын тоог суурин, зөөврийн, таблет, ухаалаг төхөөрөмж гэсэн төрлөөр ялгаж асууна. Бүгд гэдэгт суурин, зөөврийн компьютер, таблет, ухаалаг төхөөрөмжийн тооны нийлбэрийг бичнэ.

3.3. Компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагаас компьютер тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.4. Үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг уу?

Тухайн байгууллагаас үйл ажиллагаандаа сүлжээ ашигладаг эсэхийг асууж “Ашигладаг” бол “1”-г сонгоод дараагийн асуултыг асууна, харин “Ашигладаггүй” бол “2”-г сонгоод асуулт 4.1-т шилжинэ.

Сүлжээ гэдэг нь агаараар болон кабелин холболтын сувгуудыг ашиглан хэсэг бүлэг компьютер бусад мэдээллийн төхөөрөмжүүдийг (хэвлэгч, камер...) холбосон цогцолбор холболт юм.

Сүлжээг дараах байдлаар ангилна. Үүнд:

Интранэт гэж интернэт протокол ашиглаж буй дотоод сүлжээний харилцаа холбоо бөгөөд албан байгууллагын доторх зөвшөөрөгдсөн харилцаа холбоо юм.

Интранэт гэж дотоод сүлжээ нь байгууллага доторх мэдээлэл, хамтын ажиллагааны хэрэгсэл, үйлдлийн систем болон бусад тооцооллын үйлчилгээг хуваалцахад зориулагдсан

компьютерын сүлжээ бөгөөд ихэвчлэн гаднын хүмүүсийн хандалтыг хориглодог. Интернет рүү дэлхийн сая сая хүн ханддаг бол интранэтэд зөвхөн тухайн байгууллагын сүлжээний хүмүүс хандана.

Интернет бол дэлхийн нийтийн компьютерын сүлжээ юм. Энэ нь World Wide Web зэрэг харилцаа холбооны хэд хэдэн үйлчилгээнд нэвтрэх боломжийг олгодог бөгөөд ашигласан төхөөрөмжөөс үл хамааран и-мэйл, мэдээ, өгөгдлийн файлуудыг дамжуулдаг.

3.5. Үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг хэлнэ үү

Тухайн байгууллагаас үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрлийг асууж интранэт/дотоод сүлжээ, интернет гэсэн хариултаас тохирох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой. Зөвхөн “а” хариултыг сонгосон тохиолдолд асуулт 4.1-т шилжинэ.

Сүлжээний маш олон төрөл байдаг бөгөөд *Personal area network* – Хувийн сүлжээ (PAN), *Local Area Network* – Дотоод сүлжээ (LAN), *Campus Area Network* – Цогцолборын сүлжээ (CAN), *Metropolitan area network* – Хотын сүлжээ (MAN) болон *Wide area network* – Өргөн бүсийн сүлжээ (WAN) гэж ангилдаг.

3.6. Үйл ажиллагаандаа интернет тогтмол ашигладаг ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагаас интернет тогтмол ашигладаг ажиллагчдын тоог асууж хариултыг нөхнө.

3.7. Ямар зорилгоор интернэтийг ашигладаг вэ?

Тухайн байгууллагаас интернэтийг ямар зорилгоор ашигладгийг асууж дараах хариултаас тохирох хариултыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол төрлийг дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Харилцагч/хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэх
- Бараа бүтээгдэхүүнийг онлайнаар хүргэх
- И-мэйл авах/явуулах,
- Эд юмс, тоног төхөөрөмж удирдах /Internet of things/
- Мэдээ, мэдээлэл авах, илгээх
 - o бараа үйлчилгээний
 - o төрийн байгууллагын и-мэйл, веб сайтаар дамжуулан
 - o бусад мэдээллийн хайлт болон судалгаанаас
- Интернет банкны үйлчилгээнд хамрагдах
- Бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдах (мерчантын үйлчилгээ /и-коммерс үйлчилгээ, Qraу үйлчилгээ, pass ухаалаг түрийвч/ гэх зэрэг)
- Төрийн болон олон нийтийн байгууллагуудтай харилцах

4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2020 оны дүнгээр нөхнө)

4.1. Танай байгууллага 2020 онд үйл ажиллагаа явуулсан уу?

Тухайн байгууллага 2020 онд үйл ажиллагаа явуулсан эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу 2-р хариултыг сонговол асуулт 5.1-т шилжинэ.

4.2. Ажиллагчдын тоог хэлнэ үү

Тухайн байгууллагын нийт ажиллагчдын тоог 2020 оны жилийн дундаж ажиллагчдын тоог хүйсээр нөхнө. Мөн нийт ажиллагчдаас сайн дурын ажиллагчдын тоог нөхнө.

Сайн дурын ажил хийж байгаа хүн гэж заавал хийх үүрэг хүлээгээгүй, дагаж мөрдөхөөр зохицуулагдаагүй ч бусдын хэрэглээнд зориулан цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлсэн хүнийг ойлгоно (ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-л-н заалт 37).

4.3. Цалин, түүнтэй адилтгах зардлыг хэлнэ үү

Тухайн байгууллагаас 2020 онд ажиллагчдадаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээ мянган төгрөгөөр нөхнө. Цалинд буюу цалингийн фондод үндсэн цалин, нэмэгдэл, шагнал, урамшуулал орно.

Үндсэн цалин нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.

Нэмэгдэл нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.

Нэмэгдэл хөлс нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс байна.

4.4. Танай байгууллага 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн үү?

Тухайн байгууллагаас 2020 онд хөрөнгө оруулалт хийсэн эсэхийг асууж тохирох хариуг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу “2”-аар хариуг сонговол асуулт 4.6-д шилжинэ.

4.5. Хөрөнгө оруулалтын 2020 оны хэмжээг эх үүсвэрээр нөхнө үү

Хөрөнгө оруулалт нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг өргөтгөх, сайжруулахад зориулж, 2020 онд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардал юм. Хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр тодорхойлно. Үүнд:

- *Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт* гэж төрөөс үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс гаргаж байгаа хөрөнгө оруулалтын зардлыг;
- *Өөрийн хөрөнгө оруулалт*- аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө, орлогоос хийсэн хөрөнгө оруулалтыг;

- **Банкны зээлийн хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллагын банкны бизнесийн зээлээр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** - Монгол Улсын нутаг дэвсгэрт аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө болон оюуны үнэт зүйлсийг;
- **Гадаадын зээл, тусламж** - гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжаар хөрөнгөөр бий болгосон хөрөнгө оруулалтыг;
- **Хувьцаа, өрийн бичиг, үнэт цаас борлуулсны хөрөнгө оруулалт** - аж ахуйн нэгж, байгууллага нь үнэт цаас, хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт буй болгосныг;
- **Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн гэрээ байгуулах** - төр, хувийн хэвшлийн концессын гэрээний дагуу бий болгосон хөрөнгө оруулалт, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтыг;
- **Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтад** - дотоодын аж ахуйн нэгж, байгууллагын хандивын хөрөнгөөр, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг багтаана. Мөн гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон иргэний бэлэглэсэн эсвэл үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг энд хамааруулна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг эх үүсвэр тус бүрээр нь мянган төгрөгөөр үнэлж нөхнө. Харин “БҮГД” мөрөнд эдгээр хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийлбэр дүн бичигдэнэ.

4.6. Хөрөнгийн үзүүлэлтийг нөхнө үү (элэгдэл хасагдаагүй дүн)

Тухайн аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн хэмжээг асууж нөхнө. Энд хөрөнгийн элэгдэл хасагдаагүй дүнг бичнэ.

1. **Үндсэн хөрөнгө.** Үндсэн хөрөнгийг 2020 оны жилийн эхний үлдэгдэл, нэмэгдсэн, хөрөнгө оруулалт, хасагдсан, оны эцсийн үлдэгдлийг элэгдэл хасагдаагүй дүнгээр мянган төгрөгөөр тооцож нөхнө $\text{мөр1} = \text{мөр}(2+3+8+9+14+17+18)$.

Үндсэн хөрөнгө орон сууцны барилга, бусад барилга байгууламж, дуусаагүй барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж, өсөж үрждэг биологийн хөрөнгөөс бүрдэнэ.

- 1.1. **Орон сууцны барилгад** аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, хүн амьдардаг завь, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг хамруулна.

- 1.2. **Бусад барилга, байгууламж** нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газрын сайжруулалтаас бүрдэнэ $\text{мөр3} = \text{мөр}(4+5+7)$.

- 1.2.1. **Орон сууцны бус барилгад** үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, үзвэр, зочид буудал, зоогийн газар, агуулах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга орно.

- 1.2.2. **Бусад байгууламжид** гудамж, онгоцны нисэх зурвас, төмөр зам, гүүр, авто зам, хурдны зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, хол зайд дамжуулах хоолой, холбооны болон дулаан, цахилгаан дамжуулах шугам, кабель болон бусад шугам, уул уурхайн үйлдвэрийн байгууламж, спорт, амралтын байгууламж, цахилгаан станц, далан, худаг, усан сан хамрагдана.

1.2.2.1. Авто замыг бусад байгууламжаас тусад нь салгах ба үүнд авто зам, хурдны зам багтаана.

1.2.3. Газар, хөрс сайжруулалт нь газрын чанар, хэмжээ, бүтээмж, үр өгөөжийг сайжруулах болон хөрс муудахаас сэргийлэхэд чиглэсэн газрын цэвэрлэгээ, дүрслэл, худаг гаргах, цооног гаргах зэргийг хамруулна.

1.3. Дуусаагүй барилга байгууламжид хараахан дуусаагүй барилга байгууламжийг хамааруулж ойлгоно.

1.4. Машин, тоног төхөөрөмж нь бүх төрлийн тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, уул уурхай, үйлдвэрлэл, барилга, цахилгаан тоног төхөөрөмжөөс бүрдэнэ мөр 9 =мөр $(10\div13)$.

1.4.1. Тээврийн хэрэгсэл нь хүн, амьтан, бүтээгдэхүүн, эд зүйлсийг шилжүүлэн зөөх

- суудлын автомашин, ачааны автомашин, тусгай зориулалтын машин
- төмөр замын зүтгүүр, ачааны болон суудлын вагон
- нисэх онгоц, нисдэг тэрэг, сансрын хөлөг, хийн бөмбөлөг, дирижабль
- усан онгоц, аяны болон спортын завь
- мотоцикл, унадаг дугуй, ердийн хөсөг зэрэг байна.

1.4.2. Компьютер, мэдээлэл, холбооны тоног төхөөрөмжид цахим удирдлагыг ашигладаг механизм болон тэдгээрийн цахим эд, анги, компьютер, дагалдах хэрэгсэл, алсын холбооны төхөөрөмж хамаарна.

1.4.3. Тавилга, эд хогшилд албан хэрэгцээний бүх тавилгыг хамруулах бөгөөд тухайлбал, албан тасалгааны зориулалттай тавилга, ширээ, шүүгээ, сандал, бусад зориулалтын тавилга, тэдгээрийн эд анги багтана.

1.4.4. Бусад машин, тоног төхөөрөмжид ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; цахилгаан машин, аппарат; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилт, хараазүйн багаж; уурын халаалтын генератор зэрэг орно.

1.5. Биологийн өсөж үрждэг хөрөнгөд байгууллагын шууд эзэмшилд байгаа үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, олон наст ургамлыг хамруулна. Тухайлбал, сүү, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. **Тухайн жилийн бойжуулсан төлийг дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэнэ.**

1.6. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөцийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон дараах зардлуудаас бүрдэнэ.

1. Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл, тухайлбал, хуульч, архитектор, байцаагч, инженер болон хөрөнгийн үнэлгээчид төлөх үйлчилгээний шимтгэл гэх мэт;
2. Худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал;

3. Хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар;
4. Хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар;
5. Худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал;
6. Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

1.7. Оюуны өмчийн бүтээгдэхүүн

Оюуны өмчийн бүтээгдэхүүн нь биет бус, хүний оюуны хүчин чармайлтаар буй болж, нэг буюу түүнээс дээш жилээр ашиглагддаг, өөрийн эзэмшигчдэдээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгодог хөрөнгө байна. Оюуны өмчийн бүтээгдэхүүнийг дараах байдлаар ангилна $\text{мөр}18 = \text{мөр}(19 + 22 + 25 + 26)$. Үүнд:

1.7.1. Судалгаа хөгжүүлэлтийн ажилд хүний мэдлэг оюуныг дээшлүүлэхийн тулд системтэйгээр гүйцэтгэсэн бүтээлч ажлын зардлаас бүрдэх ба үүнд хүний оюун мэдлэг, соёл-боловсрол, нийгэмшил, шинэ зүйлийг нээх мэдлэгийн хэрэглээ зэрэг багтах бөгөөд харин хүмүүн капиталыг хамруулахгүй. **Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зах зээлийн үнийг** шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.

- **Инновацад** бусдаар гүйцэтгүүлсэн/ худалдаж авсан судалгаа хөгжүүлэлтийн ажил, програм хангамж, мэдээллийн өгөгдлийн сан, худалдаж авсан биет хөрөнгө зэргийг хамруулах ба зах зээлийн үнийг шууд тогтоох боломжгүй тохиолдолд зардлын нийлбэрээр нь үнэлнэ.
- **Геологи хайгуулын ажил болон үнэлгээнд** газрын тос, байгалийн хийн болон бусад баялгийн хайгуулын зардал болон нээсэн орд дээр хийх үнэлгээний зардлыг оруулна. Өөрөөр хайгуулын лицензийн өмнөх болох лицензийн зөвшөөрөл авах зардал, үнэлгээ хийлгэх зардал, өрөмдлөг хийх, цооног гаргах зардал, агаарын болон бусад судалгааны зардал, тээврийн зардал гэх мэт туршилтыг гүйцэтгэх зардал багтана.
- **Програм хангамж, мэдээллийн санд** худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд зориулан боловсруулсан програм хангамж, системийн болон хэрэглээний програм хангамж, томоохон мэдээллийн баазыг хамруулна. **Хэрэв худалдан авсан бол** програм хангамж, мэдээллийн баазыг худалдан авсан үнээр, **өөрсдөө боловсруулсан бол** үндсэн үнээр, хэрэв энэ үнээр үнэлэх боломжгүй тохиолдолд **үйлдвэрлэлийн зардлаар** үнэлнэ. Програм хангамж, мэдээллийн санг тус тусад нь салгаж бүртгэнэ $\text{мөр}22 = \text{мөр}(23 + 24)$.
- **Утга зохиол, урлагийн эх бүтээл** нь кино, дуу бичлэг, гар бичмэл, бичлэг, загвар, урлагийн тоглолт, радио, телевизийн хөтөлбөр, хөгжмийн тоглолт, спортын үйл ажиллагаа, утга зохиол, урлагийн бүтээлийг бичсэн хуурцаг зэрэг байх ба энд өөрийн бүтээсэн эх бүтээл багтана.
- **Оюуны өмчийн бусад хөрөнгө** дээрх ангилалд ороогүй хөрөнгийг хамруулна. Тухайлбал, техник эдийн засгийн үндэслэл

2. Материаллаг эргэлтийн хөрөнгө нь тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө бөгөөд

үүнд: түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн орно.

2.1.Түүхий эд, материал, сэлбэг хэрэгсэлд дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөсөн бүтээгдэхүүн орно. Үйлдвэрлэлд ашиглагддаг алт, үнэт металл энд хамрагдана.

2.2.Хангамжийн материал нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд завсрын орцоор ашиглагдахаас бусад бараа материал байна. Тухайлбал, хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл

2.3.Дуусаагүй үйлдвэрлэл нь аж ахуйн нэгж байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ мөр $35=мөр(36÷38)$.

2.3.1. Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд хараахан бүрэн боловсорч, өсөж гүйцээгүй байгаа үйлдвэрлэлээс байх бөгөөд энд тухайн жилд бойжуулсан төлийг оруулна. Тухайлбал, махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана.

2.3.2. Дуусаагүй бусад хөрөнгийн үйлдвэрлэлд өсөж үрждэг биологийн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл болон дуусаагүй барилга байгууламжаас бусад дуусаагүй үйлдвэрлэлийг хамруулна.

2.4. Бэлэн бүтээгдэхүүнд хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. Өөрөөр хэлбэл бэлэн бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд бүртгэгдэнэ. Тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд сүү, цагаан идээ; мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд хиа, махан консерв зэрэг; алт зэсийн олборлолт эрхэлдэг бол бэлэн бүтээгдэхүүнд алт, зэсийг бүртгэнэ.

2.5. Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын борлуулах зорилгоор худалдан авсан бараа орно.

Аж ахуйн нэгжийн дахин борлуулахаар худалдаж авсан хөрөнгө, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нь тухайн байгууллагын үндсэн хөрөнгө бус бараа материал учир энд тусгагдана.

3. Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь үйлдвэрлэгдсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, худалдан борлуулахгүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй байх магадлалаар барьцааны зориулалтаар эзэмшдэг хөрөнгө байна мөр $35=мөр(36÷38)$.

3.1. Үнэт металл, үнэт чулуу нь худалдан борлуулахгүй, өөрийн үйлдвэрлэлд орц байдлаар ашиглахгүй, мөнгөжүүлсэн алт болон хуваарилагдаагүй металлын дансны хэлбэрт байгаа санхүүгийн хөрөнгөөр хадгалаагүй үнэт металл болон үнэт чулуу байна.

3.2. Эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл нь уран зураг, уран баримал, гар урлалын бүтээл зэрэг түүх, дурсгалын болон урлагийн бүтээл байна. Мөн музейн үзмэр нь энд орно.

3.3. Бусад үнэт зүйлсэд маркийн цуглуулга, зоос, шаазан эдлэл, ном зэрэг үнэ цэнэ бүхий зүйлс болон гоёлын зүйлс, засаж хэлбэрт оруулсан үнэт чулуу, тодорхой үнэ бүхий металл зэргийг оруулна.

4. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө

Үйлдвэрлэгдэх хөрөнгө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болдоггүй санхүүгийн бус хөрөнгө юм. Эдгээр хөрөнгийг сайжруулахтай холбоотой, уг хөрөнгөөс тусад нь салгаж тооцох боломжгүй томоохон ажлын зардлыг мөн хамруулна.

2.2 Байгалийн нөөц баялагт газар, эрдэс баялаг, ашигт малтмал, эрчим хүчний нөөц, биологийн нөхөн сэргээгдэхгүй нөөц, усны нөөц, бусад баялаг багтана.

2.3 Гүүдвилл болон маркетингийн хөрөнгө – Үйлдвэрийн газрыг худалдан авагч нь тухайн үйлдвэрийн тогтоогдсон цэвэр өртөг болон дансанд тусгасан үнээс илүү төлбөр төлөхөд бэлэн байдаг. Тогтоогдсон цэвэр өртгөөс илүү давсан хэсгийг гүүдвилл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь байгууллагын бүтэц, ажиллах хүч, удирдлага, байгууллагын соёл, түгээлтийн сүлжээ зэрэг зүйлүүдээс хамаарна. Гүүдвилл нь тухайн хөрөнгөөсөө тусдаа үнэлэгдэхгүй. Маркетингийн хөрөнгө нь брэндийн нэр, худалдааны тэмдэг, лого, худалдааны шошго, эзэмшигчийн нэр зэргээс бүрдэнэ.

- **Шинэ бүтээл** гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.
- **Бүтээгдэхүүний загвар** гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг ойлгоно.
- **Ашигтай загвар** гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.
- **Барааны тэмдэг** гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг ойлгоно.

2.4 Бусад хөрөнгө буюу гэрээ, түрээс, лицензэд лизингийн үйл ажиллагааны гэрээ, байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл, тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл зэргийг оруулна.

Хөрөнгийн үзүүлэлтийг нөхөж бичихдээ 2020 оны дүнг 1-р баганад оны эхний дүнг, 2-р баганад оны эхнээс нэмэгдсэн дүнг, 3-р баганад шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтыг, оны эхнээс хасагдсан дүнг 4-р баганад, эцсийн дүнг 5-р баганад харуулна.

“БҮГД” гэсэн мөрөнд үндсэн хөрөнгө, материаллаг эргэлтийн хөрөнгө, үнэт зүйлийн нийлбэр дүн бичигдэнэ мөр48=мөр(1+27+35+39).

4.7. Санхүүжилтийн эх үүсвэр, 2020 оны дүнгээр

Төрийн бус байгууллагын 2020 оны санхүүгийн эх үүсвэрийг гишүүдийн татвар, хандив, олон улсын байгууллагын төслийн санхүүжилт, засгийн газрын санхүүжилт, тусламж, банкны зээл болон бусад эх үүсвэрийг оруулан мянган төгрөгөөр илэрхийлж бичнэ. Бусад эх үүсвэрийн төрлийг тоологч асууж бичнэ.

4.8.Хөрөнгийн зарцуулалт, 2020 оны дүнгээр

Төрийн бус байгууллагын 2020 оны хөрөнгийн зарцуулалтыг жилийн эцсийн байдлаар тооцож нөхнө. Хөрөнгийн зарцуулалтын бусдад олгосон хандив, тусламж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, сургалт, семинар, сурталчилгааны зардал болон тэдгээрээс бусад зардлыг бусад зардалд оруулан мянган төгрөгөөр нөхөж бичнэ. Бусад зардлыг дэлгэрэнгүй бичиж нөхнө.

5. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

5.1. Танай байгууллага салбар, нэгж, төлөөлөгчийн газартай юу?

Тухайн байгууллага салбар, нэгж, төлөөлөгчийн газартай эсэхийг асууж тохирох асуултыг сонгоно. Хэрэв “Үгүй” буюу “2” гэсэн асуултыг сонговол асуулгыг дуусгана.

5.2. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын хаягийн мэдээлэл

Тухайн байгууллагын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө. Салбар, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичих ба баганад үзүүлэлтүүдийг нөхнө. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, хаягийн мэдээлэл, утасны дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноо гэсэн үзүүлэлт байна. Хаягийн хэсэгт аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хорооны нэрийг нөхөх ба “Хаяг” гэсэн баганад гудамж, хорооллын нэр, байр/ байшин, хашаа/хаалганы дугаар, үйл ажиллагаа эхэлсэн огноог нөхнө.

5.3. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, 2020 оны дүнгээр

Тухайн байгууллагын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө. Салбар, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичнэ. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, үйл ажиллагааны чиглэлийн нэр, код, ажиллагчдын тоо, үүнээс эмэгтэй, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны нийт орлого /мянган төгрөг/, санхүүгийн тайлан гаргадаг эсэх гэсэн үзүүлэлтүүд байна. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нэрийг дэлгэрэнгүй нөхнө. Жишээ нь: Дэлхийн зөн, Ротари клубийн тэр салбар гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номоос харж нийслэл, аймгийн тооллогын комиссын гишүүн кодолно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, үүнээс эмэгтэй, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны нийт орлогыг мянган төгрөгөөр нөхөж, мэдээ, тайлан

гаргадаг эсэхийг тодруулж тохирох хариултыг сонгоно. Салбаруудын 2-с 5-р баганын үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогын дүнг БҮГД мөрөнд нэгтгэнэ.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө. Мэдээлэл өгсөн хүнд талархал илэрхийлнэ.

САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР ААНТ-4

Тоологч тооллогын асуулгын хуудсыг Улсын бүртгэлийн гэрчилгээ, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг үндэслэн асуултын дагуу нөхөж аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны тооллогын комисст хүлээлгэж өгнө.

Энэхүү маягтаар толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж байгаа **салбарууд** болон тэдгээрийн **нэгжийг** хамруулна / Монгол улсын Компанийн тухай” хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэг/.

Нэгж гэдэг нь салбар болон төлөөлөгчийн газар болж чадахгүй, үндсэн аж ахуйн нэгжээс өөр газар үйл ажиллагаа явуулж буй (уурхай, мод бэлтгэл гэх мэт) нэгжийг ойлгоно.

Салбар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан толгой компанийн нэрийн өмнөөс явуулах ба толгой компани нь өөрийн салбар компанийн хүлээх үүргийг хариуцна.

Төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

1. ХЯНАЛТЫН ХЭСЭГ

Тоологч/шалгагчийн нэр, код: Тоологч/шалгагч өөрийн нэрийг эцэг/эхийн нэрийн эхний үсгийн хамт бичиж, тоологч бүрт тооллогын комиссоос олгосон дугаарыг нөхнө. Тоологч/шалгагч дугаараа нөхөхдөө “код” баганын харгалзах нүдэнд байрлуулахад анхаарна. Хэрэв 2 эсвэл 1 оронтой дугаартай бол “001”, “011” гэж өмнөх оронгийн нүдэнд “0” тавьж гүйцээж бичнэ.

2. НЭРИЙН ХЭСЭГ

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын регистрийн дугаар, нэр, үйл ажиллагаа эхэлсэн огноо, толгой аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн нөхнө.

3. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар, цахим шуудангийн хаяг (имэйл), цахим /веб/ хуудасны нэрийг бичиж өгнө.

Кодлогч тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхөх бөгөөд салбар, нэгж, төлөөлөгчийн газрын оршин байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн нэр нь хавсралтад байгаа гудамж, хороолол, бүсчлэлийн жагсаалтад байхгүй тохиолдолд ҮСХ-ны ААНБ-ын тооллогын комиссын гишүүдтэй холбогдож кодолно.

4. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ДАРГА/ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын дарга/захирлын овог, нэр, регистрийн дугаар, суурин утас, гар утасны дугаарыг асууж нөхнө.

5. ХАРЬААЛЛЫН ХЭЛБЭРИЙГ ТОДОРХОЙЛНО УУ

Тухайн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын харьяаллын хэлбэрийг асууж тохирох асуултыг сонгоно. Хэрэв “салбар” бол “1”-г, “төлөөлөгчийн газар” бол “2”-г, “нэгж, хороо, үүр” бол “3”-г сонгоно.

Монгол улсын Компанийн тухай” хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар “Салбар” нь толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

Нэгж – салбар болон төлөөлөгчийн газар болж чадахгүй, үндсэн аж ахуйн нэгжээс өөр газар үйл ажиллагаа явуулж буй (уурхай, мод бэлтгэл гэх мэт) нэгжийг хамруулж ойлгоно.

Салбар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан толгой компанийн нэрийн өмнөөс явуулах ба толгой компани нь өөрийн салбар компанийн хүлээх үүргийг хариуцна.

Төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

6. ТАНАЙХ МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАДАГ УУ?

Тухайн салбар, нэгж, хороо, үүр, төлөөлөгчийн газар мэдээ, тайлан гаргадаг эсэхийг асууж тохирох асуултыг сонгоно. Хэрэв “Тийм” бол “1”-г, “Үгүй” бол “2”-г сонгоно.

7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, 2020 ОНЫ ДҮНГЭЭР

Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 2020 оны дүнгээр асууж нөхнө. Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны чиглэлийн нэр, код, ажиллагчдын тоо, үүнээс эмэгтэй, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлого /мянган төгрөг/ гэсэн үзүүлэлтүүд байна. Салбар, нэгж, хороо, үүр, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны нэрийг дэлгэрэнгүй нөхнө. Жишээ нь: компьютерын сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааг ихээс бага руу хуваарилах аргаар (Top-down method) тодорхойлно. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл бүрийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн эсвэл борлуулалтын орлоготой нэгжийн үйл ажиллагааг ихээс бага руу хуваарилах аргаар үндсэн үйл ажиллагааг тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номоос харж нийслэл, аймгийн тооллогын комиссын гишүүн кодолно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогыг нөхнө.

Ажиллагчдын тоо нь 2020 оны дундаж ажиллагчдын тоо байх ба үүнээс эмэгтэй ажиллагчдын тоог салгаж нөхнө.

Тухайн нэгжээс 2020 онд ажиллагчдаа олгосон цалин, түүнтэй адилтгах зардлын хэмжээг мянган төгрөгөөр илэрхийлж бичнэ. Цалинд үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал оруулна.

***Үндсэн цалин** нь тухайн ажил, албан тушаалын цалин буюу тарифт цалин юм.*

***Нэмэгдэл** нь ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл юм.*

***Нэмэгдэл хөлс** нь ажилтанд үндсэн цалин дээр нь үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан зэрэгт нь үндсэн цалингаас тооцон олгож буй нэмэгдэл хөлс юм.*

Үйл ажиллагааны орлогод барааны хувьд уг барааг бусдын өмчлөх эрхэд төлбөртэйгөөр шилжүүлэх, ажил, үйлчилгээний хувьд уг ажил, үйлчилгээг төлбөртэйгөөр гүйцэтгэсэн орлогыг оруулна. Үйл ажиллагааны орлогыг мянган төгрөгөөр илэрхийлж бичнэ.

8. САЛБАР, НЭГЖ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, 2020 ОНЫ ДҮНГЭЭР

Тухайн байгууллагын салбар, нэгж, төлөөлөгчийн газрын мэдээллийг асууж нөхнө. Салбар, төлөөлөгчийн газрыг мөрөнд жагсаан бичих ба баганад үзүүлэлтүүдийг нөхнө. Баганад салбарын регистрийн дугаар, нэр, хаягийн мэдээлэл, ажиллагчдын тоо, үүнээс эмэгтэй, цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогыг мянган төгрөгөөр нөхөж, мэдээ, тайлан гаргадаг эсэхийг асууж тохирох хариултыг сонгоно.

Салбаруудын 1-ээс 4-р баганын үзүүлэлтүүд буюу ажиллагчдын тоо, тэдгээрийн цалин, түүнтэй адилтгах зардал, үйл ажиллагааны орлогын дүнг БҮГД мөрөнд нэтгэнэ.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж, аж ахуйн нэгж, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө. Мэдээлэл өгсөн хүнд талархал илэрхийлнэ.

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ТООЛЛОГЫН АСУУЛГА НӨХӨХ ЗААВАР ААНТ-5

Энэхүү маягтаар ашиг олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй эрхэлж байгаа хувиараа **хөдөлмөр эрхлэгч иргэн/аж ахуйг** хамруулна. Эдгээр иргэд нь ямар нэгэн бүрэн хөтөлсөн данс тооцоогүй, албан ёсны бүртгэлийг дагаж мөрддөггүй буюу аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдаагүй байдаг (ХСОУ-ын 15 бага хурлын тогтоолын заалт 5, 6, 7)¹.

Харин малчид болон бичил уурхай эрхлэгчдийг хамруулахгүй. Учир нь малчдыг ҮСХ-ноос жил бүр зохион байгуулдаг “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ын мэдээллийн сангаас, бичил уурхай эрхлэгчдийг “Бичил уурхайн судалгаа”-ны дүнгээс авч энэ удаагийн тооллогын дүнтэй нэгтгэн Монгол улсын нийт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

1.1. Нэрийн хэсэг

¹ ҮСХ, Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, 2019 он

Ажил, үйлчилгээ хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эцэг/ эхийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаарыг асууж бичнэ.

1.2. Үйл ажиллагаа явуулж буй хаяг

Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байшин, байр, хашаа, хаалганы дугаар, утасны дугаар зэргийг бичнэ. Кодлогч тэдгээрийн кодыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхөх ба хэрэв тухайн аж ахуйн нэгж оршин байгаа гудамж, хороолол нь хавсралтад байгаа гудамж, хороолол жагсаалтад байхгүй тохиолдолд ҮСХ-той холбогдож кодолно.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Үйл ажиллагааны чиглэлийг бичнэ үү

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

2.2. Үндсэн үйл ажиллагаагаа эхэлсэн огноо

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үндсэн үйл ажиллагааг эхэлсэн огноог нөхнө.

2.3. Хоёрдогч үйл ажиллагааны чиглэлийг бичнэ үү

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хоёрдох үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ.

2.4. Хоёрдогч үйл ажиллагаагаа эхэлсэн огноо

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хоёрдох үйл ажиллагааг эхэлсэн огноог нөхнө.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаа бүрийг хамгийн их нэмэгдэл өртөг үйлдвэрлэсэн эсвэл борлуулалтын өндөр орлоготой үйл ажиллагааг бага руу нь хуваарилах буюу үйл ажиллагааг ихээс бага руу хуваарилах аргаар (Top-down method) тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”(ISIC- 4.0 хувилбар)-ын дагуу номоос харж нийслэл, аймгийн тооллогын комиссын гишүүн кодолно.

2.5. Та сүүлийн 12 сарын ажиллагчдын дундаж тоог хэлнэ үү

Сүүлийн 12 сард ажилласан ажиллагчдын дундаж тоог тохирох хүснэгтэд нөхнө.

2.6. Сүүлийн 12 сарын хэдэн сард нь таны орлого өндөр, бага болон хэвийн байдаг вэ? Энэ үед сард дунджаар ямар хэмжээний борлуулалтын орлого олдог вэ?

Сүүлийн 12 сарын хэдэн сард нь тухайн аж ахуйн орлого өндөр, бага болон хэвийн байдгийг асууж тохирох саруудыг бөглөж, дундаж борлуулалтын орлогыг мянган төгрөгөөр бичнэ. Мөн үйл ажиллагаа явуулаагүй сарыг бичих ба нийт сарын нийлбэр нь 12 байна.

2.7. Та бизнесийн үйл ажиллагаагаа хаана явуулдаг вэ?

Бизнесийн үйл ажиллагаагаа хаана явуулдгийг асууж дараах хариултаас тохирохыг сонгоно. Бусад гэсэн хариултыг сонговол хаана явуулдгийг тодорхойлж бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

1. Тогтсон ажлын байргүй:

- Гудамжинд/ хөдөлгөөнтэй
- Зам дагуу түр хугацаагаар байрлуулсан цэгт
- Тээврийн хэрэгсэл
- Интернэт худалдаа
- Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн гэрт
- Гэртээ, тусгай тоног төхөөрөмжгүй
- Гэртээ, тусгай тоног төхөөрөмжтэй
- Зах дээр жижиг саравчинд
- Хогийн цэг дээр
- Үзвэрийн газарт
- Бусад /бичих/

2. Тогтсон ажлын байртай:

- Дэлгүүр, зах, үйлчилгээний төвд
- Засварын газар
- Гуанз, зочид буудал
- Авто зогсоол
- Бусад /бичих/

2.8. Та бизнесийн үйл ажиллагаагаа дэмжүүлэх, өргөжүүлэх, хамгаалах зорилгоор холбоо, нэгдэлд нэгдэж, зохион байгуулалтад орсон уу?

Бизнесийн үйл ажиллагаагаа дэмжүүлэх, өргөжүүлэх хамгаалах зорилгоор холбоо, нэгдэлд нэгдэж, зохион байгуулалтад орсон эсэхийг асууж, холбогдох хариултыг сонгоно.

2.9. Та бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байрныхаа эзэмшлийн хэлбэрийг тодорхойлно уу

Бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа байрны эзэмшлийн хэлбэрийг өөрийн эзэмшлийн, түрээсийн, гэртээ, дундын оффис, бусад гэсэн хэлбэрээс тохирох хариултыг сонгоно. Түрээсийн гэсэн хариултыг сонговол дараагийн асуултыг асуух ба бусад тохиолдолд асуулт 2.11-т шилжинэ.

2.10. Түрээслүүлэгчийн төрлийг хэлнэ үү

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа байрны түрээслүүлэгчийн төрлийг асууж холбогдох хариултыг сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

2.11. Танай бизнесийн үйл ажиллагаа өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад 2021 эхний 9 сард хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгчээс бизнесийн үйл ажиллагаа нь өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад өөрчлөгдсөн эсэхийг нэг бүрчлэн дараах асуултаар асууна.

- Үйлдвэрлэл/ үйлчилгээний хэмжээ
- Орлого
- Алдагдал
- Хэрэглэгчдийн захиалга
- Экспортын хэмжээ
- Бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл
- Ажиллагчдын тоо

Хэрэв **Тийм** гэж хариулсан бол "1"-г сонгоод өссөн, буурсан эсэхийг асууж, хариултын кодоос тохирох хариултыг сонгож нөхнө. Харин **Үгүй** бол "2"-г сонгоно.

1. 10 хүртэл хувь
2. 10-19 хувь
3. 20-49 хувь
4. 50 ба түүнээс дээш хувь

2.12. Танай бизнесийн үйл ажиллагааны зардал өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад 2021 оны эхний 9 сард хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний дараах үндсэн зардал өмнөх 2020 оны эхний 9 сартай харьцуулахад өөрчлөгдсөн эсэхийг дараах зардлын төрөл бүрээр асууна.

- Түүхий эд, материалын зардал
- Цалингийн зардал, НДШ
- Татвар, төлбөр, хураамж
- Маркетинг, зар сурталчилгааны зардал
- Зээлийн хүүгийн зардал
- Түрээсийн зардал
- Тээвэр, шатахууны зардал
- Шуудан холбооны зардал
- Тусгай зөвшөөрөл, лицензийн зардал
- Бусад зардал

Хэрэв **Тийм** гэж хариулсан бол “1”-г сонгоод өссөн, буурсан эсэхийг асууж, хариултын кодоос тохирох хариултыг сонгож нөхнө. Харин **Үгүй** бол “2”-г сонгоно.

1. 1-10 хүртэл хувь
2. 10-19 хувь
3. 20-49 хувь
4. 50 ба түүнээс дээш хувь

2.13. Цаашид танай бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистой вэ?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгчээс цаашид бизнесийг хөгжүүлэхэд төрийн бодлогын түвшинд нэн тэргүүнд ямар арга хэмжээ авбал зохистойг асууж дараах хариултаас сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой бөгөөд **хамгийн чухал гурван хариултыг** холбогдох нүдэнд эрэмбэлж нөхнө.

- Авилга, хүнд суртлыг бууруулах
- Албан зөвшөөрлийн хураамжийн хэмжээг бууруулах
- Банк, санхүүгийн байгууллагын зээлийн хүүг бууруулах
- Дэд бүтцийг сайжруулах
- Зөвшөөрөл /лиценз/-ийн тоог багасгах
- НДШ-ийн иргэдээс авах хувь хэмжээг бууруулах
- Төрөөс хийгдэж буй хяналт шалгалтын тоог бууруулах
- Төрөөс хийгдэж буй хяналт шалгалтын давхардлыг арилгах
- Татварын таатай орчин бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох
- Үндэсний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжих
- Хууль, эрх зүйн орчныг сайжруулах
- Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломж бүрдүүлэх
- Бусад /бичих/
- Мэдэхгүй

2.14. Таны бизнесийн үйл ажиллагаа Ковид-19 цар тахлын улмаас доголдсон уу?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгч үйл ажиллагаа Ковид-19 цар тахлын улмаас доголдсон эсэхийг асууж, тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 2.16-д шилжинэ.

2.15. Үйл ажиллагаа доголдсон шалтгаанаа хэлнэ үү

Тухайн аж ахуйн бизнесийн үйл ажиллагаа Ковид-19 цар тахлын улмаас доголдсон шалтгааныг тодруулж, дараах хариултаас сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой.

- Төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохистой байгаагүй
- Үйлчлүүлэгчдийн тоо буурсан
- Бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлт зогссон
- Ажил олгогч, ажилтны эрүүл мэндийн байдал муудсан
- Хэрэглэгчийн худалдан авах чадвар буурсан
- Ажиллах хүчний хомсдол үүссэн
- Бусад /бичих/

Хэрэв бусад нэр заагдаагүй шалтгааныг сонгосон тохиолдолд тодорхойлж бичихийг анхаарна уу.

2.16. Танай бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээл юу вэ?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгч бизнест хатуу хөл хориотой холбоотой үүссэн хүндрэл бэрхшээлийг тодруулж, дараах хариултаас сонгоно. Асуулга нь хариултын олон сонголттой бөгөөд **хамгийн чухал гурван хариултыг** холбогдох нүдэнд эрэмбэлж нөхнө.

- Ажлын байраа хадгалах
- Ажиллагчдын цалин тавих
- Төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал
- Түүхий эдийн олдоц
- Зээлийн эргэн төлөлт
- Түрээсийн төлбөр
- Гадаад түншийн гэрээний үүрэг биелүүлэхгүй байх, гэрээ цуцлагдах
- Үйл ажиллагааны зөвшөөрөл авах процесс
- Тээврийн хэрэгслийн хязгаарлалт
- Дэлгүүр, үйлчилгээний байгууллагын цагийн хязгаарлалт
- Халдвар, хамгааллын хувцас, хэрэглэл
- Бусад /бичих/

Хэрэв бусад нэр заагдаагүй хүндрэл бэрхшээлийг сонгосон тохиолдолд тодорхойлж бичихийг анхаарна.

2.17. Танай бизнес өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах хугацааг хэлнэ үү

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгчээс өөрийн нөөцөөр ажлын байраа цаашид хадгалах боломжтой хугацааг асууж дараах хариултаас сонгоно.

- 1 сар хүртэл
- 1-3 сар
- 4-6 сар
- 7 сар-1 жил
- 1 жилээс дээш

2.18. Таны бизнес зээлтэй юу?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгч зээлтэй эсэхийг асууж, тохирох хариултыг сонгоно. “Үгүй” гэж хариулсан тохиолдолд асуулт 2.20-т шилжинэ. Танай аж ахуйн нэгж зээлтэй юу гэсэн асуулгад 2020 оноос өмнө авсан зээл хамаарна.

2.19. Таны бизнесийн зээлийн эх үүсвэр юу вэ?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгч зээлээ ямар эх үүсвэрээс авсныг асууна. Банкны зээл, ХЗХ, ББСБ, иргэн, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан зэрэг бүх эх үүсвэрийг хамруулна. Дээр дурдсанаас бусад эх үүсвэрийг “Бусад” гэдэгт дэлгэрэнгүй бичнэ. Асуулга нь хариултын олон сонголттой.

2.20. Таны бизнесийн үйл ажиллагаа и-баримтын системд холбогдсон уу?

Тухайн хувиараа хөдөлмөр эрхлэгчээс и-баримтын системд холбогдсон эсэхийг асууж “**Тийм**” гэж хариулсан бол “1” гэсэн кодыг, “**Үгүй**” гэж хариулсан бол “2” гэсэн кодыг сонгоод асуулгыг дуусгана.

Тоологч асуулгын хуудсыг бүрэн асууж дууссаны дараа тухайн асуулга өгсөн хүний албан тушаал, гарын үсгийг зуруулж баталгаажуулна.

Асуулгыг дуусаад асуулга авсан он, сар, өдрийг нөхнө.

Мэдээлэл өгсөн хүнд талархал илэрхийлнэ.

ХАВСРАЛТ. АНГИЛАЛ, КОД

1. Хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийн ангилал

Дэд код	Төрөл, хэлбэр
10	Хувьцаат компани
11	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
13	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /төрийн өмчит/
14	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /орон нутгийн өмчит/
20	Бүх гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
21	Зарим гишүүн нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
22	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
23	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /Гадаадын хөрөнгө оруулалттай/
30	Хоршоо
68	Улсын төсөвт үйлдвэрийн газар
69	Төрийн байгууллага, албан газар
71	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
72	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
74	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага
75	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд
76	Үндэсний хүмүүнлэгийн байгууллага
77	Боловсрол сургалтын байгууллага
78	Хэвлэл мэдээллийн байгууллага
80	Шашны байгууллага
81	Сан
82	Улс төрийн нам
84	Олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар

2. Хуулийн этгээдийн өмчийн хэлбэрийн ангилал

Код	Өмчийн хэлбэр
11	Төрийн өмчийн, 100 хувь
12	Төрийн өмчийн оролцоотой
13	Төрийн өмчийн, гадаадтай хамтарсан
21	Орон нутгийн өмчийн, 100 хувь
22	Орон нутгийн өмчийн оролцоотой
23	Орон нутгийн өмчийн, гадаадтай хамтарсан
31	Шашны өмчийн
32	Шашны өмчийн оролцоотой
33	Шашны өмчийн, гадаадтай хамтарсан
41	Олон нийтийн өмчийн
42	Олон нийтийн оролцоотой
43	Олон нийтийн, гадаадтай хамтарсан
51	Монгол Улсын иргэний өмч
52	Гадаад улсын иргэний өмч
53	Гадаад улсын иргэнтэй хамтарсан

3. Үүсгэн байгуулагдсан нөхцлийн ангилал

Код	Үүсгэн байгуулагдсан нөхцөл
01	Шинээр байгуулагдсан
02	Нийлүүлсэн
03	Нэгдсэн
04	Хуваасан
05	Тусгаарлагдсан
06	Өөрчлөгдсөн
07	Бусад

4. Аймаг, нийслэлийн код

Аймаг, нийслэлийн код	Аймаг, нийслэлийн нэр
11	Улаанбаатар
21	Дорнод
22	Сүхбаатар
23	Хэнтий
41	Төв
42	Говьсүмбэр
43	Сэлэнгэ
44	Дорноговь
45	Дархан-Уул
46	Өмнөговь
48	Дундговь
61	Орхон
62	Өвөрхангай
63	Булган
64	Баянхонгор
65	Архангай
67	Хөвсгөл
81	Завхан
82	Говь-Алтай
83	Баян-Өлгий
84	Ховд
85	Увс

5. Улс, орны жагсаалт

Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар
Монгол Улс	001	Америкын Самао	041	Гвиней	081
Оросын Холбооны Улс	002	Аруба	042	Гваделоир	082
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	003	Азарбажан	043	Экваторын Гунее	083
Бүгд Найрамдах Солонгос Улс	004	Босни	044	Грек	084
Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс	005	Барбадос	045	Гуатимал	085
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	006	Бангладеш	046	Гуам	086
Япон Улс	007	Бахрайн	047	Гвиней Биссау	087
Америкийн Нэгдсэн Улс	008	Бурунди	048	Гайана	088
Бүгд Найрамдах Турк Улс	009	Бенин	049	Тайвань	089
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	010	Бермуда	050	Неард ан МкДоналд аралууд	090
Бүгд Найрамдах Болгар Улс	011	Бруней	051	Гондурас	091
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	012	Боливи	052	Кроатиа	092
Канад Улс	013	Джибути	053	Хайти	093
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс	014	Дани	054	Гонконг	094
Бүгд Найрамдах Итали Улс	015	Алжир	055	Индонез	095
Бүгд Найрамдах Франц Улс	016	Доменикын бигд найрамдах	056	Ирланд	096
Бүгд Найрамдах Пакистан Улс	017	Эквадор	057	Израйл	097
Холбооны Бүгд Найрамдах Югослав Улс	018	Эстони	058	Эрийн арал	098
Бүгд Найрамдах Филиппин Улс	019	Египет	059	Буриад	099
Бүгд Найрамдах Унгар Улс	020	Вестерн сахар	060	Британийн энэтхэгийн далайн газар	100
Бүгд Найрамдах Чех Улс	021	Испани	061	Ирак	101
Бүгд Найрамдах Словак Улс	022	Этопи	062	Иран	102
Бүгд Найрамдах Австри Улс	023	Бразил	063	Исланд	103
Бүгд Найрамдах Финлянд Улс	024	Бахамас	064	Жерси арал	104
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	025	Бутан	065	Ямайка	105
Австрали Улс	026	Беларус	066	Йордан	106
Бүгд Найрамдах Польш Улс	027	Ботсвана	067	Кения	107

Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар
Бүгд Найрамдах Казакстан Улс	028	Фижи	068	Киргиз	108
Андора	029	Малвинас	069	Камбуж	109
Арабын Нэгдсэн Эмират	030	Макронесиа	070	Крибати	110
Афганистан	031	Фарое арлууд	071	Коморос	111
Антигуа ба Барбуда	032	Гавон	072	Сэйнт Китс энд Невис	112
Ангуила	033	Гренада	073	Кувейт	113
Албани	034	Гүрж	074	Сейман Арал	114
Армен	035	Францын Гунее	075	Ливан	115
Нидерландын антиллес	036	Журнсейн аралууд	076	Сэйнт Луйс	116
Ангол	037	Гхана	077	Лехтенштейн	117
Антарктик	038	Гибралтар	078	Шри Ланка	118
Аргентин	039	Гринланд	079	БНЛибер Улс	119
Асианы арал	040	Гамби	080	Лесотно	120

Улс орны жагсаалтын үргэлжлэл

Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар	Улсын нэр	Дугаар
Литон	121	Португал	166	Ватикан сити стэит	211
